



МОНГОЛЧИЛДОГ БУС
СТАНДАРТЫГ МӨРДӨЖ
ХЭВШЬЕ

С.АМАРСАЙХАН
Монгол Улсын Шадар сайд

5

ҮНДЭСНИЙ ЧАНАРЫН
ЧУУЛГАН

2023 онцлох үйл явдлууд

18

ҮНДСЭН ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ХҮНИЙ НӨӨЦ,
ТЕХНИКИЙН ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ
ЗЭРЭГ АСУУДАЛ ОЛОН БАЙНА

Б.УУГАНБАЯР
Стандарт, хэмжил зүйн газрын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

22

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙ

Нэгдүгээр сар / 2024




УРТЫН
ХЭМЖЛИЙН
ЭТАЛОНЫ
ЛАБОРАТОРИ



Уртын хэмжлийн анхдагч эталон | Иодоор тогтворжуулсан 633 нм долгионы урттай Гелий Неон лазер үүсгэгч

ЗОРИУЛАЛТ, ХЭРЭГЛЭЭ:

- Туузан метр, төмөр шугам
- Нивелирийн рейк
- Лазерметр
- Микрометр
- Штангенбагаж
- Төгсгөлт уртын хэмжүүр
- Электрон тахеометр
- Автомат нивелир зэрэг хэмжих хэрэгслүүдэд шалгалт



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙ

Нэгдүгээр сар / 2024



Монголчилдог бус Стандартыг мөрдөж хэвшье
С.АМАРСАЙХАН
Монгол Улсын Шадар сайд



Үндэсний чанарын чуулган
2023 онцлох үйл явдлууд



Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд тоног төхөөрөмж, хүний нөөц, техникийн чадавхыг нэмэгдүүлэх зэрэг асуудал олон байна
Б.УУГАНБАЯР
Стандарт, хэмжил зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



Халал болон органик хүнсийг баталгаажуулах олон улсын итгэмжлэлийн үнэлгээнд хамрагдаж, гэрчилгээ авсан
В.ГАНЗОРИГ
Бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын газрын дарга



Хүнсний аюулгүй байдлыг хангахын тулд эхлээд аюулгүй үзүүлэлтүүдээ 100 хувь үздэг болох хэрэгтэй
О.НАНДИН-ЭРДЭНЭ
Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн ерөнхий захирал, АУ-ны доктор



Монгол Улс жилдээ 200-250 стандарт баталдаг
Г.ТУЛГАА
Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын дарга

Гарчиг

- 3 Мэндчилгээ
МУ-ын шадар сайд С.Амарсайхан
- 14 "Иргэдэд ээлтэй стандарт" өдөрлөг
2023 онцлох үйл явдлууд
- 16 Стандарт, хэмжил зүйн газрын 100 жилийн ойн баярын хурал боллоо
2023 онцлох үйл явдлууд
- 20 Эрсдэл ба стандарт
2023 онцлох үйл явдлууд
- 28 Стандартын хэрэгжилтийг хангахад хэмжил зүйн үйл ажиллагаа, чадамж үнэтэй хувь нэмэр үзүүлдэг
Д.Нарангэрэл - Хэмжил зүйн бодлогын газрын дарга
- 32 Монгол Улс 11 улсын болон анхдагч эталонтой, Хөгжингүй улс орнууд 600-1000 гаруй эталонтой байна
Д.Дамбасүрэн - Хэмжил зүйн хүрээлэнгийн дарга
- 40 Сорьц нь металлын хайлшин дахь үнэт металлын агууламжийг тодорхойлж буй үйл явц
Д.Бэхбат - Сорьцын хяналтын газрын дарга
- 44 Лабораториудад үүсэх эрсдэлийг бууруулснаар хүнсний аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах боломжтой
Д.Эрдэнэтуяа - Нийслэлийн лабораторийн дарга
- 56 Баталгаажуулалтын гэрчилгээ гээгдсэн, үргэгдсэн, лац тэмдэг хөндөгдөж, эвдэрсэн бол баталгаагүйд тооцно
Л.Баярхүү - Хэмжих хэрэгслийн, шалгалт баталгаажуулалтын газрын дарга
- 58 Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр байгууллагын үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлнэ
С.Батбаатар - Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга
- 64 2024 онд виртуал хичээл бэлтгэхээр төлөвлөгөөнд тусгаад ажиллаж байна
Ч.Содном - Мэдээллийн технологи, стандартын лавлагаа, сургалтын төвийн дарга

Нэгдүгээр сар / 2024

Стандарт, Хэмжил Зүйн Газар



Эрхлэгч:	Ж.Золбат
Нарийн бичгийн дарга:	М.Лхагвасүрэн
Гишүүд:	Д.Дамбасүрэн Ч.Отгонцэцэг Л.Золзаяа Ч.Пүрэвдулам Д.Цэнд-Аюуш Д.Батзоригт Ч.Хатанбаатар Х.Энхцэцэг Ж.Цэцэгдарь Б.Энхтунгалаг
Техник редактор:	Н.Уранчимэг
Зурагчин:	Б.Эрдэнэбилгүүн
Хэвлэлийн эх бэлтгэсэн:	Н.Сувд-Эрдэнэ
“Туургатан Принтинг” хэвлэх үйлдвэрт хэвлэв.	

© Энэхүү сэтгүүл нь Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно.

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Энхтайваны гудамж - 46а
Улаанбаатар хот 13343
www.masm.gov.mn

Редакцын зурвас

Стандарт, хэмжил зүйн газар нь үндэсний стандартад олон улсын стандартын эзлэх хувийг нэмэгдүүлэх, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх, тохирлын үнэлгээний үйл ажиллагааг шинэ шатанд гаргах, бодлогоор дэмжих, салбарын зарим чиг үүргийг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих чиглэлээр гаргасан ололт амжилтаа ахиулан бататгах, өөрчлөлт шинэчлэлийг идэвхжүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх, салбарын тогтолцоо, үйл ажиллагааг улам боловсронгуй болгох, техникийн шинэчлэл, дэвшилтэт технологи, инновац, дижитал шилжилтийг нэвтрүүлэх чиглэлээр дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэн алхахын тулд хичээн ажиллаж байна.

Стандартын боловсролыг дээшлүүлэх зорилгыг амжилттай биелүүлэхийн тулд мэдлэгийг системтэй түгээх нь хамгийн чухал бөгөөд үүнд төрийн бодлого гол үүрэг гүйцэтгэдэг. Иймд бодлого өөрөө тууштай хэрэгжих нь туйлын чухал. Үүнээс гадна бодлого тодорхойлогчид, боловсролын байгууллагууд, төрийн бус байгууллагууд, хувийн секторын хамтын ажиллагаа ч чухал. Мэдээж иргэд өөрсдөө хэр оролцоотой байхаас маш их зүйл шалтгаална. Иймд тал бүрээсээ хамтдаа зүтгэж, улс эх орноо стандартын боловсрол бүхий иргэдтэй, өндөр хөгжилтэй улс орон болгохын төлөө хувь нэмрээ оруулцаа гэж уриалмаар байна.

Дэлхийн улс орнуудын өндөр хөгжилд хүрсэн нууц биш нууц нь стандарт. Стандарт хаана хамгийн сайн хэрэгжиж бас мөрдөгдөж байна тэнд чанар, аюулгүй байдал хангагдаж, амар тайван амьдрал цэцэглэж байдаг. Стандарт бол стратегийг хэрэгжүүлэх зарчим, гүйцэтгэлийг хангуулж, хөгжлийг хурдасгах замын зураг, заавал биелүүлэх амьдралын дүрэм юм. Стандарт хэмээх амин чухал зүйлийг өдөр тутмын ажил амьдралынхаа хэл соёл, хэрэглээ дадал, зарчим шаардлага болгон хэрэгжүүлэх үйл хэрэгт нийгмээрээ нэгдэх нь нэн чухал бөгөөд Стандарт, хэмжил зүйн байгууллагын манлайлал, идэвх санаачилга, оролцоо ихээхэн чухал үүрэг гүйцэтгэнэ хэмээн Монгол Улсын Шадар сайдын үргэлж онцлон хэлдэг үгээр энэхүү редакцын зурвасаа дуусгая.

Стандарт, хэмжил зүйн газрын сэтгүүлийн редакци



Стандартчилал, хэмжил зүйн салбарын үе үеийн ажилтан, алба хаагчид болоод стандартыг өдөр тутмын ажил, амьдралдаа мөрдлөг болгон хэрэглэгч иргэд, аж ахуйн нэгж байгууллага, төр, хувийн хэвшлийн төлөөлөл эрхэм Та бүхэндээ шинэ оны мэнд дэвшүүлж, 2024 ондоо ажил үйлс нь өөдрөг, амжилт бүтээлээр дүүрэн байхыг хүсэн ерөөе.

Стандарт бол улс орны хөгжлийн хэмжүүр, хүн амын амьдралын чанар, аюулгүй байдлын баталгааны илэрхийлэл болдог. Тийм ч учраас Улсын Их хурлаас 2020 онд баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг бодитоор хэрэгжүүлэхэд чанарын дэд бүтцийг бүрдүүлэгч гол үндэс суурь болсон Стандарт, хэмжил зүйн газрын үүрэг оролцоо нэн чухал билээ.

Монгол Улсын Засгийн газраас салбарын эрх зүйн орчныг шинэчлэх, үйл ажиллагааны чадавхыг дээшлүүлэх, олон улсын болон гадаад хамтын ажиллагааны харилцааг бэхжүүлэх чиглэлээр анхаарлаа хандуулан ажиллаж байгаагийн зэрэгцээ “Стандарт ба Хөгжил” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “НЭГ Улс - НЭГ Стандарт” зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Стандарт хэмээх амин чухал зүйлийг үндэсний хэмжээнд өдөр тутмын ажил, амьдралынхаа салшгүй нэг хэсэг,

хэл соёл, хэрэглээ дадал, зарчим шаардлага болгон хэрэгжүүлэх үйл хэрэгт нийгмээрээ нэгдэх нь нэн чухал бөгөөд стандарт, хэмжил зүйн байгууллагын манлайлал, идэвхи санаачилга юу юунаас чухал.

XXI зуун цахимжуулалт, нано технологи, инноваци, хиймэл оюун ухаан урьд өмнө байгаагүйгээр хурдтай өөрчлөгдөн хөгжиж, нийгмийн салбарууд нэг нэгнээсээ харилцан хамааралтай болж буй өнөө цагт олон улсын хөгжлийн чиг хандлага, нийтлэг шаардлагад нийцүүлэн стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүйн үйл ажиллагааг шинэ шатанд гарган хөгжүүлэх нь Та бидний эрхэм зорилго бөгөөд энэ тал дээр төр, засаг анхаарч хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, хэтийн хөгжлийн бодлогоо чиглүүлэн ажиллаж байна.

Стандартчилал, хэмжил зүйн салбараар овоглосон эрхэм Та бүхэн маань энэхүү хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр 2023 ондоо тодорхой зорилтуудыг тавьж амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд 2024 онд амжилтаа улам бататган, Стандарттай хөгжлийг салбар бүрд цогцлоон бий болгохын төлөө хичээн ажиллахыг хүсье. Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс болон хувиасаа Та бүхэндээ халуун талархал илэрхийлж, ажлын амжилт, амьдралын хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

Сайнбуянгийн
АМАРСАЙХАН

Монголчилдог бус Стандартыг мөрдөж хэвшье

► 2024 онд Засгийн газар, шадар сайдын ажлын хүрээнд ямар ажил хийхээр төлөвлөж байгаа вэ?

- УИХ-аар 2024 оны улсын төсвөө баталсан. Төсөл хөтөлбөрүүдээ хэрэгжүүлэх, нийгэм эдийн засгийн асуудлуудаа шийдвэрлэх, эдийн засгаа тэлэх, өгөөжөө нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох, Засгийн газрын барьж байгаа бодлогын хэрэгжилтийг хангах асуудал 2024 оны төсвөөр дамжиж биеллээ олох, түүний хэрэгжилт, чанарт анхаарлаа хандуулах, үр өгөөжийг иргэд айл өрхийн амьдралд бодитой байхуйцаар нийгмийн өмнө тулгамдсан олон хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Мөн Шинэ сэргэлтийн бодлогын дунд хугацааны зорилтуудаа урт хугацааны хэрэгжилттэйгээ уялдуулж богино хугацаанд бүх салбарын эдийн засгийн бие даасан байдал, эрчим хүчний хараат бус байдал, зам дэд бүтцийн хөгжил, барилга, нийгмийн асуудлууд, эрүүл мэнд, боловсрол гээд яриад байвал орхигдох хаягдах зүйл огт байхгүй учраас бүх салбарын уялдаа холбоог хангуулж ажиллах тал дээр анхаарч байна.

► Төсөв батлахтай холбоотой барааны үнэ нэмэгдэж иргэдийн амьдралд хүндрэл учирдаг асуудал байдаг. Ер нь төсвийн төлөвлөсөн байдал үнийн өсөлт буюу ард түмний амьжиргааны байдлыг уналтад хүргэхгүй байхад хэр анхаарал хандуулсан вэ?

- Төсвийн бодлого, төсөв санхүүгийн төсөл хөтөлбөрүүд, Засгийн газрын бодлого тэр чиглэл рүү л явж байгаа. Аль болох инфляцыг нам түвшинд барих, төгрөгийн ханш, валютын ханшны өсөлтийг зохистой түвшинд барих, үнийн хөөргөдлийг барих, мөнгөний үнийг унагахгүй байхад хамгийн гол анхаарлаа хандуулж байгаа. Тийм ч учраас аль болох инфляц, үнийн өсөлттэйгөө уялдуулан цалин тэтгэмжээ нэмэхэд анхаарч байна. Өнгөрсөн долоодугаар сард төсвийн тодотгол хийж цалингийн зөрүү, тэтгэврийн зөрүүгээ арилгасан. Дахиад инфляцтай уялдуулж төрийн албан хаагчид, тэтгэвэр, халамжийн зөв бодлогыг авч явах, үргэлжлүүлэх

үүднээс цалин тэтгэврийн асуудлуудаа шийдвэрлэлээ. 2024 оны төсвийг өргөн барихдаа хүртэл тэтгэвэр тэтгэмж, албан хаагчдын цалин хөлс, түүнийг дагасан ААНБ-ууд, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, татварын бодлого хөрөнгө оруулалтыг дэмжих гээд олон зүйлүүдээ багцалж оруулж ирсэн.

► “Стандарт ба хөгжил” үндэсний хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлээд нэг жил өнгөрч байна. Мөн “Эрсдэл ба Стандарт” сэдвийн хүрээнд томоохон хэлэлцүүлэг зохион байгууллаа. Энэ хоёрын уялдаа холбоо нь юу вэ?

- Стандарт бол бидний хөгжлийн хэмжүүр. Нөгөө талдаа аюулгүй байдлын шалгуур. Стандарт хаана хэрэгжиж байна тэнд аюулгүй байдал, чанар, хэрэглээний сэтгэл ханамж бий болж байдаг. Стандарт хаана мөрдөгдөхгүй байна тэнд ажил эзэнгүйрч, чанаргүйдэл бий болж, эрсдэл үүрлэж байдаг. Тийм учраас хөгжсөн улс орнуудын хөгжсөн нууц биш нууц нь Стандарт. Стандарт байгаа газарт хүнд суртал байдаггүй. Стандарт өөрөө хүнд суртал байх ч ёсгүй. Аливаа шатанд, бүх салбарт ажлыг эзэнжүүлээд, эзнийг нь хариуцлагажуулаад түүнийг дагасан гүйцэтгэлийн хяналт

СТАНДАРТЫГ ӨДӨР ТУТМЫН АЖИЛ,
АМЬДРАЛЫНХАА САЛШГҮЙ НЭГ ХЭСЭГ, ХЭЛ СОЁЛ,
ХЭМНЭЛ, ДАДАЛ ЗУРШИЛ, ЗАРЧИМ ШААРДЛАГА
БОЛГОЁ ГЭЭД БАЙГАА НЬ ИЙМ УЧИРТАЙ.
ИНГЭЖ БАЙЖ БИД УНДУЙ СУНДУЙ БОЛЧИХСОН
САЛБАРУУДАА ЦЭГЦЭНД НЬ ОРУУЛЖ, ЭМХ
ЦЭГЦТЭЙ, ЭРЭМБЭ ДАРААТАЙ, ЭРГЭЭД ТООЦОХ
ХАРИУЦЛАГЫН ЭЗЭН НЬ ТОДОРХОЙ БОЛОХ ЮМ.

“УЛС ОРНЫ ХӨГЖЛИЙН ГОЛ
ШАЛГУУР, ХҮН АМЫН АМЬДРАЛЫН
ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ, ҮНДЭС
СУУРЬ НЬ СТАНДАРТ ЮМ...”

Санамж бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөө байгуулаа

2023 оны 03 дугаар сарын 13-14

Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Бүгд Найрамдах Турк Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр “Халал чанарын дэд бүтцийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Халал итгэмжлэлийн агентлаг хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурлаа.

Мөн “Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Шинжлэх ухаан, технологийн судалгааны зөвлөлийн дэргэдэх Үндэсний хэмжил зүйн хүрээлэн хоорондын Харилцан ойлголцлын санамж бичиг” болон “Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар болон Бүгд Найрамдах Турк Улсын Стандартын байгууллага (TSE)-ын хооронд Стандартчилал, үнэлгээ, хэмжил зүй, сургалтын чиглэлээр 2022-2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” гэсэн эрх зүйн баримт бичгүүд батлагдлаа.



Үнэт эдлэл, үнэт металлын үзэсгэлэн болмоо

2023 оны 4 дүгээр сарын 13-14

Үнэт металлын үндэсний холбооноос хоёр дахь жилдээ зохион байгуулж буй үнэт эдлэл, үнэт металлын “Mongolian Jewellery & Metal Expo” үзэсгэлэн яармаг боллоо. Тус үзэсгэлэн үнэт металл, үнэт чулуугаар бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, уламжлагдан ирсэн соёлын өв тээгч, уран дархчид, гоёл чимэглэлийн худалдаа эрхлэгч албан байгууллага иргэдийг нэгтгэн, бүтээгдэхүүн үйлчилгээг төр болон олон нийтэд сурталчлан таниулах, борлуулалтад дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

“Дэлхийн хэмжил зүйн өдөр”-т зориулсан семинар болмоо

2023 оны 05 дугаар сарын 19

“Дэлхийн хэмжил зүйн өдөр” тохиож байгаатай холбогдуулан Стандарт, хэмжил зүйн газар, Хэмжил зүйн бодлогын газар, Хэмжил зүйн хүрээлэнгээс “Хэмжил дэлхийн хүнсний тогтолцоонд дэмжлэг үзүүлэх нь” сэдэвт семинарыг зохион байгууллаа. Хүнсний аюулгүй байдалд хэмжил зүйн гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, хяналтын тогтолцоо, судалгаа шинжилгээнд ашиглаж байгаа хэмжүүр, хэмжих хэрэгслийн ашиглалт, хэмжил зүйн үйл ажиллагаа, тогтолцоо, уялдаа холбооны хүрээнд явагдлаа. Хүний эрүүл мэнд, аюулгүй байдал хангагдах, хүрээлэн буй орчны чанар, тогтвортой байдлыг сайжруулахад стандарт хэмжил зүйн салбарын мэргэжлийн байгууллагаас эхлээд иргэн бүрийн оролцоо, хамтын ажиллагаа, дэмжлэг маш чухал ач холбогдолтой юм.

БНСУ-ын эталон, эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран уулзалт, семинар зохион байгуулаа

2023 оны 06 дугаар сарын 07

БНСУ-ын Эталон, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүд хоёр байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх хүрээнд Стандарт хэмжил зүйн газрын удирдлага, Хэмжил зүйн нэгжийн удирдлагууд болон мэргэжилтнүүдтэй уулзалт, семинар хийж, хоёр байгууллагын албан хаагч нарын дунд Хөл бөмбөгийн нөхөрсөг тоглолт зохион байгууллаа.

Урт, масс, цахилгаан болон шингэрүүлсэн шатдаг хий, байгалийн хийн хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт, хийн тоолуурын загварын туршилт, хийн тоолуур шалгаж баталгаажуулах зориулалттай эталон төхөөрөмж, хийн тоолуур болон бусад хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, нэгж дамжуулалт, эргэлзээний тооцоолол, стандарт арга, аргачлалын талаар зөвлөмж өгч, ажлын туршлага, мэдээлэл солилцох зэрэг хамтарсан уулзалт, семинар зохион байгуулсан юм.

АРМР-ийн хагас жилийн уулзалтыг зохион байгуулаа

2023 оны 06 дугаар сарын 12-16

Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжил зүйн хөтөлбөр (АРМР)-ийн хагас жилийн уулзалтыг Улаанбаатар хотод цахимаар болон биечлэн оролцох гэсэн хосолсон хэлбэрээр зохион байгууллаа.

Уулзалтаар “Удирдах Зөвлөлийн хурал”, “Хөгжиж буй орнуудын хэмжил зүйн байгууллагын (DEC) стратеги, зорилт”, “Хөгжиж буй орнуудын хэмжил зүйн байгууллагын (DEC) Техникийн хорооны хурал”, “DEC-ийн манлайлал ба удирдлага” зэрэг семинар боллоо. “Удирдах Зөвлөлийн хурал”-д нийт 31 хүн оролцсон бөгөөд хаалттай хуралдав. Харин “DEC-ийн

стратеги, зорилт” семинарын үеэр оролцогчид багаар ажиллаж Ази номхон далайн хөгжиж буй орнуудын хүрээлэнгүүдийг чадавхжуулах тэдгээрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, АРМР-ийн зүгээс хэрхэн

дэмжих, DEC-ийн стратеги, зорилтод оруулах саналуудыг гаргасан. АРМР-ийн 2023 оны хагас жилийн хурал, уулзалтын арга хэмжээний хуралдаанд Стандарт, хэмжил зүйн газрын 25 төлөөлөгч оролцсон юм.




ОХУ-ын холбооны Росстандарттай үйл ажиллагааны төлөвлөгөө байгуулаа

2023 оны 08 дугаар сарын 11

ОХУ-ын Холбооны техникийн зохицуулалт, хэмжил зүйн агентлаг (Росстандарт)-тай 2023-2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд гарын үсэг зурлаа.

Энэ үеэр талууд цаашдын хамтын ажиллагаагаа хэрхэн өргөжүүлж, хөгжүүлэх талаар харилцан санал солилцсон юм. Мөн Стандарт, хэмжил зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ууганбаяр, ОХУ-ын Холбооны техникийн зохицуулалт, хэмжил зүйн агентлаг (Росстандарт)-ийн дарга Шалаев Антон Павлович нар үйл ажиллагааны төлөвлөгөө байгуулж, харилцан гарын үсэг зурсан юм.

Уг үйл ажиллагааны төлөвлөгөөнд стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сургалтын чиглэлээр хэрэгжүүлэх ажлуудыг нарийвчлан зааж өгсөн байна.



Хоёр улсын стандартчиллын байгууллагуудын II форум БНХАУ-д зохион байгуулагдлаа

2023 оны 09 дүгээр сарын 06

Хятад-Монголын дөрөв дэх экспогийн үеэр Монгол-Хятадын ОУ-ын Стандартчиллын хоёр дахь удаагийн форумд Стандарт, хэмжил зүйн газрын төлөөлүүд оролцлоо. Энэхүү хоёр дахь дугаар форум “Стандарт-ногоон хөгжлийг дэмжиж, худалдааг хөнгөвчлөх нь” сэдвийн дор зохион байгуулагдсан юм. Хятад, Монголын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын 200 гаруй төлөөлөгчид уг форумд оролцож, стандартчиллын хөгжил дэвшил, ач холбогдол, цаашдын чиг хандлага, шийдлийн талаар хэлэлцсэн. Уг экспо нь оролцогч аж ахуйн нэгжийн тоог 30%-иар өсгөж, нийт 35 орны бараа бүтээгдэхүүнийг дэлгэн танилцуулж цар хүрээгээ өргөжүүлсэн онцлогтой болж байгаа юм. Үзэсгэлэнд Манай Улсын 500 аж ахуй нэгж оролцож байгаагийн 95% нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч байна. Салбар чиглэлийн хувьд 95% нь хүнс, мал аж ахуйн салбарын баялаг бүтээгчид оролцсон юм.

Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын дэд ЕНБД Силвио Дулински СХЗГ-т зочиллоо

2023 оны 09 дүгээр сарын 29

Монгол Улсад стандартчилал, хэмжил зүйн салбар үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойн арга хэмжээнд Олон улсын стандартчиллын байгууллага (ISO) хүндэтгэл үзүүлж, ISO-ын Дэд ерөнхий нарийн бичгийн дарга Силвио Дулински өөрийн биеэр Монгол Улсад хүрэлцэн ирж, мэндчилгээ дэвшүүллээ.

Арга хэмжээний үеэр Силвио Дулински “СХЗГ нь 1979 онд Олон улсын стандартчиллын байгууллагын бүрэн гишүүнээр элссэнээс хойш үлгэр жишээ гишүүн байсаар ирсэн. Үүнийг Монгол Улс төдийгүй дэлхийн тавцанд хийж гүйцэтгэсэн ажлаас тань бэлхнээ харж байна” хэмээв.

Мөн тэрбээр Стандарт, хэмжил зүйн газрын төв байранд зочилж, СХЗГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ууганбаяр болон холбогдох нэгжийн дарга нартай уулзаж, цаашдын хамтын ажиллагаа, ISO-оос гишүүн орнууддаа үзүүлж буй дэмжлэг, боломжуудын талаар санал, мэдээлэл солилцов.

Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулаа

2023 оны 11 дүгээр сарын 10

БНСУ-ын Эталон, эрдэм шинжилгээний судалгааны хүрээлэн (KRISS)-ийн хооронд хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, лаборатори хоорондын харьцуулалт хийх, хамтарсан сургалт, семинар зохион байгуулах, МУ-ын хэмжил зүйн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх сургалт, хөтөлбөрт хамруулах, лабораторийн техникийн чадамжийг нэмэгдүүлэхэд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.



Энэхүү уулзалтад БНСУ-ын Эталон, эрдэм шинжилгээний судалгааны хүрээлэн (KRISS)-ийн Ерөнхийлөгч, Ази, Номхон далайн бүсийн хэмжил зүйн хүрээлэн (APMP)-ийн дарга Дк. Хью Мин Парк, KRISS-ийн Гадаад хамтын ажиллагааны албаны дарга Ноён Ин Ён Хван нар Стандарт, хэмжил зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ууганбаяр, СХЗГ-ын Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын дарга, Г.Тулгаа болон бусад холбогдох мэргэжилтнүүд оролцсон юм.

Канад улстай стандартын салбарт хамтран ажиллах гэрээ байгуулав

2023 оны 11 дүгээр сарын 20

Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар болон Канад Улсын Стандартын зөвлөл (SCC) хооронд хамтран ажиллах гэрээг 11-р сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан Гадаад харилцааны сайдын Канад Улс дахь айлчлалын үеэр шинэчлэн байгуулсан. Дээрх баримт бичгийг байгуулснаар байгаль, газар зүй, уур амьсгалын хувьд Монгол Улстай ижил төстэй Канад Улсын дэвшилтэт стандартыг нутагшуулах, цаг агаарын хүйтэн нөхцөлд тэсвэртэй барилга, авто зам, гүүр, дулааны алдагдал багатай технологийг нэвтрүүлэх, Канадын Стандартын зөвлөлөөр итгэмжлэгдсэн стандарт боловсруулагч олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх, стандарт боловсруулах үйл ажиллагаандаа харилцан туршлага, мэдлэг солилцох, стандартчиллын салбарын хүний нөөцийг чадавхжуулахад ач холбогдолтой.



“HALAL ASSEMBLY 2023” олон улсын хуралд оролцлоо

2023 оны 12 дугаар сарын 03

Стандарт, хэмжил зүйн газраас Тайландын Хаант Улсад зохион байгуулагдаж буй 10 дахь удаагийн “Халал чуулган -2023”-т оролцож, олон улсын хамтын ажиллагаагаа өргөжүүлэн санал санаачилга солилцон ажиллалаа.

Энэ удаагийн чуулганд Дэлхийн 30 орчим орны төлөөлөгчид оролцож, “Дижитал технологийг халал үйлчилгээнд нэвтрүүлэх нь” уриан дор халал үйлчилгээг орчин үеийн технологийн шийдэлтэй хослуулах, арга аргачлал стандартыг боловсронгуй болгох, харилцан туршлага солилцох, мэдлэг мэдээллийг хуваалцахад чиглэлээ.

Тус олон улсын хуралд СХЗГ-ын Бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын газрын дарга В.Ганзориг, Нийслэлийн лабораторийн дарга Д.Эрдэнэтуяа болон бусад албаны хүмүүс оролцсон юм.



Тайландын “Чулалонгорны ХАЛАЛ шинжлэх ухаан, судалгааны төв”-ийн үйл ажиллагаатай танилцлаа

2023 оны 12 дугаар сарын 04

Чулалонгорн их сургууль нь бүс нутгийн хэмжээнд Халал бүтээгдэхүүнийг сурталчлах, хөгжүүлэх шинжлэх ухааны мэдээлэл лавлагаа, судалгаа шинжилгээг олон улсын түвшинд хөгжүүлэхэд анхаарч, үр дүнтэй ажлуудыг хийж байна. Халал шинжилгээний лаборатори нь судалгаа, инноваци, захиалгат судалгааны ажил эрхлэх гэсэн чиглэлүүдээр үйл ажиллагаагаа явуулдаг.


Энэхүү шинжлэх ухааны төвтэй Монгол Улсаас Стандарт, хэмжил зүйн газрын Бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын дарга В.Ганзориг, СХЗГ-ын Нийслэлийн лабораторийн дарга Д.Эрдэнэтуяа болон бусад албаны төлөөлөгчид тус төвд очиж, танилцан мэдээлэл солилцон ажиллалаа.



Стандарт, хэмжил зүйн газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл байгуулагдлаа

2023 оны 12 дугаар сарын 13

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны шийдвэрээр Стандарт, хэмжил зүйн газрын дэргэд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийг ажиллуулах шийдвэр гарлаа. Төрийн албаны зөвлөлийн Стандарт, хэмжил зүйн газрын дэргэд салбар зөвлөл байгуулагдсанаар төв болон 21 аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэст Төрийн албаны шинэтгэлийн бодлого, Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм журмын дагуу салбарын онцлогтой уялдуулан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарахад цаг алдалгүй тусгай шалгалтыг бие даан зохион байгуулах нөхцөл бүрдсэн юм.



Монголын мах, махан бүтээгдэхүүнийг булангийн орнууд руу экспортлох боломж бүрдлээ

2023 оны 12 дугаар сарын 20

Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар Булангийн орнуудын хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэдэх Итгэмжлэлийн төвөөр Халал гэрчилгээ олгох магадлан итгэмжлэлээ хийлгэж, гэрчилгээг гардан авлаа.

Стандарт, хэмжил зүйн газар нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн, Монгол Улсын Засгийн газрын экспортыг дэмжих бодлогын хүрээнд Монгол Улсаас Кувейт улс цаашлаад Булангийн орнууд руу мах, махан бүтээгдэхүүн экспортлох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, экспортын гарцыг нэмэгдүүлэх зорилтыг тавьж ажиллаж байна.

Стандарт, хэмжил зүйн газраас “Халал” гэрчилгээг олгох итгэмжлэлийн үнэлгээ хийлгүүлэхээр Булангийн орнуудын хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэдэх итгэмжлэлийн төвтэй жил орчмын хугацаанд хамтран ажиллав. Үүний үр дүнд тус итгэмжлэлийн төвөөс Стандарт, хэмжил зүйн газарт “Халал” гэрчилгээ олгох хүрээнд итгэмжлэл олгож буйгаа 12-р сарын 20-ны өдөр албан ёсоор мэдэгдэж, гэрчилгээг гардууллаа. Тус гэрчилгээ нь 2023-2027 оны хугацаанд хүчинтэй бөгөөд цаашид дахин сунгагдах боломжтой.

Ингэснээр Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газраар баталгаажсан, халал стандартыг хангасан Монгол мах, махан бүтээгдэхүүнийг Булангийн орон болон Араб, Исламын орнууд руу экспортлох үд хаалга манай хувийн аж ахуйн нэгж, компаниудад нээлттэй болж байна.

Стандарт, хэмжил зүйн газар зарим ажил, үйлчилгээг хувийн хэвшлээр гүйцэтгүүлж эхэллээ

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах, стандартын хэрэгжилтэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, бусад итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын чадавхтай уялдуулан Стандарт хэмжил зүйн газраас дараах шийдвэрийг гаргасан.

Газрын даргын 2023 оны 05-р сарын 08-ны өдрийн А/104 дүгээр тушаалын дагуу Стандарт, хэмжил зүйн газар 2024 оны 01-р сарын 01-ний өдрөөс чанарын менежментийн тогтолцоо (ISO 9001)-ны баталгаажуулалтад шинээр хамрагдах болон гэрчилгээний хугацааг сунгуулах хүсэлтийг хүлээн авахгүй бөгөөд менежментийн тогтолцооны дээрх төрлөөс бусад болон нэгдсэн менежментийн тогтолцоо (ISO 9001 багтаж болно)-ны баталгаажуулалтын хүсэлтийг хүлээн авах ажиллагаа хэвийн явагдах болно.

Хэмжил зүйн зарим ажил үйлчилгээг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхээр болмоо

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Хэмжил зүйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 22 дугаар зүйлийн 22.1.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын “Хувийн хэвшил, мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 340 дугаар тогтоолыг үндэслэн Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны 01-р сарын 16-ны өдөр баталсан А/15 дугаар тушаалаар хэмжил зүйн зарим ажил үйлчилгээг 2024 оноос эхлэн хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхээр боллоо. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан 57 нэр төрлийн хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгыг хувийн хэвшлийн болон хэмжил зүйн мэргэжлийн байгууллага гүйцэтгэх нь нээлттэй болсон.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газар хэмжил зүйн чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хувийн хэвшлийн болон хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын шалгалт тохируулгын лаборатори байгуулах, хөгжүүлэх, нэмэгдүүлэхэд чиглэсэн идэвхи санаачилгыг дэмжих;
- Хувийн хэвшил, хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын шалгалт тохируулгын ажилтны үр чадварыг үнэлэх, эрх олгох арга хэмжээг зохион байгуулах;
- Шалгалт тохируулгын ажилтны үр чадварыг нэмэгдүүлэх, чадавхжуулах, сургалт зохион байгуулах;
- Хэмжил зүйн ажил үйлчилгээг гүйцэтгүүлэх хувийн хэвшлийн байгууллагын чадавхтай уялдуулан шаардлагатай зохицуулалт хийх;
- Хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх шийдвэр, үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлж ажиллах.

“Стандарт ба хөгжил” Үндэсний чуулган



хэвшлийн байгууллагуудаар гүйцэлдүүлэх, тохирлын үнэлгээний байгууллагыг олон тоогоор бий болгох шаардлагатай байна гэдэг санал санаачилга нэлээд олон хувь эзэлсэн байна.

Б.УУГАНБАЯР: УЛСЫН ХЭМЖЭЭНД ӨРНӨСӨН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ 16 МЯНГА ГАРУЙ ИРГЭН ОРОЛЦОЖ, 6987 ОРЧИМ САНАЛ ИРҮҮЛСЭН БАЙНА. ЭДГЭЭР САНАЛ САНААЧИЛГУУДЫГ СТАНДАРТЫН БҮХ ТҮВШИНДЭЭ ХЭРЭГЖДЭГ БОЛГОХООР ЗОРЬЖ БАЙНА.

Энэ нь стандартын ач холбогдол, нийгэмд гүйцэтгэх үүргийн талаар иргэдийн мэдлэг ойлголт хангалттай бус, хууль эрх зүйн орчин нэн сул, төрийн байгууллагуудын уялдаа холбоо асар дутагдалтай байгаагаас стандартын хэрэгжилт хангалтгүй байна

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

С.АМАРСАЙХАН: “САЛБАР БҮРИЙН ХӨГЖЛИЙН СУУРЬ НЬ СТАНДАРТ ЮМ БАЙНА ГЭДГИЙГ БИД ХАА ХААНАА МЭДДЭГ БОЛЖЭЭ. БИД ЭМХ ЦЭГЦ, ЭРЭМБЭ ДАРАА, ЧАНАРЫН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛЖ ТОГТООН, ТЭДГЭЭРИЙГ ХЯНАЖ,ХЭМЖИЖ ЧАДДАГ БОЛСОН ЦАГТ Л БОДИТ ХӨГЖИЛД ХҮРНЭ. СТАНДАРТ БОЛ ШИНЖЛЭХ УХААНД СУУРИЛСАН, УЛС ОРНЫ ХӨГЖЛИЙН ГОЛ ХЭМЖҮҮР, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН САЛШГҮЙ ХЭСЭГ. ХҮН АМЫН АМЬДРАЛЫН ЧАНАР, ХЭРЭГЛЭЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БАТАЛГАА НЬ БАЙХ ЁСТОЙ. НИЙГЭМ ДАЯАРАА СТАНДАРТЫГ ЗАРЧИМ БОЛГОХ, ЗАРЧМАА ДАДАЛ БОЛГОН ХЭВШҮҮЛЭХ ЧАНАР, СТАНДАРТЫН СОЁЛЫГ ТҮГЭЭХЭД ТА БҮХНИЙ ҮҮРЭГ ОРОЛЦОО, ИДЭВХ ЧАРМАЙЛТ ХАМГИЙН ЧУХАЛ ЮМ ШҮҮ ГЭДГИЙГ ДАХИН ОНЦЛОН ХЭЛБЭ” ГЭСЭН ЮМ.

гэсэн санал, дүгнэлтүүд давамгайлсан юм. Хүнс, эрүүл мэнд, барилгын салбарт хамгийн олон стандарт мөрдөгддөг хэр нь энэ салбаруудад л хамгийн их асуудал гарч, аюул эрсдэл тулгардаг. Яагаад гэвэл хяналтын үйл явц нь эзэнгүйдчихсэн.


Цаашлаад Стандартын хэрэгжилт хангалтгүй байгаагаас гадаад улс орнуудтай эдийн засаг, экспортын чиглэлээр нээлттэй, “стандарт” гэсэн нэг хэлээр ярьж ойлголцоход хүндрэл гарч байгааг тодотгож байлаа. Чанарын дэд бүтцийн эрх зүйн орчныг олон улсын жишигт хүргэх замаар бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор “Стандарт ба хөгжил” үндэсний хөтөлбөрийн хэлэлцүүлгийг орон даяар өрнүүлсэн.



Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор “Төрөөс стандарт, хэмжил зүйн талаар баримтлах бодлого”, “Стандарт ба хөгжил” үндэсний хөтөлбөрийн хэлэлцүүлгийг 2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрөөс 03 дугаар сарын 30-ны өдрүүдэд 13 яам, 21 аймаг, Нийслэлийн 9 дүүрэг, нийслэлийн нутгийн захиргааны 34 байгууллага болон агентлагуудын төлөөллүүд ээрэг орон даяар хэлэлцүүлэг өрнүүлж, төслийг танилцуулан, санал солилцсон. Нэгдсэн хэлэлцүүлэг “Чингис хаан” үндэсний музейд амжилттай зохион байгуулагдаж нийт 16 мянга гаруй иргэн оролцсоноос 6987 орчим санал бичгээр болон цахим шуудангаар хүлээн авсан юм.

Үүний тулд эрх зүйн орчинг боловсронгуй болгох, тогтолцоог бий болгох, мөн стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний бодлого хэрэгжилтийг боловсронгуй болгох хүрээндээ стандартын хэрэгжилт дээр нь хяналт тавих, тогтолцоог бий болгох нь зүйтэй байна. Үүнийг хувийн

Хэлэлцүүлгийн хүрээнд хөндөгдсөн асуудлууд



ИРГЭДЭД ЭЭЛТЭЙ СТАНДАРТ ӨДӨРЛӨГ

Иргэд олон нийтэд Стандарт, хэмжил зүйн газар үйл ажиллагаагаа танилцуулах, иргэд өөрт хэрэгтэй үйлчилгээг хэрхэн, яаж авах болон стандартын тодорхой ойлголт өгөх зорилгоор “Иргэдэд ээлтэй өдөрлөг” зохион байгууллаа.

Уг нээлттэй хаалганы өдөрлөгт Стандарт, хэмжил зүйн газрын дэргэдэх Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, Сорьцын хяналтын газар, Хэмжих хэрэгслийн, шалгалт баталгаажуулалтын газар, Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газар, Нийслэлийн лаборатори, Бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын газар, Мэдээллийн технологи, стандартын лавлагаа, сургалтын төв болон 21 аймгийн стандарт, хэмжил зүйн хэлтсүүд оролцлоо.



МӨН ХҮРЭЛЦЭН ИРСЭН ИРГЭДИЙН ДУНД НЭЭЛТЭЙ МИКРОФОН АЖИЛЛАЖ, СТАНДАРТЫН ТАЛААРХ ИРГЭДИЙН ДУУ ХООЛОЙГ СОНСЛОО.

Өдөрлөгийн үеэр СХЗГ-ын дарга Б.Ууганбаяр “Стандарт, хэмжил зүйн салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, стандартын мэдээлэл, бүтээгдэхүүн, худалдаа, үйлчилгээний болон хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болох хүнсний болон ахуйн хийми, хөрс, ус, ургамлын үр зэрэгт сорилт шинжилгээ хийх үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хэрэглэгчдэд хүргэх чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна” гэсэн юм.

Мөн хүрэлцэн ирсэн иргэдийн дунд нээлттэй микрофон ажиллаж, стандартын талаархи иргэдийн дуу хоолойг сонслоо.

Түүнчлэн Нийслэлийн лаборатори Экспорт, импорт, органик бүтээгдэхүүний баталгаажуулалтын талаарх мэдээлэл өгөхөөс гадна танин мэдэхүйн сонирхолтой туршилтуудыг хийсэн бол Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лабораториос:

- Ажлын байр, цэцэрлэг сургуулийн анги танхимд цацраг идэвх радон хийн хуримтлалын хэмжээ тодорхойлох
- Гадаргууд альфа, бета цацрагийн бохирдолт, гамма цацрагийн тун, тунгийн чадал тодорхойлох
- Гамма цацрагийн үүсгүүр болон байгалийн фоны тун, тунгийн чадал тодорхойлох
- Эмнэлэг, сургууль цэцэрлэг, хүнсний байгууллагын ажлын байрны агаараас дээж авч, бичил биетний бохирдлыг илрүүлэх
- Эмнэлэг, сургууль цэцэрлэг, хүнсний байгууллагын эд зүйлсийн гадаргуугийн бохирдлыг тодорхойлох арчдасны шинжилгээг түргэвчилсэн аргаар хийх
- Бүх төрлийн бичил биетийг тодорхойлох түргэвчилсэн ялтаст оношлуур
- Гол мөрөн, булаг шанд, гадаргуугийн усанд эгэл биетэн илрүүлэх түргэвчилсэн тест зэрэг шинжилгээг хийсэн юм.

Орон нутгийн төлөөлөл болох Орхон аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн хамтран ажиллагч “Эрдмин” ХХК уртасгагч залуур, Дархан-Уул аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсээс “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК оролцон бүтээгдэхүүнээ дэлгэн танилцуулснаас гадна тохирлын гэрчилгээтэй, аюулгүйн тэмдэгтэй төв, 21 аймгийн бренд бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа дэлгэгдсэн юм.

Органик хүнсний баталгаажуулалтын чиглэлээр чадавхаа үнэлүүлж байна

“Органик хүнсний тухай” хуулийн хэрэгжилтийг хангах, баталгаажуулалтын үйл ажиллагааны хамрах хүрээг өргөжүүлэх зорилтын хүрээнд шаардлагатай баримт бичгийг боловсруулан түүний дагуу баталгаажуулалтын ажил үйлчилгээг эхлүүлж улмаар

АНУ-ын Олон улсын Органик итгэмжлэлийн байгууллага (IOAS)-аас итгэмжлэл авах хүсэлт гаргасаны дагуу үнэлгээний баг 2023 оны 10 дугаар сарын 02-ноос 07-ны хооронд Стандарт, хэмжил зүйн газарт ажилласан.

Энэхүү ажиллагаа нь Монгол Улсаас органик хүнсийг экспортлох, органик бүтээгдэхүүн болохыг нотолсон гэрчилгээг олон улсад хүлээн зөвшөөрүүлэхэд тавих шаардлагыг хангах боломжийг бүрдүүлж байгаагаараа онцлог юм.

Баталгаажуулалтын үйл ажиллагаанд оролцогчдыг чадамжийг дээшлүүлэх, арга зүйгээр хангах хүрээнд НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага (ЮНИДО)-н зөвлөх Kevin Gallagher-ыг урьж “Үр тарианы үйлдвэрлэл, мал аж ахуйн үйлдвэрлэл, зөгийн аж ахуй, хүнс боловсруулалтын чиглэлийн органик үйлдвэрлэл ба IFOAM стандартын шаардлага” зэрэг сэдэвт сургалтыг амжилттай зохион байгуулсан.

- Гурван аж, ахуйн нэгжийн бүтээгдэхүүнд Органикийн гэрчилгээ олгосон.
- “Сүргийн нуга” ХХК
- “Гурван борхууд” ХХК
- “Фирмакултур” хөгжил ХХК

Стандарт, хэмжил зүйн газрын 100 жилийн ойн баярын хурал болмоо



Анх 1923 онд “Жин хэмжүүрийн товчоо” нэртэйгээр 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдаж байсан бол өдгөө 14 нэгж, харьяа газар нэг, 21 аймгийн салбар хэлтсүүд нийт 700 гаруй ажилтан, албан хаагчтайгаар өргөжин тэлж, Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг болсон Стандарт, хэмжил зүйн газар байгууллагынхаа үүсэл хөгжил, төлөвшил дэвшлийн нэгэн зууны баяраа тэмдэглэж байна.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД С.АМАРСАЙХАН:
“СТАНДАРТ ХААНА ХАМГИЙН САЙН МӨРДӨГДӨЖ БАЙНА ТЭНД ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ ТОГТОЖ, АЙДАС ХҮЙДЭСГҮЙ АМАР ТАЙВАН АМЬДРАЛ ЦЭЦЭГЛЭДЭГ. ТИЙМЭЭС СТАНДАРТЫГ ӨДӨР ТУТМЫНХАА АЖИЛ АМЬДРАЛЫН ХЭЛ СОЁЛ, ХЭРЭГЛЭЭ ДАДАЛ, ЗАРЧИМ ШААРДЛАГАА БОЛГОХОД НИЙГМЭЭРЭЭ НЭГДЭХ НЬ ЭНЭ ЦАГ ҮЕД НЭН ЧУХАЛ БӨГӨӨД СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН БАЙГУУЛЛАГЫН МАНЛАЙЛАЛ, ТАЛ БҮРИЙН ИДЭВХ САНААЧИЛГА ИХЭЭХЭН ҮҮРЭГ ОРОЛЦООТОЙ”.



Мөн СХЗГ-ын дарга Б.Ууганбаяр “1923-2023 оныг хүртэлх зуун жилийн хугацаанд нийгэм улс төр, цаг үеийн хөгжил, хувьслын олон янзын өнгө аясыг туулсан ч ажил мэргэжлээ

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН САЛБАРЫН ҮҮСЭЖ ХӨГЖСӨН НЭГЭН ЗУУНЫ ТҮҮХ БОЛ ТА БИДНИЙ АЖИЛ МЭРГЭЖЛИЙН НЭР ТӨР, ҮНЭ ЦЭН, ҮҮРЭГ ОРОЛЦООНЫ БАЯР БИЛЭЭ.

үргэлжлүүлсээр ирсэн үе үеийн стандарт, хэмжил зүйчдэдээ талархан мэхийе.

Стандарт, хэмжил зүйн газрынхан олон улсын жишигт нийцсэн чанар стандартын үндэсний систем тогтолцоотой болох, судалгаанд суурилсан, шинжлэх ухааны үндэслэлтэй, амьдралын хөрсөнд нийцэн хэрэгжих боломжтой бодлого үйл ажиллагаа явуулах нийгэм цаг үеийн шаардлагыг хүлээн авч, ажил хэрэг болгохоор хичээн зорьж байна.

Чанар стандартад итгэх итгэл, хандах үнэ цэнийг өсгөх, үр дүнг нь танин мэдүүлэх соён гэгээрлийн ажлууд өрнүүлж, бүхнийг эхнээс нь эрэмбэлэн цэгцэлж, эмхлэн

харж, засан сайжруулж, зөв удирдан чиглүүлье гэсэн үндсэн үзэл баримтлал бүхий санал санаачилгууд гарган ажиллаж байна.

Үндэсний хэмжээний чанарын дэд бүтцийг бий болгохын тулд эрх зүйн орчныг боловсронгуй болгож, чанар стандарт тогтоох, баталгаажуулах, мөрдөх, хэрэгжүүлэх, хянах ажлын уялдааг хангах, санхүү эдийн засгийн бэрхшээлийг шийдвэрлэх зоригтой алхмуудыг хийн ажиллаж байна.” хэмээн хэллээ.

Түүнчлэн Олон Улсын Стандартчиллын байгууллагын дэд ерөнхий нарийн бичгийн дарга Силвио Дулински, Туркийн Халал итгэмжлэлийн агентлагийг төлөөлж Монгол Улс дахь Туркийн элчин сайдын яамны Худалдааны зөвлөх Кадир Серьян нар баярын хуралд мэндчилгээ дэвшүүлсэн юм.



Үндэсний чанарын чуулган 2023

Дэлхийн чанарын өдрийг угтан Манай Улс Үндэсний чанарын чуулган болон Үндэсний чанарын шагнал гардуулах үйл ажиллагааг зохион байгуулж байна. Энэхүү чуулганыг Стандарт, хэмжил зүйн газар болон Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Монгол Улсын Шадар сайдын ивээл дор Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд “Үндэсний чанарын чуулган-2023”-нд нийт 500 гаруй (танхимаар 300, цахимаар 200) оролцогч оролцсон юм.

Арга хэмжээний үеэр Шилдэг байгууллага, шилдэг үйлчилгээ, шилдэг аж ахуйн нэгж, байгууллагыг шалгарууллаа. Нийт 60 гаруй аж ахуйн нэгж, байгууллага өрсөлдсөн юм.



“Үндэсний чанарын шагнал-2023” эздээр дараах гурван байгууллага шалгарлаа.

Шилдэг аж ахуйн нэгж: “ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ

Чанарын менежментийн тогтолцоо; Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо; Хүний нөөцийн менежментийн тогтолцоо; Техникийн хяналтын менежментийн тогтолцоо; Лабораторийн чанарын менежментийн тогтолцоог холбогдох олон улсын стандартын дагуу хэрэгжүүлснээс гадна гадаадын ALS Group; Alfred H Khigh Asia Analytical болон RC Inspection Asia Assayers байгууллагаар хөндлөнгийн хяналтыг хийлгэж бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулдаг.

Шилдэг бүтээгдэхүүн: МИЛКО ХХК-ИЙН “Монголын камел” бүтээгдэхүүн

“Ингэний хоормог” нэрийн бүтээгдэхүүн нь энгийн болон баяжуулсан гэсэн 2 төрөлтэй. Тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл жилээс жилд нэмэгдэж, 2021 онд 17,3 мян.тонн байсан бол 2023 оны эхний 9 сарын байдлаар 63,7 мянган тонн болж өсөн БНХАУ-ын зах зээлд экспортолж байна.

Шилдэг үйлчилгээ: “СКАЙ ХАЙПЕРМАРКЕТ” ХХК

БНСУ-ын жижиглэн худалдаа сүлжээ болох Имарт хайпер маркетийг франчайзингийн эрхтэйгээр явуулдаг бөгөөд үйлчилгээний чанар хүртээмжийг хангах хүрээнд холбогдох хууль тогтоомж, стандартыг мөрдөхөөс гадна 40 гаруй дүрэм журам болон итгэмжлэгдсэн лабораториор дамжуулан дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

Үндэсний чанарын шагнал авсан байгууллага, аж ахуйн нэгжийн жагсаалт

ШИЛДЭГ БҮТЭЭГДЭХҮҮН	ШИЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭ	ШИЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ
“ЭКО НООС” ХХК Хонины ноосон барилгын дулаан тусгаарлагч материал	АРЬСНЫ ӨВЧИН СУДААЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ Эмнэлгийн тусламж үйлчилгээ	“М СИ ЭС ИНТЕРНЕЙШНА ХХК Эрчим хүчний чиглэлээр
2019		
ШИЛДЭГ БҮТЭЭГДЭХҮҮН	ШИЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭ	ШИЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ
“АПУ ДЭЙРИ” ХХК “Сайн актив” нэрийн иогурт	УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ Олон улсын тээвэр зуучлалын үйлчилгээ	“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК Химийн хог хаяглыг дахин боловсруулах үйлдвэрлэл
2020		
ШИЛДЭГ БҮТЭЭГДЭХҮҮН	ШИЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭ	ШИЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ
“СҮҮ” ХК “Миний Монголын сүү” нэрийн сүү	ОНЦГОЙ БАЙДАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР “Жаргалант” сувилал	“НЕКСТ ЭЛЕКТРОНИКС” ХХК Цахилгаан барааны импорт, нийлүүлэлт
2021		
ШИЛДЭГ БҮТЭЭГДЭХҮҮН	ШИЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭ	ШИЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ
“БАРЛОВАРД МОНГОЛИА” ХХК Машин тоног төхөөрөмжийн түлш, тос, хөргөлтийн шингэний шинжилгээний лабораторийн үйлчилгээ	“МИЛКО” ХХК “Зөв” брэндийн бүтээгдэхүүн: шингэн аарц, хатаасан аарц, аариан үрэл	“КАШМЕР ХОЛДИНГ” ХХК Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа (“Эвсэг”, “Нирун”, “Alfred Rowland”, “Топ донж” бренд)
2022		
ШИЛДЭГ БҮТЭЭГДЭХҮҮН	ШИЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭ	ШИЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ
“МИЛКО” ХХК “Mongolian camel” нэрийн бүтээгдэхүүн	“СКАЙ ХАЙПЕРМАРКЕТ” ХХК Жижиглэн худалдаа, үйлчилгээ	“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ Зэс, молибдены хүдрийн олборлолт, баяжуулалт
2023		

Эрсдэл ба стандарт

Үндэсний форум / 2023




Монгол Улсын Шадар сайдын ивээл дор “Эрсдэл ба стандарт” сэдвийн хүрээнд үндэсний форум болж, амжилттай өндөрлөлөө. Эрсдэлийн үндэсний форум нь улс оронд тулгарч болзошгүй нийгэм, эдийн засаг, гамшгийн эрсдэлүүд, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга замын талаар хэлэлцэж, бодит шийдлийг эрэлхийлж, төр, хувийн хэвшил, иргэний зүгээс эрсдэлийг удирдахад тодорхой хувь нэмэр оруулах зорилготой арга хэмжээ байлаа.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
С.АМАРСАЙХАН: ТООЦОО СУДАЛГААТАЙ, ҮНЭ ЦЭНТЭЙ, АЖИЛ ХЭРЭГЧ САНАЛУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МИНИЙ БИЕ ОНЦГОЙЛОН АНХААРАХ БОЛНО

Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан; Өнгөрсөн хугацааны гашуун сургамжийг ирээдүйд давтахаас урьдчилан сэргийлэх, Аливаа эрсдэлийг урьдчилан тооцож төлөвлөх, Стандартыг мөрдүүлэх замаар гамшгийн болон бусад эрсдэлийг бууруулах, шилжүүлэх, хариу арга хэмжээний стратеги төлөвлөлт, эрсдэлийн удирдлагын менежментийг сайжруулахад энэхүү форумын ач холбогдол оршиж байлаа. Монгол Улсад гамшгийн эрсдэлийн даатгалын тогтолцоо. Энэ тогтолцоо руу явахаас өөр гарцгүй. Даатгал бол зөвхөн санхүүгийн хэрэгсэл биш, байгалийн гамшиг, гэнэтийн аюул осол, эрсдэл тулгарахад хохирол багатайгаар даван туулах хамтын хүч юм. Хэлэлцүүлгийн хүрээнд яригдсан тооцоо судалгаатай, үнэ цэнтэй, ажил хэрэгч саналуудыг хэрэгжүүлэхэд миний бие онцгойлон анхаарал хандуулах болно. Энэхүү форумаас гарсан санал дүгнэлтийг ажил хэрэг болгох тал дээр үргэлжлүүлэн ажиллаж, ажлын хэсэг, баг ажиллуулж, Засгийн газар, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх ажлыг эрчимтэй үргэлжлүүлнэ” хэмээн хэлсэн юм.

Уг 14 дэх жилдээ болж буй арга хэмжээнд Стандарт, хэмжил зүйн газар хамтран зохион байгуулж оролцлоо. СХЗГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэч



Б.Ууганбаяр: “Стандартыг хэрэглэхгүй салбар гэж байхгүй. Стандарт нь өөрөө маш олон талт харилцааг зохицуулж байдаг. Үүнд: Худалдааг хөнгөвчлөх, Бизнесийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, Аюулгүй байдлыг хангах, Эрсдэлийг бууруулах зэрэг. Дэлхийн улс орнууд эрсдэлээ удирдах, эрсдэлээ бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд стандартыг үйл ажиллагаандаа

дагаж мөрдөж байна. Бид стандартыг ажил амьдралдаа хэрэгжүүлж, амьдралын дадал хэвшил болгох ёстой. Энэ нь эрсдэлийг бууруулах гол хэрэгсэл. Стандартыг мөрдөхгүй байх нь нийгмийн эрсдэлийг бий болгож байна. Бүх салбарт стандарт хангалттай байна. Гэвч хэрэгжүүлэх, импортоор орж ирж байгаа бараа бүтээгдэхүүнд стандартын дагуу хяналт шалгалт хийхгүй байна. Энэ нь өөрөө эрсдэл. Байгалын давагдашгүй хүчин зүйлийг бүрэн сэргийлж чадахгүй ч Бүтээн байгуулалт, дэд бүтцийг шийдэхдээ стандартын шаардлага, норм дүрэм, техникийн зохицуулалтыг ягштал баримталснаар иргэдэд учирч болох эрсдэлээс хамгаалж буй хамгийн том шийдэл болно” хэмээн онцлон хэлсэн юм.

Уг арга хэмжээг Онцгой байдлын ерөнхий газар, Стандарт, хэмжил зүйн газар, нийслэл болон 21 аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран улсын хэмжээнд зохион байгуулсан. Форумын үйл ажиллагаанд төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллага болон НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Хүүхдийн сан, Хүн амын сан, ДЭМБ, МУЗН зэрэг олон улсын байгууллагуудын 2400 гаруй төлөөлөгч оролцлоо. Түүнчлэн 21 аймагт “Эрсдэл ба стандарт” үндэсний форумын салбар хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд тоног төхөөрөмж, хүний нөөц, техникийн чадавхыг нэмэгдүүлэх зэрэг асуудал олон байна

► Хэмжиж чаддаг улс хөгждөг. Манай улс хэмжиж чадаж байна уу?

- Манай улс хэмжиж чадаж байна. Гэхдээ тодорхой түвшинд хэмжиж чадаж байгаа ч нэр төрөл цар хүрээ нь бага байна. Нарийн хэмжлийн үр дүнгээс стандарт гэдэг зүйл бий болдог. Өнөөдөр Стандарт, хэмжил зүйн газар нь хуулиар олгосон чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд тоног төхөөрөмж, хүний нөөцийн чадавхаас эхлээд маш олон зүйлүүдийг шийдвэрлэх шаардлагатай байна.

► Стандарт, хэмжил зүйн салбар аливаа зүйлийн хэм хэмжээг тогтоож, асуудал болон аюул дагуулаад байна уу гэдгийг нийгэмд тогтоож өгдөг байгууллага. Гэтэл энэ байгууллагын нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэгт ач холбогдол, хөгжлийг бодолгүй төсөв мөнгө оруулахгүй хасаад байгаа харагддаг, Та үүнтэй санал нийлэх үү?

- Энэ асуудлууд хурцаар тавигдаж байна. Стандарт, хэмжил зүйн салбар бол хөгжлийн суурь үзүүлэлтийг тодорхойлдог байгууллага. Дэлхийн улс орнууд Стандарт, хэмжил зүйн байгууллагад маш өндөр ач холбогдол өгч, санхүү төсвийг нь шийдвэрлэдэг. Хамгийн чадалтай, сүүлийн үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангагддаг. Гэтэл манай улсад хэрэглэж байгаа техник хэрэгсэл хангалтгүй түвшинд байсаар байна. Монгол Улсын Үндсэн хуульд Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, байгалийн тэнцэл алдагдахаас сэргийлүүлэх эрхтэй гэж заасан. Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх гэдэг үүнийг яг юугаар тодорхойлох вэ. Эрүүл гэхээрээ эрүүл, аюулгүй гэхээр аюулгүй болчихдог юм уу? Эрүүл аюулгүй орчныг тодорхойлж байгаа баримт бичиг, шалгуур үзүүлэлт нь стандарт. Энэ стандартын шаардлагыг хангаж байгаа тохиолдолд эрүүл аюулгүй орчинд амьдарна гэсэн үг.

► Энэ нь хангагдахгүй байна гэсэн үг үү.

- Тийм. Хангагдахгүй байна.

► Танай байгууллагын нийгэмд эзлэх байр суурь, үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлооч гэвэл юу гэх вэ?

- Үндсэн чиг үүрэг нь хэрэглэгч үйлдвэрлэгчийн эрх ашгийг хамгаалахад чиглэгддэг. Үйл ажиллагааны цар хүрээ гэвэл маш том. Монгол Улсад мөрдөж буй стандартыг батлах, Олон Улсын стандартыг нутагшуулах, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулах, улсын эталоныг хадгалах, хэмжлийн үр дүнг олон улсад хүлээн зөвшөөрүүлэх, тохирлын үнэлгээний үйл ажиллагаа, стандартын шаардлага хангасныг нотлох үйл явц, мөн сорьцын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Олборлосон алтыг хайлж гулдмайлах, сорьц тогтоох, эрдэнийн чулууг тодорхойлох, сорилт туршилтын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, Нийслэлийн лаборатори нь манай байгууллагад 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдөр шилжин ирсэн. Стандарт, хэмжил зүйн газар нь дэргэдээ 1 байгууллагатай, 21 аймагт салбар хэлтэстэй, салбарын хэмжээнд 720 гаруй албан хаагчидтай байгууллага. Үйл ажиллагаандаа Стандартчилал техникийн зохицуулалт тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Хэмжил зүйн тухай хууль, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хууль зэрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилладаг. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад 6608 стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүний 43 хувь нь Олон Улс, бүс нутгийн хэмжээнд хүрсэн. 1,3 сая хэмжих хэрэгсэлтэй. Хэмжих хэрэгсэл гэдэг нь бид бүхний өдөр тутамдаа ашигладаг усны, цахилгааны тоолуур, худалдааны жин, шатахуун түгээх станцын хошуу зэрэг бөгөөд үүнийг шалгаж баталгаажуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

► Хэмжиж чаддаг улс хөгждөг гэдэг. 1,3 сая хэмжих хэрэгслийг шалгаж, баталгаажуулахад ямар хүндрэл тулгарч байна?

- Монгол улсад 2013 онд 650 мянган хэмжих хэрэгсэл байсан бол өнөөдөр 1 сая 300 мянган болсон. Гэтэл



“УЛСЫН ЭТАЛОН ГЭДЭГ НЬ ҮНЭН ЗӨВ
БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ШАЛГАХ БАГАЖ
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ. ГЭТЭЛ УГ ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ МАНАЙ УЛСАД 11 ШИРХЭГ
Л БАЙНА. ГЭТЭЛ БНХАУ-Д 554 УЛСЫН
ЭТАЛОН БАЙНА. СОЛОНГОС 800, ГЕРМАН
1000, ХАМГИЙН БАГА НЬ ЧЕХ УЛС 65 БАЙХ
ЖИШЭЭНИЙ...”

хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулдаг мэргэжилтэн 2013 онд 53 байсан бол өнөөдөр 46 болж буурсан. Үйл ажиллагааны цар хүрээ өсөөд байдаг. Нөгөө талд хүний нөөц багасаж, нэмэгдүүлэх шаардлагатай асуудлууд тулгараад удаж байна. Стандарт, хэмжил зүйн салбарын 100 жилийн ой 2023 онд тохиож, ойн хүрээнд улсын эталонууд бий болгосон. Улсын эталон гэдэг нь үнэн зөв байдлыг дүйцүүлэн шалгах багаж тоног төхөөрөмж. Гэтэл уг тоног төхөөрөмж манай улсад 11 ширхэг л байна. БНХАУ-д 554 улсын эталон байна. Солонгос 800, Герман 1000, хамгийн бага нь Чех улс 65 байх жишээний. Энэ тоог нэмэгдүүлэх шаардлагатай. Мөн хүч, хатуулаг, гэрэл, хий эдгээр чиглэлийн эталонуудыг бий болгох зайлшгүй шаардлагатай. Үүнийг төрөөс бодлогоор дэмжиж өгөх хэрэгтэй байна.

▶ Стандартын хэрэгжилт ямар байгаа вэ? Эрх зүйн орчин уялдаа холбоогүй байгааг байдаг?

- Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр нэлээд арга хэмжээ авч байгаагаас гадна Монгол Улсын Шадар сайдын зүгээс манай салбарт онцгой анхаарч ажиллаж байна. Үүний хүрээнд Монгол улсын Ерөнхий сайдын захирамжаар Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд өөрчлөлд оруулахаар ажлын хэсэг байгуулагдан Шадар сайд, яам, агентлагууд орж ажиллаж байна. Батлагдсан 6608 стандарт бий. Гэхдээ стандартын хэрэгжилт ямар байгаа вэ гэвэл “хангалтгүй”. Учир нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд Стандартын хэрэгжилтэд хуучин Мэргэжлийн хяналтын газар, гаалийн байгууллага хяналт тавина гэж заасан хуультай байсан. 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс тодорхой зөрчлүүд арилсан. Мөн стандартыг сонгон хэрэглэнэ гэж заасан. Энэ нь стандартыг хэрэглэж ч болно хэрэглэхгүй ч байж ч болно гэдэг ойлголтын зөрүүтэй байдлыг бий болгож байна. Дэлхийн бусад орнууд тохирлын үнэлгээний байгууллага хувийн хэвшлээр дамжуулан стандартын хэрэгжилтийг хангуулдаг. Гэтэл манай улсад стандартын хэрэгжилтийг хангах эзэн нь тодорхойгүй байна. Хэрхэн хэрэгжүүлэх, хэн хяналт тавих бэ гэдэг нь асуудал хэвээр байна.

Уг нь 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс салбарын яамдад стандартын хяналт очсон. Бодлого, хэрэгжилт, хяналт гурав нэг малгайн доор орсон. Холбогдох яамнууд хяналтаа тавиад явж байгаа. Тодорхой өөрчлөлт, шинэчлэлт гарна гэж итгэж байна. Гэхдээ төрийн байгууллагуудад зөвхөн хяналтын чиг үүргийг оноогоод байгууллагууд стандартыг хэрэгжүүлнэ гэж үзвэл өрөөсгөл. Учир нь иргэд стандартын талаар ойлголт мэдээлэлтэй болж, стандартыг шаарддаг, нэхдэг болж байж стандарт хэрэгжинэ. Ингэж бие биедээ стандартын шаардлагыг тавьж, хангаснаар эрүүл, аюулгүй баталгаатай орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ. Хэмжил зүйн болон сорьцын хяналтын чиг үүрэг манай байгууллагад байна. Хэмжил зүйн хяналт, бодлогоо хэрэгжүүлэхээр байцаагчаа томилоод ажиллуулж байна. Үндсэн зорилго нь зөрчил дутагдалтай иргэн, хуулийн этгээдийг торгох бус иргэний эрх ашгийг хамгаалах, стандартын хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна.

Хэмжил зүйн хяналтын байцаагч нар зах, худалдааны төвүүд зэрэг 286 объектод хяналт шалгалт хийж, 70 гаруй хувьд хүрсэн байна. Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, Нийслэлийн лабораторийн бодлого, зорилтынхоо түвшинд хангалттай ажиллаж чадахгүй байгаа. Нийслэлийн лаборатори, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, 21 аймгийн лабораторийн бодис урвалжийн төсвийг 50 хувь танасан. Энэ нь шаардлагатай шинжилгээг хийх боломжгүй болох эрсдэлийг бий болгож байгаа юм. Нийслэлийн лабораторид 2023 оны эхний 10 сарын байдлаар 10.455 дээж шинжилгээний 6% нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй. Уг 6 хувь нь иргэн, аж ахуйн нэгж өөрийн хүсэлтээр ирсэн дээжээс илэрсэн. Гэтэл улсын байцаагчийн хяналт шалгалтын нийт сорьцын 20%-ийг дээж эзэлж байгаа нь шаардлага хангаагүй дээжийн эзлэх хувь нь өндөр. Тиймээс эрсдэл бүхий цэгүүдэд улсын байцаагч ажиллаж, хяналт шалгалт хийснээр эрсдэл буурна гэж байгаагийн тод илрэл. Иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтээр дээж авах бус нэгдсэн нэг журмаар шинжилгээнд хамруулах нь зүйтэй. Хэрэв, стандартын хэрэгжилтийг хангуулахад анхаарья гэж байгаа бол энэ асуудалд бодитой хандаж, оновчтой шийдвэр гаргах ёстой.

▶ Стандарт, хэмжил зүйн газарт ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, лабораторийн үйл ажиллагаа ямар түвшинд байна вэ?

- Эталон төхөөрөмж, техник хэрэгсэл маш хангалтгүй. Дэлхийн улс оронд тоног төхөөрөмж 800, 1000 байхад манайх 11. Нийслэлийн лаборатори дээр хэрэглэгдэж байгаа төхөөрөмжүүдийн 85% нь ашиглалтын шаардлага хангахгүй, 20-оос дээш жилийн насжилттай. Тоног төхөөрөмжийг засаж сэлбээд явж байна. Бусад орны адил өндөр үзүүлэлт, шаардлага хангасан олон үзүүлэлтээр гаргадаг байх шаардлагатай. Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори 2013 онд БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар байгуулагдсан. Энэ лаборатори дээр ашиглаж байгаа тоног төхөөрөмж, 21 аймгийн сорилтын лаборатори дээр ашиглаж байгаа 190 төрлийн 490 багаж төхөөрөмжийг шинэчлэх шаардлагатай үүссэн. Пестицидээ тодорхойлж чадахгүй байдалд хүрээд байна. Пестицид нь хурц хордлого шууд өгөхгүй, аажимдаа архаг хордлого бий болгодог, хүний гений удмын санд нөлөөлөх хүртэл эрсдэл бий болгодог.

▶ Пестицидийг хэдэн үзүүлэлтээр шалгаж байгаа вэ?

- Өмнө нь 14-ийг шалгадаг байсан бол өнөөдрийн байдлаар энгийн аргаар буюу пестицид байна, байхгүй гэдэг үзүүлэлтийг гаргаж байгаа юм. Гэтэл дэлхийн улс орнууд 230 үзүүлэлтээр тодорхойлж байна.

НИЙСЛЭЛИЙН ЛАБОРАТОРИ ДЭЭР ХЭРЭГЛЭГДЭЖ БАЙГАА ТӨХӨӨРӨМЖҮҮДИЙН 85% НЬ АШИГЛАЛТЫН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ, 20-ООС ДЭЭШ ЖИЛИЙН НАСЖИЛТТАЙ. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ЗАСАЖ СЭЛБЭЭД ЯВЖ БАЙНА.

▶ Стандартын хэрэгжилт хангалтгүй, лабораторийн үйл ажиллагаа хэвийн бус цаашид яах вэ?

- Төр бас нүдтэй. Асуудлуудыг шийдээд явна гэж итгэж байна. Стандарт нийгэм, эдийн засгийн цаг үетэйгээ уялдаад өөрчлөгдөж, шинэчлэгдэж, нэмэгдэж, хасагдадаг. Харин стандартын шаардлага хангуулахад төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа чухал. Аюулгүй байдлын үзүүлэлт шаардлагуудаа төр нь, бусад асуудлыг төр хувийн хэвшлийн хүрээнд хэрэгжүүлэх боломж бий. Эрх зүйн орчноо боловсронгуй тодорхой болгох нь зүйтэй байна. Монгол Улсын засгийн газрын 2023 оны 340 дүгээр тогтоолын хүрээнд бид тодорхой арга хэмжээнүүдийг хувийн хэвшилд шилжүүлэх, тохирлын үнэлгээний байгууллагуудыг бодлогоор дэмжих чиглэлээр бодлого, зохион байгуулалтын арга хэмжээ авч байна. ISO:9001 Менежментийн тогтолцооны баталгаажуулалтыг тохирлын үнэлгээний байгууллага хийдэг байсныг хувийн хэвшилд шилжүүлсэн. 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс Стандарт, хэмжил зүйн газар энэ чиг үүргийг хэрэгжүүлэхгүй. Хувийн хэвшил нь хэрэгжүүлэх тодорхой шийдвэр гарсан. Саар зүйлийн хажуугаар сайн зүйлс байна. Органик баталгаажуулалтын чиглэлээр олон улсын итгэмжлэлд хамрагдахаар болсон. Мөн халал баталгаажуулалтын итгэмжлэлд хамрагдахаар болсон. Ингэснээр булангийн орнуудад халал аргаар махыг экспортод гаргана. Жилд дунджаар 600 сая ам доллар Монгол улсад орж ирэх боломжтой.

▶ Заавал баталгаажуулалтад хамрагдах бүтээгдэхүүний жагсаалт гэж байдаг. Энэ тогтоолын хэрэгжилт бодит байдалд ямар байдаг бол?

- Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд нөлөөлдөг бүтээгдэхүүн үйлчилгээний жагсаалтыг 2018 оны 291 дүгээр тогтоолоор баталсан байдаг. Энэ нь 50 бүлгийн 644 бүтээгдэхүүн үйлчилгээний жагсаалт байдаг. Стандарт, хэмжил зүйн газар дээрх жагсаалтын 286 бүтээгдэхүүнийг баталгаажуулж тохирлын үнэлгээнд хамруулж чадаж байна. Бусад чиглэлээр 12 байгууллага 52 чиглэлийн үйлчилгээнд тохирлын үнэлгээнд хамруулж байна. Үлдсэн 300 нэр төрлийн бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулж чадахгүй байна. Үүнийг хэрэгжүүлэх орон зай хувийн хэвшилд байна хамгийн гол нь салбарын яам бодлогоор дэмжих хэрэгтэй байгаа юм.

▶ Тохирлын үнэлгээнд хамрагдаж чадаагүй 300 бүтээгдэхүүн дээр нийтийг хамарсан асуудал гарвал яах вэ?

- Энэ жагсаалтад өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Цаг үеэ дагаад өөрчлөх, шинэчлэх, жагсаалтаас нэлээд хувийг нь хасах мөн нэмэх шаардлагатай бүтээгдэхүүн бий болсон байна. Мөн тохирлын үнэлгээний үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх гэдэг асуудал байдаг. Стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаа магадгүй БНХАУ, Япон улсаас орж ирдэг. Шаардлага хангасан байхыг үгүйсгэхгүй. Энэ асуудлуудыг харилцан хүлээн зөвшөөрөх асуудалд ач холбогдол өгөөд явж байна.

▶ 2024 оны төсөв ороод батлагдсан, Энэ тал дээр ямар менежмент хийж ажилладаг вэ?

Төсөв хөрөнгө оруулалтад хэд хэдэн зайлшгүй шийдвэрлэх асуудал байна. Урвалж бодисын хэмжээг

ISO:9001 МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫГ ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА ХИЙДЭГ БАЙСНЫГ ХУВИЙН ХЭВШИЛД ШИЛЖҮҮЛСЭН. 2024 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 01-НЫ ӨДРӨӨС СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР ЭНЭ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХГҮЙ.

нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна. Манай төсөв өнгөрсөн жилийнхтэй ижил орсон байна. Үүнийг холбогдох байгууллагуудад саналаа өгсөн. Нааштайгаар шийдвэрлэнэ гэж найдаж байна.

▶ Төсвийн тодотголоор нэмээд оруулчихвал?

- Стандарт, хэмжил зүйн салбарт хөрөнгө оруулалт дутмаг шийдвэрлэгддэг. Сүүлийн 10 жилд манай салбарын хөрөнгө оруулалтаас харахад Хэнтий, Дорнод аймагт гишүүний багцаас хоёр барилга шийдвэрлэгдсэнийг эс тооцвол 2022 онд 300 сая төгрөгийн хөрөнгө оруулалт л хийгдсэн. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр бусад хөтөлбөр, бодлогын баримт бичигт хэд хэдэн зорилт арга хэмжээнүүд бий. Хэмжил зүй, тоног төхөөрөмжийг бий болгох, үйл ажиллагаагаа цахимжуулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч байна. Бид зөвхөн улсын төсвийг харж суухгүй аль болох бүх талын боломж бололцоог эрэлхийлж ажилдаг ч хүрэлцэхгүй хүндрэлтэй байна.

▶ Аливаа стандартыг батлахад тус бүр хороотой байдаг юм байна. Стандартыг ямар аргаар нутагшуулдаг вэ?

- Стандартыг хэн ч боловсруулж болно. Манай байгууллагын дэргэд төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоос бүрдсэн 64 стандартчиллын техникийн хороо байдаг. Энэ хороод иргэний эсвэл хувийн хэвшлийн боловсруулсан стандартыг тал бүрээс нь судалж шинжилж, шинжлэх ухаанч талаас нь баталдаг.

▶ Хөгжлийн стандарт гэдэгт юу юу байж болдог вэ?

- Төлөвлөлтгүй гүйцэтгэл бол бүтэлгүйтэлтэй адилхан гэдэг. Тиймээс төлөвлөлт байж гүйцэтгэл тод гарна. 2024-2025 оны стандартчиллын төлөвлөгөөг боловсруулж байна. Ингэхдээ салбарын яамдууд, холбогдох байгууллагуудаас санал авч байгаа. Стандартын хөтөлбөр төлөвлөгөөнд суурилан стандартчиллын төлөвлөгөө батлагддаг. Стандартчиллын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангадаг байх ёстой. Энэ хөгжлийн бодлогодоо нийцсэн стандартыг богино хугацаанд баталдаг, батлагдсан стандарт нь бүх төвшиндөө хэрэгждэг. Хэрэгжилтийн үр дүнд амьдралын чанар сайжирдаг. Энэ бодлого зохицуулалтыг эрх зүйн орчиндоо бид бүхэн оруулан ажиллаж байна.

▶ Төлөвлөлт, судалгаа тооцоогүй, шинжлэх ухаанчаар хандаагүй ажил цаашаа ерөөсөө явдаггүй. Үүнийг та стандарттай холбож тайлбарлаач?

- Стандарт өөрөө хөгжлийн баримт бичиг. Дэлхийн бусад орны адил хөгжинө гэвэл стандартаа л мөрд. Энэ бол цорын ганц арга зам. Тиймээс стандартыг бүх төвшиндөө хэрэгждэг, иргэд нь өөрсдөө стандартын мэдлэг ойлголттой байж, шахаж шаарддаг байя. Үйлчилгээний байгууллагууд стандартын шаардлагаа хангадаг. Ингэж чадвал амьдралын чанар сайжирна. Өнөөдөр би стандартын байгууллагыг удирдаад, стандартыг хамт баталж байгаа ч ажлаасаа гараад энгийн л нэг аав хүн. Өнөөдөр миний хүүхэд хүүхдийн тоглоомынхоо талбайд аюулгүй орчинд тоглодог байх наад захын стандарт хэрэгжихгүй байгаа нь харамсалтай санагддаг.

► Стандарт, хэмжил зүйн газрын гадаад хамтын ажиллагаа 2023 онд хэр өргөн хүрээг хамарч өнгөрсөн бэ?

- Монгол улс хоёр болон олон талт хамтын ажиллагаатай 27 байгууллага бий. БНХАУ, Солонгос, Канад, Орос зэрэг. Хамтарсан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бааз суурийг нэмэгдүүлэх зэрэг тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллалаа. 2023 оны 06 дугаар сард Оросын Росстандарт байгууллагатай үйл ажиллагааны төлөвлөгөө байгуулсан. Тодруулбал, Стандартын хүний нөөцийг сургаж дадлагуулах болон химийн хэмжил зүйг хөгжүүлэх, багаж техникээр дэмжлэг үзүүлэх зэргээр хамтран ажиллахаар боллоо. Мөн БНХАУ-ын SAC-тай хамтран ажиллах уулзалтыг Монгол Улсын Шадар сайдын хамт хийсэн. Энэ уулзалтад Шадар сайд оролцсоноор хамтын ажиллагааг сэргээх, өргөжүүлэх, үр дүнг нэмэгдүүлэх арга хэмжээг бий болгосон. Хүнсний аюулгүй байдлыг хангах лабораторийн тоног төхөөрөмжийн бааз суурийг өргөжүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлнэ гэсэн саналаа илэрхийлсэн. Шаардлагатай тоног төхөөрөмжийн өндөр хүчин чадал бүхий төхөөрөмж нь манай байгууллагад ирсэн тохиолдолд тоног төхөөрөмж дээр ажиллах боловсон хүчин байна уу гэдэг асуудал гарна. Иймд БНХАУ-д тоног төхөөрөмж ажиллуулж сурахад тухайн улсын мэргэжилтнийг манайд ажиллуулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг тусгасан. Стандартыг ижилтгэх, хүлэмжийн хийг бууруулах, байгалийн нөхөн сэргээлт зэрэг стандартыг дүйцүүлэх зэргийг харилцан тохиролцоод үйл ажиллагааны төлөвлөгөө байгуулсан байна. Үүнээс гадна Солонгос Улстай хамтын ажиллагаагаа сэргээн бас үргэлжлүүлэн ажиллаж байна. Канад болон Турк Улсын стандартын байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан гээд ололт амжилт ихтэй жил байлаа.

► Ярилцсанд баярлалаа. Танд цаашдын ажилд нь амжилт хүсье.

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

ХЭМЖИЛ ЗҮЙН БОДЛОГЫН ГАЗАР

Хэмжил зүйн үйл ажиллагааны чадавхыг үнэлэх

2023 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар Монгол Улсад 9 хэмжлийн төрлөөр 210 аж ахуйн нэгж, байгууллага үнэлгээнд хамрагдаад байна.

2023 онд 51 аж ахуйн нэгж, байгууллагад үнэлгээний ажил хийгдсэн бөгөөд

- Анхдагч - 29
- Хамрах хүрээ өөрчлөх - 3
- Давтан - 17
- Магадлан - 2

Загварын туршилтад 58 аж ахуйн нэгж, байгууллагын 93 хэмжих хэрэгслийг хамруулсан. Үүнд:

- OIML-ийн гэрчилгээ хүлээн зөвшөөрсөн - 1
- Сунгуулах - 40
- Шинээр - 43
- Загварын туршилтад тэнцээгүй - 9 хэмжих хэрэгсэлд туршилт хийсэн байна.

Стандартын хэрэгжилтийг хангахад хэмжил зүйн үйл ажиллагаа, чадамж үнэтэй хувь нэмэр үзүүлдэг

► Стандарт, хэмжил зүй гэсэн ойлголт байна, хэмжил зүй гэдэгт яг юуг оруулж тооцох вэ?

- Хэмжил зүй, стандартчилал нь бидний өдөр тутмын амьдралд маш чухал үүргийг гүйцэтгэдэг. Энэ хоёр нэр томъёо тодорхойлолттой байгууллага салшгүй холбоотой. Тэр дундаа хэмжил зүй гэдэг бол бид нарын хэмжлийн хэрэглээ болон шинжлэх ухааныг судалдаг үйл ажиллагаа юм. Хэмжил зүйг хүн бүр тэр болгон стандарт гэдэг үг шиг ойлгож үздэггүй. Гэтэл анх хүүхэд төрөхөд жин болон өндрийг үзэж, тухайн хүүхдийн эмчилгээг эхлүүлдэг. Үүнээс эхлээд бидний ажил, амьдрал бүхий л үйл ажиллагаанд хэмжил зүй нягт уялдаа холбоотой явдаг. Хэмжил зүй бол тэртээ 1923 онд нэг эрхлэгч, хоёр дархан гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй Сангийн яамны дэргэд алба болон байгуулагдаж байсан нь Орчин цагийн хэмжил зүй үүссэн. Монголчууд бид өнө эртний хэмжил зүйн чиглэлийн түүхтэй улс. Тодруулбал, Монгол гэрээрээ хэдэн цаг минут болж байна гэж цаг минутаа тодорхойлдог. Мөн цаг уурын хэмжил гэх мэт хэмжлийг шинжиж, тодорхой аж ахуй амьдралдаа зохицуулаад ирсэн нь хэмжил зүйг аль эртнээс хэрэглэж ирсэн уламжлалтай ард түмэн юм.

► Стандартыг мөрдөгдөхгүй байна гэдэг асуудал их гарч байна. Энэ нь төр, аж ахуйн нэгж, иргэн

хоорондын уялдаа холбоо хамааралтай юу? Хамгийн их алдаа хаанаа гардаг вэ?

- Олон улсын стандартыг Монголд нутагшуулсан 6600 гаруй стандарт Монгол улсын үндэсний стандартаар батлагдсан байна. Эдгээрийн 43 хувь нь олон улсын жишигт нийцсэн стандарт. Олон улсын стандартын байгууллага /ISO/-ийн стандарт нь дэлхийн 160 гаруй улс орны стандартын байгууллагыг нэгтгэсэн саналыг нь авч тусгасан ерөнхий шаардлагыг тогтоосон баримт бичиг. Гэтэл Монгол улсын хэмжээнд нутагшуулна гэдэг нь манай оронд нийцэж байна уу, эс нийцэх үү үнд анхаарч ажиллахаас гадна төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэдэд нийцэж байж тэр стандартын хэрэгжилт хангана гэж үздэг. Хэмжил зүйгээр бол хүнсний бүтээгдэхүүн эрүүл ахуй нь хүний биед шаардлагыг хангаж байна уу, эс хангаж байна уу гэдгийг стандартаар тогтоосон хэм хэмжээг тогтоохдоо хэмжил зүйн үзүүлэлтээр, хэмжлийн үр дүнгээр тогтоодог. Хэмжил зүй өөрөө чадварлаг чадамжтай байх ёстой. Мөн сорилт туршилтын шинжилгээ хийдэг үзүүлэлт болгоныг хэмжиж чаддаг чадамжтай байх нь зүйтэй юм. Гэтэл манай зарим сорилт туршилт хийж байгаа лабораториудын хувьд хүчин чадал дутмаг. Үүнээс үүдэн хүний биед хортой бодисуудыг илрүүлж чадах чадамж болон бүх үзүүлэлтүүдийг шалгаж чадахгүй байна.

ХЭМЖИЛ ЗҮЙГЭЭР БОЛ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН ЭРҮҮЛ АХУЙ НЬ ХҮНИЙ БИЕД ШААРДЛАГЫГ ХАНГАЖ БАЙНА УУ, ЭС ХАНГАЖ БАЙНА УУ ГЭДГИЙГ СТАНДАРТААР ТОГТООСОН ХЭМ ХЭМЖЭЭГ ТОГТООХДОО ХЭМЖИЛ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТЭЭР, ХЭМЖЛИЙН ҮР ДҮНГЭЭР ТОГТООДОГ.

Тэгвэл Монгол Улсын Засгийн газраас Стандарт, хэмжил зүйн салбар болон сорилт туршилтын шинжилгээний лабораториудад онцгой анхаарч байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс ч хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэл, өөрсдийн аж үйлдвэрээ хөгжүүлэх чиглэлээр онцгой анхаарч тодорхой арга хэмжээ авч байна. Ингэснээр стандартад заасан үзүүлэлтүүдийг л тодорхойлох, сорилт туршилт, хэмжил зүйн чадамжийг дээшлүүлэх нэн шаардлагатай гэж үзэж эхэлсэн.

► Стандарт, хэмжил зүйн газар нь Монгол Улсын 21 аймагт салбар хэлтэстэй үндэсний хэмжээний байгууллага мөн Монгол Улсын Засгийн газрын агентлаг. Лаборатори, судалгаа шинжилгээ хийх, эрдэм шинжилгээний ажилтан, шинжээч, хэмжил зүйн мэргэжилтнүүд бэлтгэх, боловсон хүчнээ сургах энэ бодлогыг яаж хэрэгжүүлдэг юм вэ?

- Стандартын хэрэгжилтийг хангах түвшинд боловсон хүчний чадамжийг сайжруулах хамгийн гол анхаарлаа хандуулах асуудал мөн. Анх 1956 оноос хэмжил зүй үүсэж хөгжсөн цагаас эхлээд ардын засгаас хэмжил зүйн салбар, стандартын байгууллагыг чадавхжуулахад ОХУ хуучнаар Зөвлөлт холбоот Улсын өөрсдийн боловсон хүчнийг бэлтгэхээр материаллаг баазад тулгуурлаад хэмжил зүйн салбарын боловсон хүчний чадавхыг нэмэгдүүлж байсан. 1960-1990 он хүртэл уг системээр хүний нөөцийг зохион байгуулж ирсэн. ОХУ нь тухайн үеийн социалист орнууд Чех, Герман, Болгар зэрэг улс орнууд боловсон хүчнийг чадавхжуулах чиглэлээр системтэй, шат дараатайгаар авч хэрэгжүүлж байлаа. Харин 1990 оноос хойш хэмжил зүйн боловсон хүчнийг бэлтгэхэд их дээд сургуулиуд хэмжил зүйн чиглэл болон ялангуяа сорилт туршилтын чиглэлийн нарийн мэргэжилтнүүдийг бэлтгэдэг систем алдагдалд орсон. Ингээд бид олон улсын чиг хандлага, олон улсын стандарт зарчимд нийцүүлэн бэхжүүлэх, сайжруулах чиглэлээр онцгой анхаарал хандуулан ажиллаж байна. Их дээд сургуулиуд хэмжил зүйн боловсон хүчин, чанарын дэд бүтэц, стандартчилал тохирлын үнэлгээ, хэмжил зүйн итгэмжлэл сорилт туршилтын лабораториудын боловсон хүчин хүний нөөцийг бэхжүүлэх, чадавхжуулах чиглэлээр магистр, бакалаврт энэ чиглэлийн хичээлүүдийг оруулдаг болгох, кредитүүдийг бий болгох зайлшгүй шаардлагатай болсон. Одоогийн байдлаар боловсон хүчин бэлтгэхдээ Монгол Улсын төлөөлөл СХЗГ-аас хэмжил зүйн Олон Улсын гишүүн орон, тэр дундаа Ази, Номхон далайн бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд боловсон хүчнээ сургаж, мэргэшүүлэх чиглэлээр хамтраад ажиллаж

байна. Манай байгууллага 100 жилийн түүхийг бичсэн байна. Дараагийн эрин зуунд хиймэл оюун ухаан, дижитал шилжилт, хэмжил зүй буюу чанарын дэд бүтэц чиглэл рүү алхах ёстой. Аж үйлдвэрлэлийн салбарыг түүчээлээд явахын тулд чанартай хэмжиж чаддаг байх, үйл ажиллагаанд стандартын хэрэгжилтэд анхаарал хандуулахад хэмжил зүйн үүрэг, сорилт туршилтын шинжилгээний үр дүн маш чухал үүрэгтэй гэж хэлмээр байна.

► Хэмжил зүйн тоног төхөөрөмж, боловсон хүчний чиглэлээр хамгийн өндөр хөгжилтэй улс орнууд гэвэл ямар орон байна?

- Дэлхийн улс орнуудаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын РТВ буюу Физик технологийн хүрээлэн олон улсад хэмжил зүйн хөгжил, чиг хандлагыг тодорхойлж, Улс орнуудыг түүчээлэн хөгжүүлж яваа хэмжил зүйн байгууллага юм. Мөн Ази Номхон далайн хэмжил зүйн байгууллага болон Япон, Солонгос, Хятад, Австрали, Тайланд зэрэг гишүүн орнуудтай нягт хамтын ажиллагаатай ажилдаг. Олон улсын түвшний Ази Номхон далайн хууль эрхийн хэмжил зүйн гишүүнээр 1998 онд элсээд, 1875 онд дэлхийн 17 улс орны харилцан хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан метрийн хэлэлцээрт 2013 онд нэгдэж орсон. Ач холбогдол нь Монгол Улсаас гарч буй экспортын бүтээгдэхүүнд хэмжил зүйн нэгдмэл байдал хангагдаж байна гэсэн нотлох баримтын үйл ажиллагаа. Бусад улс орон хэмжил зүйн чиглэлээр эталон тоног төхөөрөмжийн чадамж болон хэрэглэгчийн хэмжих хэрэгсэл цахилгааны тоолуур, усны тоолуур, жин хэмжүүр гэх мэт хэмжих хэрэгслүүдийн нэгж дамжуулалтыг хэрхэн хангаж байна энэхүү чадамжаараа дэлхий нийтээрээ олон улсын харьцуулалт, лаборатори хоорондын харьцуулалтын үзүүлэлтээр өрсөлддөг. Энэ чиглэлийн масс, цахилгаан, уртын хэмжлийн төрлөөр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байна. Монгол Улс 200 гаруй Улс орнуудтай ижил түвшний чадамж, үр дүнгээ хүлээн зөвшөөрүүлсэн гэдгийг дахин дуулгахад таатай байна. Цаашид температур, нягт, даралт, эзлэхүүн, гэрэлтүүлэг, акустик гэх мэт чиглэлийн эталон тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, лабораторийн байгууламжийг барих, боловсон хүчнийг бэлтгэх, арга аргачлалыг сайжруулах зэрэг ажлууд хүлээгдэж байна.

ИХ ДЭЭД СУРГУУЛИУД ХЭМЖИЛ ЗҮЙН БОЛОВСОН ХҮЧИН, ЧАНАРЫН ДЭД БҮТЭЦ, СТАНДАРТЧИЛАЛ ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭ, ХЭМЖИЛ ЗҮЙН ИТГЭМЖЛЭЛ СОРИЛТ ТУРШИЛТЫН ЛАБОРАТОРИУДЫН БОЛОВСОН ХҮЧИН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ, ЧАДАВХЖУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР МАГИСТР, БАКАЛАВРТ ЭНЭ ЧИГЛЭЛИЙН ХИЧЭЭЛҮҮДИЙГ ОРУУЛДАГ БОЛГОХ, КРЕДИТҮҮДИЙГ БИЙ БОЛГОХ ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ БОЛСОН.

► Хөгжил дэвшлийн үндэс нь стандарт. Стандартыг хэрэгжүүлэхийн тулд хэмжил зүй алдаатай байж болохгүй гэлээ. Салбар 21 аймгийн хэлтсүүдэд ямар асуудалд тулгарч байна, бэрхшээл гарч байна уу?

- Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль 1994 онд батлагдсан. Уг хуульд орон нутгийн салбар хэмжил зүйн байгууллагуудын чадамжийг дээшлүүлэх, бий болгох чиглэлээр онцгой анхаарал хандуулдаг. Бид 100 жилийн ойгоо угтан 2023 онд Говьсүмбэр аймагт хэлтсээ байгуулснаар 21 аймаг бүрд хэлтэстэй боллоо.

Орон нутгийн хэлтсүүд 1995 оны хэмжих хэрэгслийн баталгаажуулах ажлыг голчлон хийж байна. 2019 онд Хэмжил зүйн тухай хууль шинэчлэн батлагдсан. Энэ хуулиар орон нутагтаа заавал улсын баталгаажуулалтад хамрагдах хэмжих хэрэгслүүд болон хүний эрүүл мэнд аюулгүй байдлыг хангах, улсын батлан хамгаалах, байгаль орчныг хамгаалах гэх мэт хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой зайлшгүй төрийн хяналтад байх хэмжих хэрэгслүүдийг заавал баталгаажуулах хэмжих хэрэгслүүдийг орон нутагт чадавхжуулаад явж байна.

Орон нутагт ч гэсэн боловсон хүчин, ажиллах хүчин дутагдалтай хэвээр байна. 21 аймгийн мэргэжилтнүүд нэг аймагт 2-3 мэргэжилтэн 4-5 хэмжлийн төрлөөр улсын шалгагч хийдэг. Тодруулбал, Механикийн буюу жин хэмжүүр массын шалгагч нь шатахуун түгээгүүр, усны тоолуурыг шалгаж баталгаажуулах ажлыг давхар хийж байна. Өнөөгийн нөхцөл байдалд тохируулан СХЗГ-аас жил болгон хуваарь гарган улсын шалгагч нарыг бэлтгэх, улсын шалгалт тохируулгын ажилтан буюу эталон тоног төхөөрөмж /эталон гэдэг нь баримт бичиг, стандарт, хэмжил талаасаа хамгийн өндөр нарийвчлалтай хэмжих хэрэгслийг хэлнэ/ ажилтнуудын сургалтуудыг зохион байгуулан ажиллаж байна.


ОРОН НУТАГТ Ч ГЭСЭН БОЛОВСОН ХҮЧИН, АЖИЛЛАХ ХҮЧИН ДУТАГДАЛТАЙ ХЭВЭЭР БАЙНА. 21 АЙМГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮД НЭГ АЙМАГТ 2-3 МЭРГЭЖИЛТЭН 4-5 ХЭМЖЛИЙН ТӨРЛӨӨР УЛСЫН ШАЛГАГЧ ХИЙДЭГ.

► Гаднын улс орнууд хүний нөөц хангалттай бол 1-2 төрлөөр мэргэшүүлэх ёстой гэдэг, энэ нь танай салбарт хэр оновчтой вэ?

- Хэмжлийн төрөл болгон дотроо ангилагддаг. Энэ нь ганцхан усны тоолуур, шатахуун түгээгүүрийг дагнасан байна. Гэтэл бид эзлэхүүний шалгагч нь жин хэмжүүрийг шалгадаг гэх мэт боловсон хүчний дутмагаас хамаараад хэд хэдэн хэмжлийн төрлийг давхар хийж байна. Уг нь хэмжлийн төрөл болгоноор дагнасан байвал хэмжил зүй хөгжих, хэмжлийн үр дүнгээрээ үнэн зөв зааж байна гэдгийг тодорхойлсноор улсын шалгагч нарын чадамж, ажлын ачаалал зэрэг нь зөв явах юм.

► Ярилцсанд баярлалаа. Танд цаашдын ажилд нь амжилт хүсье.





ЯРИЛЦЛАГА

Д.ДАМБАСҮРЭН

Хэмжил зүйн хүрээлэнгийн дарга

Монгол Улс 11 улсын болон анхдагч эталонтой, Хөгжингүй улс орнууд 600-1000 гаруй эталонтой байна

Улаанбаатар хотноо Хэмжил зүйн чиглэлээр туршлага солилцох уулзалт, семинар болон нөхөрсөг Хөл бөмбөгийн тоглолтыг зохион байгуулсан, мөн 11-р сард манайхаас төлөөлөл БНСУ-д очиж хамтын ажиллагааны санамж бичгээ сунгаж, Эталон эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Эталоны лабораторийн үйл ажиллагаатай танилцаж, цаашлаад Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эталон эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг Монгол улсад хөгжүүлэх, туршлага судлах ажлуудыг амжилттай хэрэгжүүлээд ирсэн.

▶ Засгийн газарт бодлого хөтөлбөртөө өөрчлөлт оруулахаар өргөн барьсан байгаа гэлээ. Энэ өөрчлөлт орсноор ямар чиглэлээр өөрчлөлт орж ахисан түвшинд хүрэх бэю

- Манай Стандарт хэмжил зүйн салбарын гол үйл ажиллагаа нь Хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, хүний эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бий болгох, бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулахад гол зохицуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг юм.

Олон улсын нэр, томьёо, тодорхойлолтоор бол үүнийг “Үндэсний чанарын дэд бүтэц” гэж хэлдэг. Энгийнээр хэлбэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулахад Стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээний бодлогоор үйл ажиллагаагаа сайжруулснаар иргэд, аж ахуй нэгж байгууллагууд хэвийн чанартай үйл ажиллагаагаар хангагдах нөхцөл бүрдэж, амьдралын чанар дээшилнэ гэж ойлгож болно.

▶ Хэмжил зүйн стандарт гэдэг нь...

- Хэмжил зүйн үйл ажиллагаа гэдэг нь маш олон төрлийн цогц үйл ажиллагаа юм. Жишээ нь: Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт, шалгалт тохируулга, загварын туршилт гээд тус тусдаа үйл ажиллагаа бөгөөд батлагдсан стандартын дагуу явуулдаг.

Монгол улсад мөрдөж байгаа 6600 гаруй стандартаас яг хэмжил зүйн чиглэлийн 260 гаруй стандарт байна.

Үндэсний хэмжээнд үйлдвэрлэл, технологи, инноваци нэвтэрч, эдийн засгийн өсөлт, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ өсч хөгжихийн хирээр мөрдөж буй 260 гаруй стандартыг богино хугацаанд шинэчлэх, эсвэл олон улсын стандартыг үндэсний болгон орчуулж батлуулах шаардлага тулгардаг.

Энэ үйл ажиллагаа болон хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангахын тулд Шинжлэх ухааны байгууллага, их дээд сургуулиудын ахисан түвшний судлаач нарыг стандарт орчуулах, боловсруулах, батлуулах үйл ажиллагаанд татан оролцуулан хамтарч ажилласнаар богино хугацаанд Олон улсын түвшинд хүрсэн стандартуудыг боловсруулж батлаад хэрэглэгчид, аж ахуйн нэгжүүд мөрдөх, ашиглах боломжтой болно.

▶ Стандартуудаа ойр ойрхон өөрчилж шинэчлэхгүй бол өөрсдөө техник төхөөрөмжөөсөө хоцрох гээд байдаг гэж байна. Хяналт шалгалт хийгээд явж байхад тулгамдаг гол асуудал юу байна?

- Хэмжил зүйн хүрээлэнгийн хувьд бол сүүлийн 20 гаруй жил олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд улсын эталон, анхдагч эталонуудаа бий болгоод олон улсад хүлээн зөвшөөрүүлэх ажлыг шат дараатай төлөвлөөд хэрэгжилтийг хангаад явж байна. Өнөөдрийн байдлаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гурван хэмжлийн төрөл байна. Үүнд: Масс, урт, цахилгааны хэмжлийн төрлөөр “Олон улсын жин хэмжүүрийн товчоо”-ны мэдээллийн санд албан ёсоор бүртгүүлсэн.

Энэ нь ямар ач холбогдолтой бэ гэхээр олон улсын худалдаан дахь техникийн саад тотгорыг бууруулахад хэмжил зүйгээр дэмжлэг үзүүлэх хүрээнд манай шалгалт тохируулгын гэрчилгээтэй бол дэлхийн 90 гаруй улс оронд шууд хүлээн зөвшөөрнө, дахин шалгалт тохируулгад хамруулахгүй ашиглаж болно, олон улсын худалдаа үйлчилгээнд маш үр дүнтэй, чухал ач холбогдолтой үйл ажиллагаа юм.

Монгол улсад ганцхан байдаг өндөр нарийвчлалтай эталонууд учраас өндөр өртөг зардалтай, улсын хөрөнгө оруулалтаар тендерээр авах гэхээр хууль, дүрэм журамтай нийцэж өгдөггүй, маш хүндрэлтэй байдаг.

▶ Манайд агаарын бохирдлыг шийдвэрлэхэд шаардлагатай хийн тоног төхөөрөмж, нөхцөлүүд бүрдсэн байна уу?

- Олон улстай харьцуулахад манай улс хангалтгүй явж байна. Хөгжлийнхөө түвшинд олон эталонуудыг бий болгоод стандартчилсан загвар, химийн бодис уусмалуудыг бий болгож байж эрүүл, аюулгүй ажиллаж, амьдрах нөхцөл нь бүрдэнэ гэсэн үг юм.

▶ Сүүлийн жилүүдэд төсөв санхүүгээр хэрхэн хангагдаж байна. Шинжлэх ухааны салбар, гол суурь хэсгүүд орхигдоод байна гээд байгаа тийм үү?

- Хамгийн тулгамдаж буй асуудал бол хүний нөөц, боловсон хүчний асуудал, ажиллах орчин нөхцөл, ашиглах шаардлагатай эталон, тоног төхөөрөмж, урвалж бодисоор сайн хангах шаардлагатай.

ОДООГИЙН БАЙДЛААР 8 ХЭМЖЛИЙН ТӨРЛИЙН 11 УЛСЫН БОЛОН АНХДАГЧ ЭТАЛОН АШИГЛАЖ БАЙНА. МАНАЙХТАЙ ОЙРОЛЦОО УЛС ОРНУУД БОЛОН ХӨГЖИНГҮЙ УЛС ОРНУУД БОЛОХ БНХАУ, БНСУ, ХБНГУ ЗЭРЭГ УЛСУУД 600-1000 ГАРУЙ УЛСЫН БОЛОН АНХДАГЧ ЭТАЛОНУУД, СТАНДАРТЧИЛСАН ЗАГВАРЫГ ХӨГЖҮҮЛЭЭД АШИГЛААД ЯВЖ БАЙНА.

Шинжлэх ухааны байгууллагууд, Төрийн байгууллагууд, мэргэжлийн байгууллагууд, ТББ-ын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, нэгдсэн зөв бодлогоор үйлдвэрлэлд болон зах зээлд нэвтрүүлэхэд төр засгаас маш сайн дэмжих шаардлага тулгарч байна.

▶ Стандарт хэмжил зүйн байгууллага олон улстай харьцуулахад ямар түвшинд байна бэ?

- Ази Номхон далайн хэмжил зүйн хөтөлбөр гээд 41 улс орны 61 гишүүн байгууллагууд байдаг. Монгол Улсын хэмжил зүйн байгууллага дундаас дээш түвшинд явж байгаа. Яагаад гэвэл шалгалт тохируулгын чиглэлээр улсын эталоны хэмжлийн шалгалт тохируулгын чадавхаа 2020, 2021, 2023 онуудад Олон улсын жин хэмжүүрийн товчоонд хүлээн зөвшөөрүүлсэн.

Энэ байгууллагын гол шалгуур үзүүлэлт нь хэмжлийн шалгалт тохируулгын чадавхаа олон улсад хүлээн зөвшөөрүүлсэн үү гэдэг дээр шаардлагаа тавьдаг.

Олон улсын худалдаан дахь техникийн саад тотгорыг бууруулснаар худалдаа, эдийн засаг сайжирч, үндэсний үйлдвэрлэгч экспортлогч нар дэлхийд гарах нөхцөл бүрдэнэ, энэ үр дүнгийн дагуу бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар сайжирна.

▶ Ярилцсанд баярлалаа. Танд цаашдын ажилд нь амжилт хүсье.



Стандарт, хэмжил зүйн газар органик бүтээгдэхүүнийг баталгаажуулж, гэрчилгээ олгож байна

Стандарт, хэмжил зүйн газар нь 2022 оноос эхлэн орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг “Органик бүтээгдэхүүн”-ээр гэрчилгээжүүлэх зорилт тавин, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын “Гурван борхууд” ХХК, Булган сумын “Тунамал өгөөж” ХХК, Хангал сумын Хялганат тосгоны “Сүргийн нуга” ХХК, Сэлэнгэ аймгийн ХХК-уудын хүсэлтийн дагуу органик бусаас органик үйлдвэрлэлд шилжих гэрээ байгуулан ажиллаж, 2023 онд “Гурван борхууд” ХХК-ийн “Халтар арвайн гурил”, Булган сумын “Тунамал өгөөж” ХХК-ийн “Их шүүдэргэнийн цай”, Хангал сумын Хялганат тосгоны “Сүргийн нуга” ХХК-ийн “Зөгийн бал”, Сэлэнгэ аймгийн “Пермакултур хөгжил” ХХК-ийн “Цэцэг” нэрийн зөгийн балын үйлдвэрлэлд органик хүнсний баталгаажуулалтын үнэлгээг Булган, Сэлэнгэ аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэстэй хамтран явууллаа.

Стандарт, хэмжил зүйн газраас Булган аймгийн Хутаг өндөр сумын “Гурван борхууд” ХХК-ийн “Халтар арвайн гурил”, Хялганат тосгоны “Сүргийн нуга” ХХК-ийн “Хялганат” нэрийн зөгийн бал бүтээгдэхүүнийг тус тус баталгаажуулж, органик хүнсний бүтээгдэхүүний гэрчилгээг олголоо. Тус гэрчилгээг аймгийн ИТХ-ын дарга Д.Эрдэнэбат, Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ, ХХААГазрын дарга Ч.Амгалан нарын хамт гардууллаа.

Баян-Өлгий аймаг “Халал” стандартаар тохирлын үнэлгээ хийж, баталгаажуулалтын гэрчилгээ олгох эрхтэй боллоо

Персийн булангийн итгэмжлэлийн төв (GAC)-ийн үнэлгээний баг 2023 оны 10 дугаар сарын 28, 29, 30-ны өдрүүдэд Баян-Өлгий аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэст ажиллаж, Итгэмжлэлийн анхдагч үнэлгээг тус хэлтсийн Халал баталгаажуулалтын албаны үйл ажиллагаанд нэвтрүүлж буй GSO 2055-2:2021 Тохирлын үнэлгээ-2 дугаар хэсэг: Халал баталгаажуулалтын байгууллагуудад тавих шаардлага стандартын дагуу хийлээ.

Баян-Өлгий аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн аудитын баг Халал менежментийн тогтолцооны анхдагч баталгаажуулалтын 2-р шатны аудитын үйл ажиллагааг батлагдсан төлөвлөгөөний дагуу 2023 оны 10 дугаар сарын 29 -ны өдөр “Азат” ХХК-ийн махны үйлдвэр болон “Акбоар” ХХК-ийн “Каз”-ны үйлдвэрт ажиллаж, халал аргаар мах бэлтгэх болон “Каз” боловсруулах үйл явцад нэвтрүүлж буй халал менежментийн тогтолцооны GSO 2055-1:2015 Халал хүнс - 1 дүгээр хэсэг: Ерөнхий шаардлага стандартын дагуу үнэлгээ хийлээ. Энэхүү үнэлгээ нь UNIDO Mongolia-НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллагаас хэрэгжүүлж буй тохирлын үнэлгээний байгууллагуудыг чадавхжуулах төслийн хүрээнд хийгдсэн.

Улмаар халал итгэмжлэлийн анхдагч үнэлгээ амжилтай явагдаж Персийн булангийн орнуудын Итгэмжлэлийн байгууллагаас GSO 2055-2:2021 - Халал хүнс. 1-р хэсэг. Халал баталгаажуулалтын байгууллагад тавих шаардлага стандартаар итгэмжлэлийн гэрчилгээг гардаж авлаа.

Бүтээгдэхүүний баталгаажуулалтын тоон мэдээ

Дотоодын бүтээгдэхүүний баталгаажуулалтын тоон мэдээ	
Аж ахуй нэгж	102
Нэр төрөл	300
Экспорт бүтээгдэхүүний баталгаажуулалтын тоон мэдээ	
Аж ахуй нэгж	216
Нэр төрөл	4352
Импорт бүтээгдэхүүний баталгаажуулалтын тоон мэдээ	
Аж ахуй нэгж	262
Нэр төрөл	330
Аюулгүйн тэмдэг баталгаажуулалтын тоон мэдээ	
Аж ахуй нэгж	2
Нэр төрөл	11

Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын мэдээ

Гэрчилгээжсэн аж ахуйн нэгжийн тоо **290**

Менежментийн тогтолцооны төрлөөр ангилбал

ISO 9001	232
ISO 22000	17
ISO 45001	17
ISO 14001	8
ISO 50001	1
HACCP	16
Органик бүтээгдэхүүн	1



ЯРИЛЦЛАГА

В.ГАНЗОРИГ

Бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын газрын дарга

Халал болон органик хүнсийг баталгаажуулах олон улсын итгэмжлэлийн үнэлгээнд хамрагдаж, гэрчилгээ авсан

▶ Стандарт гэж юу вэ, Монгол Улсад хэчнээн стандарт байдаг вэ?

- Стандарт гэдэг бол хэм хэмжээ, амьдралын зөв дадал, арга хэрэгсэл юм. Монгол улсад 6600 гаруй стандарт мөрдөгдөж байна. Стандарт, хэмжил зүйн газар нь Салбар, салбарын боловсруулсан стандартуудыг техникийн хороогоор хэлэлцүүлж, баталдаг.

▶ Стандарт, хэмжил зүйн газар 21 аймагт үйл ажиллагаа явуулдаг уу?

- Манай байгууллага 21 аймагт салбартай, аймаг бүрд Стандарт, хэмжил зүйн хэлтэс үйл ажиллагаа явуулдаг. 2023 оны 1 сарын 1-нээс МХЕГ-ын чиг үүрэг өөрчлөгдсөнтэй холбогдуулан төв, орон нутгийн МХГ-ын харьяанд байсан лабораториуд, нийслэлийн төв лаборатори болон Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори СХЗГ-ын харьяанд шилжин ирсэн.

▶ Танай газрын хувьд ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?

- Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газраас бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулж, тохирлын гэрчилгээг олгодог. Мөн олон улсын менежментийн тогтолцооны стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хэрэгжүүлсэн байдалд аудит хийж, гэрчилгээжүүлдэг.

▶ Стандарт, стандарт гээд л байдаг, стандартын нөхцөл байдал, хэрэгжилт хэр байгаа бэ?

- Монгол улсад 6600 гаруй стандарт байгаагаас 43 хувь нь олон улсын стандартын түвшинд хүрсэн. Олон улсын стандартын түвшинд хүрсэн үндэсний стандартын хувийг нэмэгдүүлэх зорилт тавин ажлын төлөвлөгөөнд ороод холбогдох байгууллагууд нь ажиллаж байна.

Стандартгүй гэж ярьж болохгүй, хангалттай тооны стандарт байна, харин стандартыг хэрхэн хэрэгжүүлэх,

хэн хяналт тавих бэ гэдэг асуудал хэвээр байсаар байна. Төрийн байгууллагуудад зөвхөн хяналтын чиг үүргийг оноогоод байгууллагууд стандартыг хэрэгжүүлнэ гэж үзвэл өрөөсгөл. Учир нь иргэд стандартын талаар ойлголт мэдээлэлтэй болж, стандартыг шаарддаг, нэхдэг болж байж стандарт хэрэгжинэ. Ингэж бие биедээ стандартын шаардлагыг тавьж, хангаснаар эрүүл, аюулгүй баталгаатай орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ. Ер нь стандарт бол хөгжлийн түлхүүр юм.

▶ Тохирлын гэрчилгээний талаар?

- Тохирлын гэрчилгээ гэдэг нь стандартын шаардлагыг хангасныг нотолж өгч байгаа баримт бичиг. Гэрчилгээг дагалдуулаад баталгаагүй бүтээгдэхүүнээс ялгах зорилгоор баталгаажуулалтын гэрчлэх тэмдгийг аж ахуй нэгжүүдэд өгдөг. Аж ахуйн нэгжүүд тухайн тэмдгийг бүтээгдэхүүнийхээ хаяг шошгод байршуулах ёстой. Ингэснээр иргэд ижил төрлийн 10 талхнаас сонголт хийхдээ хаяг шошгоос нь баталгаажуулалтын тэмдэг байгаа эсэхийг хараад сонголтоо хийх боломжтой. Баталгаажуулалтын тэмдэггүй бол мэргэжлийн байгууллага ажиллаагүй, баталгаа гаргаагүй, стандартын шаардлага хангасан эсэхээ нотлуулаагүй л гэсэн үг. Тохирлын гэрчилгээг итгэмжлэгдсэн хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллага олгодог хуулийн зохицуулалттай.

ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ ГЭДЭГ НЬ СТАНДАРТЫН ШААРДЛАГЫГ ХАНГАСНЫГ НОТОЛЖ ӨГЧ БАЙГАА БАРИМТ БИЧИГ. ГЭРЧИЛГЭЭГ ДАГАЛДУУЛААД БАТАЛГААГҮЙ БҮТЭЭГДЭХҮҮНЭЭС ЯЛГАХ ЗОРИЛГООР БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧЛЭХ ТЭМДГИЙГ АЖ АХУЙ НЭГЖҮҮДЭД ӨГДӨГ.

▶ Ямар бүтээгдэхүүнийг заавал баталгаажуулалтад хамруулах ёстой вэ?

- Засгийн газрын 291 дүгээр тогтоолоор тохирлын гэрчилгээтэй байх бүтээгдэхүүний жагсаалтыг баталж өгсөн. Энэ жагсаалтад 644 нэр төрлийн бүтээгдэхүүнийг тохирлын баталгаанд заавал хамруулахаар зохицуулж өгсөн. Жагсаалтыг хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, улс орны аюулгүй байдал хохирол учруулж болзошгүй, өндөр эрсдэлтэй гэж үзэж Засгийн газраас баталсан юм. Улс орнууд ард иргэдийнхээ эрүүл мэнд, амь нас, байгаль орчноо хамгаалахын тулд өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүнийг тодорхойлж, заавал тохирлын баталгаанд хамруулж тохирлын гэрчилгээ олгодог.

▶ Танай байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээнийхээ талаар хэрхэн олон нийтэд хүргэдэг вэ?

- Манай байгууллага байнгын нэг цэгийн үйлчилгээ ажиллуулдаг. Мөн өөрсдийн чиглэлээр төлөвлөгөөт болон захиалгат олон сургалтуудыг нээлттэй зохион байгуулж байна. Түүнчлэн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албатай болсон. Энэ алба нь иргэдэд шаардлагатай

БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТЭМДЭГГҮЙ БОЛ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА АЖИЛЛААГҮЙ, БАТАЛГАА ГАРГААГҮЙ, СТАНДАРТЫН ШААРДЛАГА ХАНГАСАН ЭСЭХЭЭ НОТЛУУЛААГҮЙ Л ГЭСЭН ҮГ.

мэдээллийг тухай бүр олон нийтийн мэдээллийн суваг, албаны цахим хуудсаар хүргэж байна.

▶ 2023 онд хэрэгжүүлсэн ололт амжилтын талаар?

- 2023 онд манай байгууллагын түүхт 100 жилийн ой тохиосон. Энэ хүрээнд олон арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. Тодруулбал, өнгөрсөн 11 дүгээр сард Дэлхийн чанарын өдөр тохиодог. Дэлхийн чанарын өдрийг 2015 оноос хойш “Үндэсний чанарын чуулган” болгон цар хүрээг нь өргөжүүлсэн бөгөөд энэ чуулганы үеэр чанараар тэргүүлэн ажиллаж байгаа компаниуд туршлагаа хуваалцах, чанарын шагналыг шилдэг үйлчилгээ, бүтээгдэхүүн, аж ахуйн нэгж гэсэн 3 номинациар шалгаруулж Засгийн газраас “Үндэсний чанарын шагнал”-ыг олгож байна.

Мөн 100 жилийн түүхэн ойд зориулж ном хэвлүүлсэн. Анх 1923 оноос хойш СХЗГ нь ямар нэртэй үүсгэн байгуулагдсан, ямар үйл ажиллагаа хийдэг байсан, 100 жилийн хугацаанд нийгэм, эдийн засагт эерэг үр дүн үзүүлсэн ажлууд болон ямар түүхэн шийдвэрүүдийг гаргаж байсан талаар дурдаж, Монгол улсын Стандарт, хэмжил зүйн байгууллагын шинэчлэлийн талаар өгүүлсэн сайхан ном бүтсэн.



Энэ жил бид баталгаажуулалтын чиглэлээр ХАЛАЛ болон органик хүнсийг баталгаажуулах Олон улсын итгэмжлэлийн үнэлгээнд анх удаа амжилттай хамрагдаж, гэрчилгээжсэн түүхэн амжилтуудаар дүүрэн он байсныг онцлон тэмдэглэе.

▶ Ярилцсанд баярлалаа. Танд цаашдын ажилд нь амжилт хүсье.

Сорьцын хяналтын газрын ажил үйлчилгээ 2023

1 Төв болон орон нутгийн үнэт металлын сорьц тогтоох лабораторид 2023 онд давхардсан тоогоор нийт 1825 аж ахуйн нэгж, иргэний 10,331.4 кг үнэт металлыг хүлээн авч хайлж гулдмайлан дугаарлаж, хайлалтын актыг үйлдэж, үйлчилгээ үзүүлсэн.

2 Төв болон орон нутгийн үнэт металлын сорьц тогтоох лабораторид 2023 онд давхардсан тоогоор 127 аж ахуйн нэгж, иргэний 4157 алтан гулдмай, 3 аж ахуйн нэгжийн 671 мөнгөн гулдмай, 97 аж ахуй нэгж, иргэний үйлдвэрлэсэн болон импортоор оруулж ирсэн нийт 1335 алтан эдлэл, 112 аж ахуйн нэгж, иргэний 1049 мөнгөн эдлэлд MNS ISO 11427:2017 шинжилгээний аргын стандартыг ашиглан химийн шинжилгээ хийсэн.

3 Дотоодын үйлдвэрийн болон импортоор орж ирсэн 112 аж ахуйн нэгж, иргэний

82,151

алтан эдлэл,

56,186

МӨНГӨН ЭДЛЭЛД

сорьцын баталгааны тэмдэг дарж баталгаажуулсан.

4 Байгууллага, иргэний эрдэний чулуу, тэдгээрээр хийсэн эдлэл, чулууны түүхийг эдийг тодорхойлж 438 аж ахуйн нэгж, иргэнд үйлчилгээ үзүүлж 1684 эрдэнийн чулуунд гэрчилгээ олгосон.





ЯРИЛЦЛАГА

Д. БЭХБАТ
Сорьцын хяналтын газрын дарга

Сорьц нь металмын хайлшин дахь үнэт металмын агууламжийг тодорхойлж буй үйл явц

► Сорьцын хяналтын газар юу хийдэг вэ? Бид сорьцын хяналт гэдэгт ер нь юуг ойлгох ёстой юм вэ? Жишээ нь үнэт металл, үнэт эдлэл гээд л бид нар ярьдаг. Энэ нь сорьцын тухай ойлголт уу?

- Стандарт, хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын газар нь Монгол Улсын нутаг дэвсгэрт олборлосон үнэт металмын сорьц тодорхойлох, үнэт металл хийсэн эдлэл, эрдэнийн чулуун эдлэлийн сорьц чанарыг тогтоох чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн байгууллага. Мөн эрдэнийн чулууг тодорхойлж, гэрчилгээ олгодог. Энгийнээр хэлбэл Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж тухайн бүтээгдэхүүний үнэн зөв эсэхийг нь тодорхойлж өгч байгаа хэрэг юм.

Үнэт металл хийсэн эдлэл дээр “сорьц” гэдэг хэмжигдэхүүнийг хэрэглэдэг. Сорьц гэдгийг бол тухайн металмын хайлшийг мянган нэгж гэж үзэх юм бол хэд нь үнэт металл юм бэ гэж агуулгыг нь тодорхойлж байгаа үйл явц юм. Үнэт металл, тэдгээрээр үйлдвэрлэсэн гоёл чимэглэлийн эдлэлд химийн шинжилгээ хийж, сорилтын үр дүнгээ үндэслэлд тухайн эдлэлд сорьцын баталгааны тэмдэг дарж өгдөг.

999-н сорьцтой алт, 960-тай алт, 585-тай алт, 925-н сорьцтой мөнгө гэж сонсож байсан байх, Энэ бол тухайн

үнэт металмын агуулгыг мянган нэгжээр илэрхийлээд хэлж байгаа юмаа гэдгийг хэрэглэгч, уншигчид маань ойлгоно байх.

► Үнэт металл гэдгийг жаахан тодруулж хэлбэл?

- Эрдэнэсийн сангийн тухай хууль, Засгийн газрын 281-р тогтоолоор батлагдсан журмын 6-д Үнэт металл, Эрдэнийн чулууны ангиллыг баталсан бөгөөд энэхүү ангиллаар алт, мөнгө, платина, палладий, иридий, родий, рутений, осмий гэсэн найман металлыг (олон улсын түвшинд ч мөн адил) үнэт металл гэж үздэг, Бидний хамгийн сайн мэдэх алт, мөнгө юм. Зарим тохиолдолд платиныг цагаан алт гэж орчуулан хэрэглэж байгаа нь буруу ойлголт. Олон Улсын худалдааны практикт ангиар white gold, оросоор белое золото гэж ярьдаг нь шар алтны нэг төрлийн хайлшны нэр юм. Платина нь алтнаас 30-40 хувиар илүү үнэтэй байдаг тул зөв ойлгож хэрэглэх нь чухал.

► Үнэт металл хийсэн эдлэлийг бараг хүн болгон хэрэглэж байна. Монголчуудын хувьд харьцангуй эрт дээр үеэс үнэт эдлэлийг хэрэглэж байсан гэж түүхчид хэлдэг шүү дээ?

- Монгол эр хүн ямар ч байсан нэг удаа өөртөө унаа залгуулах хэмжээний үнэт эдлэл, хөөрөг, мөнгөн тоногтой хэт хутга, хаш соруултай гаансыг биедээ авч явдаг байсан гэдэг. Энэ бол бидний давтагдашгүй “Өв соёл” юм. Аливаа бараа бүтээгдэхүүнд тухайн бүтээгдэхүүнийг тодорхойлох чанарын үзүүлэлт байдаг. Тухайлбал хоол хүнсэнд илчлэг, уураг, амин дэм гэж ойлголтууд байдагтай ижил үнэт металл хийсэн эдлэл дээр сорьц гэж чанарын гол үзүүлэлт байдаг. Хэрэглэгчид сорьцын баталгаатай бараа бүтээгдэхүүнийг, хаяг байршил тодорхой, буух эзэн, буцах хаягтай газраас худалдаж авч байгаарай гэдгийг зөвлөж байна.

► Таны ярианы эхэнд Үнэт чулууг шинжлээд судлаад гэрчилгээ олгох тухай яригдаад өнгөрсөн. Хөөрөг дотроо манан хөөрөг гэхэд халтар манан, усан манан гээд маш олон төрөл байдаг. Энэ юуг нь судална гэсэн үг вэ?

- Өмнө хэлсэн хууль, тогтоомжоор Эрдэнийн чулууг ангилсан, ангилал нь мэдээж олон улсын чиг хандлага, ангиллыг баримталж байгаа. Эрдэнийн чулууг үнэт чулуу, хагас үнэт чулуу, гоёл чимэглэлийн, өнгөлгөөний чулуу гэж 4 ангилдаг. Энэ ангиллын дагуу тухайн чулууг лабораторийн орчинд судлаад тодорхойлоод өгнө гэсэн үг. Үнэт чулуунд Доржпалам (Diamond), Маргад (Emerald), Бадмаараг (Ruby), Индранил (Sapphire), Сувад (Pearl) гэсэн 5 чулууг багтаан ойлгодог. Мана бол (Agate) Гоёл чимэглэлийн чулууны ангилалд багтдаг. Эрдэнийн чулууны гэрчилгээ бол тухайн эдлэл дээрээ л хүчин төгөлдөр.

Эрдэнийн чулууны гэрчилгээ нь тухайн эдлэлийн хэмжээстүүдтэй, өндөр, амсар, голч, тойрог, жин гэх мэт мэдээллийг агуулсан Шинжлэх Ухааны арга дээр суурилж тодорхойлсон байна. Энэ нь худалдах, худалдан авах 2 талд хоёуланд ойлгомжтой байх боломжийг тэгш өгч буй хэрэг юм. Зах зээл дээр маш их хуурамч бүтээгдэхүүн бий. Дуураймал, мөнгөтэй төстэй металл хийсэн

МОНГОЛ УЛС ХЭМЖЛИЙН НЭГЖИЙН “СИ” СИСТЕМИЙГ ХЭРЭГЛЭДЭГ. КАРАТ(К) ГЭДЭГ ХЭМЖИГДЭХҮҮНИЙГ ИХЭВЧЛЭН ГОЁЛ ЧИМЭГЛЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ДЭЭР ЯРИГДДАГ БӨГӨӨД 1-24 КАРАТ ХЭРТЭЛ ХЭМЖЭЭТЭЙ, 24 К НЬ 999,9 СОРЬЦТОЙ ТЭНЦДЭГ. ҮҮНИЙГ ЧУЛУУНЫ CARAT(ЖИН) АДИЛ ОЙЛГОХ НЬ БУРУУ.

эдлэлийг мөнгө гэж зарах, алмаз зэрэг үнэт чулууг лабораторийн орчинд тарьж ургуулаад байгалийн алмаз гэх зэрэг олон асуудлууд бий. Ерөнхийдөө практикт чулуу үнэлэх хамгийн гол 4 шалгуур үзүүлэлтийг 4с /дөрвөн си/ гэдэг бөгөөд энэ нь Clarity (Тунгалагшилт), Color (Өнгө), Carat (Жин), Cut (Засалт) үзүүлэлтийг баримталдаг. Монгол Улсад Үнэт металл хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдан борлуулж буй 100 гаруй иргэн, аж ахуйн нэгж байгаа.

► Карат, лан, цэн, пун гэх ойлголтууд ижил үү? Эсвэл хүмүүс буруу ойлгоод байна уу?

- Өнөөдөр иргэд алт, мөнгөний хэмжээний талаар ярихдаа лан, цэн, пун гэсэн хэмжигдэхүүн хэрэглэдэг байдаг. Энэ нь Хятад нэр томьёо бөгөөд Монгол Улсын хэмжлийн нэгжээс 1950-иад онд хасагдаж хэрэглэгдэхээ больсон. Монгол Улс Хэмжлийн нэгжийн “Си” системийг хэрэглэдэг. Карат (к) гэдэг хэмжигдэхүүн ихэвчлэн гоёл чимэглэлийн бүтээгдэхүүн дээр яригддаг бөгөөд 1-24 карат хэртэл хэмжээтэй, 24 к нь 999,9 сорьцтой тэнцдэг. Үүнийг чулууны Carat (Жин) адил ойлгох нь буруу.

► Ярилцсанд баярлалаа. Танд цаашдын ажилд нь амжилт хүсье.



Нийслэлийн лабораторийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа

Нийслэлийн лаборатори нь Нийслэлийн хүн амыг хүнсээр хангаж буй үйлдвэр, үйлчилгээ, хоол үйлдвэрлэлийн газруудын бүтээгдэхүүн, хүн амын ундны ус, Туул болон салбар голуудын ус, хэрэглээнээс гарч буй бохир ус, хөрсний ус, Нийслэлийн нутаг дэвсгэрийн хөрсний бохирдолтын байдалд эрүүл зүйн хими, хор судлал, микробиологийн шинжилгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлж байна. Налайх, Багануур дүүрэг дэх салбар лабораториуд мөн энэ үүргийг хэрэгжүүлдэг.

Энэ онд хийгдсэн гол ажлуудын нэг нь “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавигдах ерөнхий шаардлага ISO/IEC 17025:2018” стандартын дагуу итгэмжлэлийн гэрчилгээгээ амжилттай сунгууллаа. Ингэснээр лабораторийн үйл ажиллагааг 1997 оноос хойш 9 дахь удаагаа итгэмжлүүлж, 61 төрлийн бүтээгдэхүүнийг 1215 үзүүлэлтээр шинжлэх чадамжаа баталгаажуулав.

Тайлант хугацаанд лабораторийн үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах чиглэлээр санаачлага гарган ажиллаж, “Лабораторид дээж хүлээлгэн өгөх, лабораторид дээж хүлээн авах, шинжилгээний дүнг олгох, төлбөр барагдуулах үйл ажиллагаанд мөрдөх журам”, “СХЗГ-ын баталгаажуулалтын ажил, үйлчилгээ, хэмжил зүйн салбарын ажил үйлчилгээ, үнэт металлын сорьц тогтоох, эрдэнийн чулуу тодорхойлох ажил үйлчилгээ, лабораторийн шинжилгээ хийх ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох аргачлал” зэргийг шинэчлэн батлууллаа.

ISO 660:2003 Амьтан ургамлын гаралтай өөх ба тос. Хүчлийн тоо, хүчиллэгийг тодорхойлох арга, MNS ISO 5550: Казейн болон казеин агуулсан бүтээгдэхүүний чийглэгийн хэмжээг тодорхойлох арга, “ISO 13720:2010, Мах, махан бүтээгдэхүүн. Pseudomonas spp-ийн тоог тоолох” стандартуудын нэмэлт өөрчлөлтүүдийг шинэчлэн орчуулж, Үндэсний стандартын санд хүлээлгэн өглөө.



Лабораториудад үүсэх эрсдэлийг бууруулснаар хүнсний аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах боломжтой

► Стандарт гэдэг ойлголт хүмүүст ойрхон юм шиг мөртлөө хол байдаг. Яагаад стандарт мөрдөх ёстой, стандарт нь хаана байна гэж асуудаг хүмүүс байдаг. Та стандартын гол ач холбогдлыг уншигчдад хэлж өгнө үү?

- Өнөөдрийн байдлаар Монгол улсад мөрдөгдөж байгаа 6608 стандарт байна. Хэдийгээр манай улсад стандартын тоо хангалттай байгаа хэдий ч стандартын хэрэгжилт, мөрдөлтийн хувьд бүрэн дүүрэн хангалттай биш байна. Лабораторийн хувьд үндэсний болон олон улсын стандарт арга аргачлалын дагуу шинжилгээгээ хийж гүйцэтгэдэг. “Эрсдэл ба стандарт” үндэсний форумд оролцоходоо лабораторийн шинжилгээний үр дүн яагаад чухал гэдгийг онцлохыг хүссэн. Учир нь хүнсний аюулгүй байдлыг хангахад лабораториудын чиг үүрэг их чухал юм. Жишээлбэл, таны хажууд байгаа савласан усыг уухдаа та нүдээрээ хараад “Энэ ус аюулгүй, эрүүл ус” гэж бодоод ууж чадах уу? Эсвэл хажуудаа байгаа 2 өөр төрлийн савласан уснаас сонгож уух хэрэгтэй боллоо гэхэд нэг нь лабораторийн шинжилгээний бичигтэй, нөгөөх нь шинжилгээний бичиггүй байлаа гэж бодоход аль савласан усыг авч уухыг бодох вэ? Мэдээж лабораторийн шинжилгээний бичигтэй савласан усыг сонгохыг бодно тийм үү. Тиймээс л лабораторийн шинжилгээний үр дүн нь хүнсний аюулгүй байдлын нэгээхэн чухал хэсэг гэдгийг ойлгох нь зүйтэй байгаа юм. Энэхүү энгийн жишээгээр лабораторийн чухал үүргийг ойлгуулахыг хичээлээ.

► Бидний идэж буй гурил, будаа, махыг шинжилсэн шинжилгээний бичигтэй байж л дэлгүүрт зарагдах ёстой? Сүүлийн үед иргэд арай өөр сонголт хийдэг боллоо. Зах, худалдааны төвөөс биш, супер маркетаас худалдаж авбал илүү баталгаатай гэж бодоод байна. Супер маркетад худалдаалагдаж байгаа бүх бүтээгдэхүүнийг лабораторийн шинжилгээнд хамруулдаг уу? Энэ талаар ямар арга хэмжээ авч анхаардаг вэ?



- Манай лаборатори бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүн, гоо сайхны болон ахуйн химийн бүтээгдэхүүн, эмнэлгийн дотоод халдварын шинжилгээ, хотын төвлөрсөн усан хангамжийн унд, ахуйн цэвэр ус, төв цэвэрлэх байгууламжийн бохир ус, хот орчмын булаг шанд, гүний худгийн ус, хөрс, атмосферийн болон ажлын байрны агаарт жилд дунджаар 20000-25000 гаруй сорьцод 60000-65000 гаруй үзүүлэлтээр шинжилгээг хийж, стандартын шаардлагад нийцээгүй /5-6%/ үзүүлэлтийг илрүүлж ажиллаж байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдийн хүсэлтээр тухайн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний дээжээ эрүүл, аюулгүй стандартын шаардлага хангаж буйг мэдэхийн тулд хүсэлтээрээ бүтээгдэхүүний дээжээ шинжилгээнд хамруулахыг хүсдэг. Шинжилгээний бичигтэй бүтээгдэхүүнээ тухайн дэлгүүр, супермаркетад өгдөг байх.

► Өнөө цагт хүнсний лабораториудын чадавх хэр байгаа вэ?

- Өнөөдөр хүнсний аюулгүй байдал алдагдаж байна гэж яригдаад байна. Тиймээ, хүнсний аюулгүй байдлыг

хангуулахад лабораториудын хүчин чадал, аюулгүйн үзүүлэлтийг үзэх чадавхын талаар ярих хэрэгтэй болно. Харамсалтай нь манай лабораторийн хувьд багаж, тоног төхөөрөмж хуучирч элэгдсэн, зарим нь түр ажиллагаагүй болсноос үүдэж лабораторийн шинжилгээний зарим үзүүлэлтийг хийх чадваргүй болох эрсдэл үүсээд байна. Харин лабораторийн багаж, тоног төхөөрөмжүүдийг нарийн мэдрэг орчин үеийн тоног төхөөрөмжөөр шинэчилж сайжруулснаар хүнснээс шалтгаалах аюулын эрсдэлийг бууруулна гэж харж байна.

Лабораториуд шинжилгээний үр дүнг аюулгүйн үзүүлэлтээр нэмэгдүүлэх нь чухал. Аюулгүйн үзүүлэлтийг бүрэн тодорхойлох нь маш чухал боловч 21 аймаг, нийслэлийн лабораторийн хүчин чадал өнөөдрийн байдлаар хангалттай түвшинд байж чадахгүй буюу олон улсын түвшинд хүрэхгүй үзэж чадахгүй байна. Аюулгүй үзүүлэлтийг шинжилж чадахгүй байгаа нь нэгдүгээрт, тоног төхөөрөмж хуучирсан, шинэчлэл хийгдээгүйтэй холбоотой. Хоёрдугаарт шинжилгээний эм урвалжийн хангалт бага, гуравдугаарт хүний нөөцийн дутагдал, нарийн мэргэших байдал хангалтгүй байна.

АЮУЛГҮЙ ҮЗҮҮЛЭЛТИЙГ ШИНЖИЛЖ ЧАДАХГҮЙ БАЙГАА НЬ НЭГДҮГЭЭРТ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХУУЧИРСАН, ШИНЭЧЛЭЛ ХИЙГДЭЭГҮЙТЭЙ ХОЛБООТОЙ. ХОЁРДУГААРТ ШИНЖИЛГЭЭНИЙ ЭМ УРВАЛЖИЙН ХАНГАЛТ БАГА, ГУРАВДУГААРТ ХҮНИЙ НӨӨЦИЙН ДУТАГДАЛ, НАРИЙН МЭРГЭШИХ БАЙДАЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

► Ерөнхийлөгчийн зүгээс Хүнсний хувьсгал гэж эхлүүлээд явж байна. Нэгэнт хүнс үйлдвэрлэж байгаа тохиолдолд хүнсээ шинжилж, аюулгүй байдлыг нотлох үүрэгтэй оролцогч нь лаборатори юм байна. Гэтэл лаборатори нь дэлхийн жишигт нийцсэн болохын тулд ямар шаардлагыг хангасан байх ёстой вэ? Энэ тал дээр танайх хүсэлт тавьсан уу? Дэлхийн лабораториуд цахим, тоон системд шилжиж, технологийн хувьд сайжирсаар хүний үйл ажиллагааг багасгасаар байна шүү дээ.

- Яг үнэн. Миний ярихыг хүссэн зүйлийг хөндсөнд баяртай байна. Жишээ нь манай лабораторийн өнөөгийн үйл ажиллагаа явуулж буй 2 давхар барилга, барилгын цахилгаан болон дулааны шугам сүлжээ ашиглалтын шаардлага хангахгүй болсон. Мөн орчин үеийн өндөр мэдрэг багаж, тоног төхөөрөмжөөр лабораторийн хүчин чадалаа нэмэгдүүлмээр байна. Гэтэл бид технологийн энэ зуунд уламжлалт шинжилгээний аргаар шинжилгээгээ хийсээр л байна. Уламжлалт аргаар шинжилгээ хийх нь үнэмшлийн хувьд адилхан ч мэдрэг чанар бага, цаг хугацаа, хүний оролцоо ихээр шаарддаг, нарийвчилсан тоон утгаар илэрхийлэх боломжгүй байдаг. Тиймээс төсөв мөнгөтэй холбоотой энэ асуудлаа шийдчих юм бол лабораториудын хүчин чадал сайжирч, хүнсний аюулгүй байдлыг хангахад түлхэц болно гэж бодож байна.

► Лабораторийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр төсөвт суугдсан уу? Та бүхэнд энэ талын мэдээлэл байна уу?

- Сүүлийн жилүүдэд Шадар сайд С.Амарсайхан Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагааг маш сайн дэмжиж ажиллаж байгаа. Манай лаборатори дээр ирж ажилласны хувьд тоног төхөөрөмжүүдийг зайлшгүй шинэчлэх шаардлагатай байгаа нөхцөлтэй танилцаж ойлгож хүлээн авсан. Үүний үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хүнсний лабораториудын чадавхыг нэмэгдүүлэхэд төсвийг нэмэх чиглэлд ажиллаж байгаад бидний зүгээс талархаж байгаа.

► Лабораторийг сайжруулах нь улс орны хэмжээнд ач холбогдолтой асуудал шүү дээ, тиймээ?

- Мэдээж, энэ бол зөвхөн Стандарт, хэмжил зүйн газрын асуудал биш юм. Лабораториудад үүсэх эрсдэлийг бууруулснаар бид хүнсний аюулгүй байдал, цаашлаад Үндэсний аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах боломжтой гэж харж байгаа.


► Ярилцсанд баярлалаа. Танд цаашдын ажилд нь амжилт хүсье.

2023 оны жилийн эцсийн байдлаар улсын байцаагч, аж ахуй нэгж, иргэний хүсэлт, хордлого, гомдлын нийт 11071 сорьцод 37632 үзүүлэлтээр шинжилгээ хийснээс 5,3% нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй дүнтэй шинжлэгдсэн байна. Шаардлага хангаагүй дүнтэй шинжлэгдсэн сорьцыг иргэн, аж ахуйн нэгж, улсын байцаагчийн ирүүлсэн дээжийн тоотой харьцуулвал, улсын байцаагчийн хяналт шалгалт, удирдамжаар ирүүлсэн дээжийн тоо цөөн боловч стандартын шаардлага хангаагүй дээжийн тоо их байна. Энэ нь юуг илэрхийлж байна вэ гэвэл, иргэн аж ахуйн нэгж өдөр тутмын үйл ажиллагаандаа стандартыг мөрдлөг болгохгүй байгааг харуулж байна.


Мөн нийт шинжлэгдсэн сорьцын шаардлага хангаагүй дүнгээс харахад гадаад орчны бохирдол 61%-ийг, хүнсний бүтээгдэхүүний бохирдол 39%-ийг эзэлж байгааг графикаас харж болно.

Шинжилгээгээр эрүүл ахуйн шаардлага хангаагүй нийт 24 үзүүлэлт тодорхойлогдсон. Эдгээрээс нитрит, цайр, хар тугалга нь аюулгүйн үзүүлэлтэд хамаардаг. Аюулгүйн үзүүлэлт зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй.



Харин үлдсэн 21 үзүүлэлт нь тухайн бүтээгдэхүүн, дээжийн бохирдол, чанарыг илэрхийлэх үзүүлэлтүүд байна. Энэ үзүүлэлтүүд дотроос бичил биетний ерөнхий тоо хүнс, ус, гадаад орчны шинжилгээнд хамгийн ихээр шаардлага хангаагүй шинжлэгдсэн. Энэ нь хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх явцдаа үйлдвэрлэлийн технологи, эрүүл ахуйн зохистой дадлыг мөрдөхгүй, бохир орчинд үйлдвэрлэл эрхэлж байгааг харуулж байна.



Шаардлага хангаагүй үзүүлэлтийн задаргаа



Эрүүл ахуйн шаардлага хангаагүй үзүүлэлт



ШИНЖИЛГЭЭ: Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь 6071 хэрэглэгчийн хүсэлтээр 64745 дээжинд 175040 үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийсэн байна.

Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээ

Бүтээгдэхүүний төрөл	Эерэг	Нийт дээж
Мах, махан бүтээгдэхүүн	22	1528
Сүү	6	565
Сүү, сүүн бүтээгдэхүүн	63	2396
Гурил	1	552
Гурилан бүтээгдэхүүн	0	3513
Төрөл бүрийн будаа	125	999
Сахар, чихрийн зүйл	65	3087
Төмс	0	158
Хүнсний ногоо	38	4214
Жимс, жимсгэнэ	7	2342
Буурцагт ургамал	3	28
Өндөг	0	177
Хүнсний тос	9	817
Ундны ус	35	254
Ундаа, жүүс	14	3029
Архи, пиво, дарс	38	3135
Үр тариа, бусад үр, үрсэлгээ	360	1064
Хүнсний нэмэлт	3	2455
Бусад	122	7041
Нийт	911	37354

Шинжилгээний төрөл

Шинжилгээний төрөл	Эерэг дээж	Нийт дээж
Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээ	911	37354
Ахуйн бүтээгдэхүүний шинжилгээ	19	7199
Орчны шинжилгээ	362	20192
Нийт	1292	64745





Хүнсний аюулгүй байдлыг хангахын тулд эхлээд аюулгүй үзүүлэлтүүдээ 100 хувь үздэг болох хэрэгтэй

► Манай улсад тулгамдаад байгаа Хүнсний аюулгүй байдлын талаар болон танай лаборатори ямар үүрэг гүйцэтгэж байгаа вэ гэдэг талаар яриагаа эхлүүлье. Та лабораторийнхоо үндсэн чиг үүргийн талаар хэлж өгнө үү.

- Манай лаборатори нь 1958 оноос эхлэн үйл ажиллагаагаа эхлүүлж, өнөөдрийг хүртэл Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори болтлоо хөгжиж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажилласаар ирлээ. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйл дээр манай байгууллагын үндсэн чиг үүргийг дэлгэрэнгүй зааж өгсөн байдаг тул бид энэхүү хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах үйл ажиллагааг явуулдаг. Нэгдүгээрт бид эрсдэлтэй бүтээгдэхүүний тандалт судалгааг хийгээд дараа нь эрсдэлийг тодорхойлно. Эрсдэлийг тодорхойлохдоо ямар аюулгүйн үзүүлэлт ямар түвшинд байгааг тодорхойлно. Энэхүү аюулгүйн үзүүлэлтүүдийг эрүүл

мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулдаг. Хоёрдугаарт улсын хэмжээнд хүнсний лабораториудын ур чадварын сорилтыг зохион байгуулдаг. Мөн магадлан сорилт шинжилгээ хийх, орон нутгийн сорилтын лабораториудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, шинжилгээний үр дүнгийн нэгдсэн мэдээллийн тогтолцоог улсын хэмжээнд бий болгох, удирдан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

► Тогтвортой хөгжлийн зорилтод тусгасан хүнсний аюулгүй байдлыг хангах асуудалд лаборатори ямар үүрэг гүйцэтгэн ажиллаж байгаа вэ?

- Тогтвортой хөгжлийн зорилтод хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар маш тодорхой зааж өгсөн боловч улсын хэмжээнд хэрэгжиж буй бусад тогтвортой хөгжлийн хэрэгжилттэй харьцуулахад хангалтгүй байна. Тогтвортой хөгжлийн хэрэгжилтийг хангах үндэсний сайн дурын 2 дахь илтгэлд чанар, аюулгүйн үзүүлэлтүүдийг

бүрэн шинжлэх лабораторийн хүчин чадал сул байна гэж тодорхойлсон. Бусад хүнсний хангамжийг сайжруулах тал дээр хүнсний түүхий эдийн ханган нийлүүлэлт тээвэрлэлт, хадгалалт эдгээр чиглэлээр нэгдсэн хяналтын тогтолцоо бүрдээгүй байна гэж үзсэн байна. Ингэж дүгнэхээс ч аргагүй. Яагаад гэвэл, хүнсний бүтээгдэхүүний сүлжээ гэдэг нь олон улсад хүнс хөрсөн дээр ургаж эхлээд тээвэрлэгдэн аж ахуйн нэгж, компаниар дамжин бүтээгдэхүүн болж, савлагдаж, шошгологдон дэлгүүрийн лангуун дээр ирж хэрэглэгчдэд хүрэх бүх үйл явцыг хамаарна гэж үздэг юм. Хүнсний аюулгүй байдал гэдэг бол энэ бүх сүлжээ хяналтад байхыг хэлдэг. Гэтэл манай улсад энэхүү хүнсний сүлжээний нэгдсэн хяналтын тогтолцоо нь бүрдээгүй байна.

► Асуудлыг ерөнхийд нь харахад лабораториос шалтгаалахгүй асуудал байгааг ойлголоо. Лаборатори талаасаа илүү сайн шинжилж, судлахын тулд тоног төхөөрөмжөө сайжруулах шаардлагатай. Энэ тал дээр ямар арга хэмжээг төлөвлөсөн байгаа вэ?

- 2024 оны эхний улиралд багтаан тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг МУ-ын Засгийн газраас хийхээр төлөвлөсөн. Стандартад заасан 245 нэр төрлийн пестицидийн үлдэгдлийг тодорхойлох ёстой боловч пестицидийн үлдэгдлийг тодорхойлох багаж маань үндсэндээ 10 жил ажилласны эцэст элэгдэж, 2022 онд эвдэрсэн тул пестицидийн үлдэгдлийг тодорхойлж чадахгүй байна. Иймд бид пестицидийн үлдэгдэл, хүнсэнд дэх эмийн үлдэгдэл, генийн өөрчлөлттэй хүнсний бүтээгдэхүүн, хүнд металлын үлдэгдлийг тодорхойлох чадамжтай тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхээр төлөвлөж байна.

► Одоогийн байдлаар хүнсний аюулгүй байдлын баталгааг лабораторийн түвшинд гаргаж чадаж байгаа болов уу?

- Бид эмийн үлдэгдлийг 5 хувь, хими, хор судлал, микробиологи, цацраг, таримал ургамлын үр, хорио цээрийн чиглэлээр үндсэн үзэх ёстой үзүүлэлтийнхээ 80-90 хувийг шинжилж байна. Өнөөдрийн түвшинд микробиологийн чиглэлээр 80 хүртэл хувийг үзэж байгаа боловч энэ нь тоног төхөөрөмж болон шинжээчийн ур чадвараас хамаарна. Тоног төхөөрөмж гэхэд л зөвхөн дан ганц төхөөрөмжийн тухай бус, түүний эд анги, гуурс, колонк гээд л бусад бүх дагалдах хэрэгслүүдийг



МОНГОЛ УЛСАД МӨРДӨГДӨЖ БУЙ 6600 ГАРУЙ СТАНДАРТ БАЙГААГААС 576 НЬ ХҮНСНИЙ СТАНДАРТУУД, ТЕХНИКИЙН ШААРДЛАГА БАЙДАГ. ГЭВЧ ЭНЭ СТАНДАРТЫГ ИРГЭН НЬ, АЖ АХУЙН НЭГЖ НЬ, ТӨР НЬ БҮГД МӨРДӨЖ БАЙГАА ЭСЭХ ТАЛ ДЭЭР Л АСУУДАЛ ҮҮСДЭГ.

хамруулж ойлгох нь зүйтэй бөгөөд шинжилгээ хийх урвалж бодисын нөөц бага, дагалдах хэрэгслийн хүчин чадал сул, эвдрэл их байвал үндсэн тоног төхөөрөмж ажиллахгүй байгаагаас ялгаагүй гэсэн үг. Тиймээс бид зөвхөн нэг тоног төхөөрөмжийг авч өгснөөр хүнсний аюулгүй байдал одоо сайжрах юм байна гэж ойлгож болохгүй. Хэвийн ажиллагааг тасралтгүй хангах хэрэгтэй. Цаашилбал, эдгээр тоног төхөөрөмжүүд дээр бид ямар урвалж, ямар кит, оношуур, дагалдах хэрэгслүүдийг ашиглан үйл ажиллагаагаа өргөжүүлэх, олон улсын жишигт хүрсэн аюулгүйн үзүүлэлтүүдээс хэдэн хувийг нь үздэг болох вэ гэдгийг тодорхойлох, мөн батлагдсан аюулгүйн үзүүлэлтүүд бидэнд өнөөдрийн байдлаар шаардлагатай эсэх, хэрэв шаардлагагүй бол хасах гэх мэт тодорхой шинэчлэлтүүдийг хийх, стандартыг дагаж мөрдөх үүрэг оногдож байна.

► Манай улсын үндэсний лавлагаа лабораторийн шинжээч нар ямар түвшинд байна, сайжруулахын тулд ямар ажил хийгдэж байгаа талаар ярьвал?

- Манайх микробиологи, хими, хор судлал, цацрагийн хяналт болон таримал ургамлын үр, хорио цээрийн гэсэн 4 лабораторитой. Манай лабораторийн нэг онцлог бол шинжээч нар өөрсдөө санаачилгатай байвал өөрийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлж хөгжих бүрэн боломжтой. Сүүлийн үед дэлхий нийт улс орны хөгжлөөс үл хамааран аюулгүй хүнсэнд ихээхэн анхаарал хандуулах болсон. Учир нь, шинжлэх ухаан хөгжихийн хэрээр вирус хувьсаж өөрчлөгддөгтэй ижил хүнсэнд агуулагдаж байгаа нэмэлт бүтээгдэхүүнүүд ч улам нэмэгдэж байна. Олон улсын түвшинд хүнсэнд харшил төрүүлэгчийг өмнө нь улс бүр үздэггүй байсан бол одоо үздэг болох зорилт тавьж байх

жишээтэй. Манайх ч мөн стандартын дагуу 2024 онд нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Манай шинжээч нарын хувьд мэдлэг ур чадвар сайн ч нэг хэцүү зүйл байгаа нь цалин хөлс, нийгмийн асуудлын дэмжлэгтэй холбоотой. Шинжээч нарын цалин хөлс нь төрийн үйлчилгээний ангилал, зэрэглэлээр нэг саяас нэг сая хоёр зуу мянган төгрөгийн хооронд байдаг. Үндэсний лабораторидоо чадавжаад ажиллаж байгаа шинжээч нарт маань хувийн хэвшлийн байгууллагууд өндөр цалин хөлс, нийгмийн асуудлын дэмжлэг амладаг. Дээрх тохиолдолд маш сайн бэлтгэгдсэн боловч хүчин маань бага цалин, төрөөс үзүүлж буй нийгмийн дэмжлэг байхгүйтэй холбоотойгоор улсад

ажиллах сонирхлоо орхиж, хувийн хэвшилд ажиллах сонголтыг хийдэг нь тун харамсалтай санагддаг.

► **ХАБУЛЛ нь бусад орны болон олон улсын лабораториудтай харьцуулахад ямар түвшинд байгаа вэ?**

- Нэгдүгээрт манай улс орны хөгжил ямар билээ гэдгийг харгалзаж үзэх хэрэгтэй. Хоёрдугаарт, шинжлэх ухаандаа ямар төсөв зарцуулдаг вэ, гуравдугаарт эдийн засаг ямар вэ зэрэг асуудлаас хамаарна. Олон улсад таримал ургамлын ортон шавж илрүүлэх арга одоог хүртэл уламжлалт аргаараа буюу микроскопоор илрүүлж байгаа хэвээрээ. Манай лаборатори ч мөн уламжлалт аргаар шинжилж байна. Харин микробиологи, хими, хор судлалын шинжилгээнүүд тоног төхөөрөмжийн хүчин чадлаас хамаарч өөр, өөр байгаа. Гэхдээ бид үүнийг олон улсын түвшинд хүргэхийн төлөө л зорих ёстой, энэ зорилтыг ч тавьж ажиллаж байгаа.

МУ-ын Шадар сайдын зүгээс олон улсын төсөл хөтөлбөрт хамрагдах боломжийг судлах, төрөөс бүх зүйлээ шаарддаг биш байгууллагын удирдлага, хамт олон санаачилгатай, шинжлэх ухаанч ажиллах, шинэ санаачилгуудаа засгийн газарт тухай бүр уламжилж ажиллахыг даалгасан бөгөөд дээрх тохиолдлуудад МУ-ын Засгийн газраас зөвлөгөө, зөвлөмж, дэмжлэг үзүүлж ажиллана гэдгээ илэрхийлж, бидэнд хүнсний аюулгүй байдлыг хангах, 100 хувь аюулгүй үзүүлэлтүүдээ шинжилдэг болох зорилтыг нэн тэргүүнд тавьж ажиллахыг үүрэг болгосон. Үүний дагуу бид олон улсын байгууллагуудтай хамтарч, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гаргаад байна. Дэлхийн хүнс хөдөө аж ахуйн байгууллагын Кодексийн стандартууд, нэг үгээр хэлбэл дэлхийн хүнсний хууль юм. Үүний дагуу өмнө нь хэлсэн 3 чиглэлээр хими, микробиологи, хорио цээрийн олон улсын тодорхой стандартууд байдаг. Манай улс Кодексийн гишүүн болоод удаж байгаа. Мөн холбогдох стандартуудыг орчуулаад, хэрэгжүүлээд явж байгаа. Эндээс харахад бид олон улсын түвшинд үйл ажиллагаагаа явуулж байгааг илэрхийлэх боловч нөгөө талаас улс орны эдийн засаг, төсвийн байдлаас хамаараад лабораторийнхоо тоног төхөөрөмжийг шинэчилж чадахгүй, яг шаардлагатай урвалжуудаа авч ашиглаж чадахгүй байхад олон улсын лабораториудтай харьцуулахад хэцүү. Олон улсын лабораториудын хөгжлийн нэг сайн тал нь зөвхөн лабораторийн шинжилгээ хийгээд зогсохгүй тандалт судалгаа, эрдэм шинжилгээний ажлуудыг хослуулж хийдэг. Лабораторийн шинжилгээнд орсон бүтээгдэхүүндээ эрсдэлүүдээ тооцоод явна. Харин манайд эрсдэлүүдээ тодорхойлдог, аюулгүй үзүүлэлтийг гаргадаг хэдий ч энэ талаар бүтээл болгон хэвлүүлдэг, олон нийтэд анхааруулах, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах, иргэддээ урьдчилан сэргийлэх мэдээлүүдийг тогтмол олгох ажлууд орхигдсон байсныг засаж, 2024 оны төлөвлөгөөндөө иргэдэд чиглэсэн лабораторийн үр дүн дээр суурилсан тухайн аюултай эрсдэлтэй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, импортлогч аж ахуйн нэгжээс шалтгаалахгүйгээр хэлж зарлах, харин үнэхээр сайн бүтээгдэхүүн буюу стандартынхаа шаардлагыг хангасан лабораторийн шинжилгээгээр баталгаажсан бол иргэддээ зөвлөх арга хэмжээг тусгана. Энэ нь бид олон улсын систем рүүгээ л шилжиж байгаа хэлбэр, жишээлбэл

Америкт бид очиход бүх хүнсний бүтээгдэхүүн дээрээ "FDA" гэсэн тэмдэгтэй байдаг. Энэ нь иргэд тухайн хүнсний бүтээгдэхүүнийг айх аюулгүйгээр хэрэглэх бүрэн боломжтой баталгаажсан гэсэн үг юм. Харин манайд яг үнэхээр сайн бүтээгдэхүүн гэж юунд итгэх вэ гэвэл бид үйлдвэрлэгчийнхээ лабораторид итгэхээс аргагүй нөхцөлд байна. Зарим нь дотоодынхоо бүтээгдэхүүнд итгэдэггүй, зөвхөн импортын бүтээгдэхүүнийг хэрэглэдэг хэсэг бүлэг хүмүүс байна. Тиймээс үүнийг цэгшлэх, стандартыг мөрдүүлдэг байх арга зам руу манай лаборатори шилжин ажиллана.

► **Тэгэлгүй яахав, олон улсад ямар нэгэн бүтээгдэхүүний гарал үүсэл нь тодорхой, би яг юу хэрэглэж байгаа вэ гэдэг нь тодорхой байдаг шүү дээ. Харин манай улсад гарал үүсэл нь тодорхойгүй байх тохиолдол маш их байдаг. Энэ чиглэл дээр ямар ажлууд хийгдэж байгаа вэ, ер нь хэзээ бид нар хэрэглэж байгаа бүтээгдэхүүнийг гарал үүслийг мэддэг болох боломжтой болох вэ?**

- Ер нь манай улс хүнсний бүтээгдэхүүнийхээ 80 орчим хувийг импортоор хангадаг. МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хувьсгал үндэсний хөтөлбөрийн дагуу импортыг бууруулж, экспортыг дэмжих, дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих, аюулгүй хүнс хэрэглэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх УИХ-ын 36 дугаар тогтоол батлагдсан. Бид цаашдаа энэ бодлогын хүрээнд ажиллах үүрэгтэй, лабораторио ч хөгжүүлнэ. Үндсэндээ таны асууж байгаатай адил ялангуяа түргэн мууддаг хүнсний бүтээгдэхүүн, тухайлбал хиам, зайдас, торт гэх мэтчилэн эдгээр бүтээгдэхүүнүүдийг хүнсний хяналтын сүлжээндээ нэгтгэж чадахгүй байна. Бид хадгалалт, тээвэрлэлтийн явцад хяналтаа тавьж чадаагүйгээс хоолны хордлого үүсэж, улмаар эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Хэрэв бид хүнсээ хянаж, аюулгүй байдлыг нь баталгаажуулж

БИД ЭМИЙН ҮЛДЭГДЛИЙГ 5 ХУВЬ, ХИМИ, ХОР СУДЛАЛ, МИКРОБИОЛОГИ, ЦАЦРАГ, ТАРИМАЛ УРГАМЛЫН ҮР, ХОРИО ЦЭЭРИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮНДСЭН ҮЗЭХ ЁСТОЙ ҮЗҮҮЛЭЛТИЙНХЭЭ 80-90 ХУВИЙГ ШИНЖИЛЖ БАЙНА.

чадвал зөвхөн хоолны хордлого гэлтгүй халдварт бус өвчлөлийн эрсдэлийг ч бууруулах, цаашлаад бид өвчлөхгүй байх ч бүрэн боломжтой. Хүнс эрүүл бол хүн эрүүл. Хүнсний сүлжээний хяналтууд хангалтгүй болохоор, дан ганц лаборатори байлаа гээд хангалтгүй. Жишээ нь, нэг аж ахуйн нэгж манай лабораторид хүнсний бүтээгдэхүүнээ шинжлүүлээд аюулгүй гэсэн шинжилгээний хариугаа авлаа гэж бодоход манай улсын байгаль цаг уурын онцлог, газар нутгийн өргөн уудам зай, зам тээврийн нөхцөл байдлаас шалтгаалан 1500 км алслагдсан газарт амьдарч байгаа иргэдийг тухайн аюулгүй хүнсээр хэрхэн хангаж байгааг нотлох, ямар бодлого баримталж хэрэгжүүлэх шаардлагатай вэ гээд өмнө нь дурдсан нэгдсэн тогтолцоо, хүнсний сүлжээгээ

БИД ХАДГАЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТИЙН ЯВЦАД ХЯНАЛТАА ТАВЬЖ ЧАДААГҮЙГЭЭС ХООЛНЫ ХОРДЛОГО ҮҮСЭЖ, УЛМААР ЭРҮҮЛ МЭНДЭД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БАЙНА. ХЭРЭВ БИД ХҮНСЭЭ ХЯНАЖ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ НЬ БАТАЛГААЖУУЛЖ ЧАДВАЛ ЗӨВХӨН ХООЛНЫ ХОРДЛОГО ГЭЛТГҮЙ ХАЛДВАРТ БУС ӨВЧЛӨЛИЙН ЭРСДЭЛИЙГ Ч БУУРУУЛАХ, ЦААШЛААД БИД ӨВЧЛӨХГҮЙ БАЙХ Ч БҮРЭН БОЛОМЖТОЙ.

бүрэн зохион байгуулж ажиллахгүй бол дан ганц сайн лаборатори байлаа гээд хүнсний аюулгүй байдлын асуудал шийдэгдэхгүй. Лабораториос шалтгаалахгүй хүчин зүйлүүд ч их байна. Хөрсөн дээр ургаж байгаа хүнс нь үйлдвэрлэгч дээрээ очих процесст бид хүнсний бүтээгдэхүүний хяналтыг хэрхэн тавих вэ, энэ нь өөрийн дүрэм журамтай, стандарттай, тогтолцоотой байх ёстой.

► **Ирэх онд ХАБУЛЛ ямар ажлуудыг төлөвлөж байгаа талаараа товчхон танилцуулна уу.**

- Цаашдаа бид олон улсын төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдахад анхаарлаа хандуулж гадаад хамтын харилцааг өргөжүүлэх замаар лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ. Нэгдсэн үндэсний байгууллагын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага, Хүүхдийн сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн зөн, ЖАЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллага

гэх мэт олон улсын байгууллагуудад хамтран ажиллах саналаа уламжилсан. Мөн Кодексийн олон улсын төсөлд тодорхой асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтарч оролцохоор төлөвлөсөн. Бүтээгдэхүүн талаасаа гэвэл сүүлийн жилүүдэд нэлээд яригдаж байгаа хүүхдийн таргалалт, чихэрлэг ундааны хэрэглээтэй холбоотой нийгмийн эрүүл мэндийн асуудлууд, түүний эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлоход нь лабораторийн оролцоогүйгээр боломжгүй, мөн чихэрлэг шингэн хүнсний үйлдвэрлэлийн стандартыг шинэчлэх, техникийн шаардлагад өөрчлөлт оруулах замаар элсэн чихрийн хэрэглээг бууруулах зэрэг асуудалд анхаарч ажиллана. Өөрөөр хэлбэл шинжлэх ухааны нотолгоог лаборатори бүрдүүлдэг, лабораторийн тоон мэдээлэл, дүн шинжилгээгүйгээр бид хэзээ ч хүнсний аюулгүй байдлын талаарх бодлогыг боловсруулж чадахгүй. Бодлогын түвшинд ажиллахын тулд манай менежментийн баг өөрсдөө ямар түвшинд байхыг харгалзан зөвхөн шинжээч нарын мэдлэг үр чадварыг дээшлүүлээд зогсохгүй, удирдлагын багийн мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч байна. Мөн иргэдэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх тал дээр бид тусгайлан төлөвлөгөө боловсруулж ажиллана. Үүнийгээ эрүүл мэндийг дэмжих маш томоохон үзүүлэлтүүдийн нэг гэж бодож байна. Хүүхэд бага наснаасаа эхлэн хүнс аюулгүй байх тухай, зүгээр нэг алим идэхгүй алим нь аюулгүй байх ёстой гэдэг ойлголттой болох, мөн аюулгүй байлгахын тулд надаас шалтгаалах зүйл юу вэ гэдгийг нийт ард иргэд маань ойлгодог байхад лаборатори онцгой анхаарч, цаашдын үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлнэ.

► **Ярилцсанд баярлалаа. Танд цаашдын ажилд нь амжилт хүсье.**





Хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын газрын үндсэн үйл ажиллагаа

Монгол улсын “Хэмжил зүйн тухай” хуулийн дагуу хүн, мал эмнэлгийн оношилгоо, эмчилгээ, аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах, улсыг батлан хамгаалах, худалдаа, үйлчилгээний тооцоонд чиглэсэн бүхий л үйл ажиллагаанд ашиглаж байгаа хэмжих хэрэгслүүд нь стандартын тогтоосон шаардлагуудад нийцэж байгааг эсэхийг улсын анхдагч болон ээлжит шалгалт баталгаажуулалтын үр дүнгээр тогтоох үйл ажиллагааг 4 лаборатори явуулж байна.

- Механик хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын лаборатори
- Эзлэхүүн зарцуулалтын хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын лаборатори
- Цахилгаан хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын лаборатори
- Дулаан, даралт, эрүүл мэндийн хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын лаборатори

Хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын газар нь нийслэлийн 9 дүүрэгт хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын ажлыг 20 хүний бүрэлдэхүүнтэй хийж байна. 2023 онд Аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан хэмжих хэрэгсэл шалгаж баталгаажуулах гэрээ, графикийн дагуу 273527 ширхэг хэмжих хэрэгсэлд улсын баталгаажуулалт хийсэн.

Үндсэн чиглэл

- Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах талаар төрийн бодлогыг хэрэгжүүлэх;
- Хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах хэмжил зүйн үйл ажиллагааны чадавхаа үнэлүүлэх аж ахуйн нэгж байгууллагад олгохтой холбогдуулан мэргэжлийн дүгнэлт гаргах;
- Хэмжих хэрэгсэлд загварын туршилт хийх;
- Улсын баталгаажуулалтад хамрагдах хэмжих хэрэгсэлд аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан гэрээ, графикийн дагуу шалгалт баталгаажуулалт хийх;
- Аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагын хэмжлийн лабораторийг итгэмжлэхэд мэргэжлийн дүгнэлт гаргах ажлын хэсэгт техникийн шинжээчээр оролцох;
- Хэмжлийн нэгдмэл байдлыг хангахтай холбоотой улсын стандарт боловсруулах, олон улсын стандартыг орчуулан үндэсний стандарт болгож зохих журмын дагуу батлуулах, хэмжил зүйн дүрэм, журамд санал өгөх;
- Аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага ба холбогдох итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн боловсон хүчинд сургалт, мэдээлэл арга зүйн туслалцаа үзүүлэх;
- Хэмжил зүйн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд оролцож, хэрэглэгчид болон сонирхсон этгээдүүдэд хэмжил зүйн талаар танилцуулга, сурталчилгааг хийх;
- Улсын баталгаажуулалтад хамрагдах хэмжих хэрэгсэл эзэмшдэг аж ахуйн нэгж, албан байгууллага, хуулийн этгээдүүдийн ашиглаж байгаа хэмжих хэрэгслийн судалгааг гаргах;



ЯРИЛЦЛАГА

Л.БАЯРХҮҮ

Хэмжих хэрэгслийн, шалгалт баталгаажуулалтын газрын дарга

Баталгаажуулалтын гэрчилгээ гээгдсэн, үрэгдсэн, лац тэмдэг хөндөгдөж, эвдэрсэн бол баталгаагүйд тооцно

► Заавал баталгаажуулалтад хамруулах хэмжих хэрэгсэлд юу юу ордог вэ?

- Заавал баталгаажуулалтад хамруулах хэмжих хэрэгслийг хэмжил зүйн төв байгууллага санаачлан Монгол улсын Шадар сайд баталдаг. Одоогоор 60 гаруй төрлийн хэмжих хэрэгсэл заавал баталгаажуулалтад хамрагдаж байна. Үүнээс өргөн хэрэглэгддэг худалдааны жингүүд, автомашины жин, вагон жин, цахилгааны электрон тоолуур, усны тоолуур зэрэг төлбөр тооцоонд хэрэглэгддэг бүхий хэмжих хэрэгслийн жагсаалтад оруулсан байна. Жагсаалтыг байгууллагын цахим хуудас болох masm.gov.mn гэх хаягаас харж болно.

► Танай байгууллага эрсдэлтэй болон алдаа гарсан байгууллагын үйл ажиллагааг зогсоох цуцлах, хүчингүй болгох тохиолдол гарч байсан уу?

- Сүүлийн үеийн хэмжих хэрэгсэл өндөр нарийвчлалтай, бүтээмж өндөр болсон. Усны тоолуур баталгаажуулалт хоорондын хугацаа нь 15мм-ийн холболтын голчтой нь 6 жил, 20x250мм-ийн диаметртай нь 2 жил, цахилгаан тоолуур 8 жил байдаг.

ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖҮҮД ӨӨРСДИЙН АШИГЛАЖ БҮЙ ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН ҮНЭН ЗӨВ ЗААЖ БАЙГААГ ӨӨРСДӨӨ ХЯНАН, ШАЛГАЛТ ТАВЬЖ БАЙХ ХЭРЭГТЭЙ.

► Та ажлын чиглэлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?

- 2019 оны 05-р сарын 09-ний өдөр Хэмжил зүйн тухай хууль шинэчлэгдсэн найруулга батлагдсан. Хуулийн 8.1 дэх заалтын дагуу иргэд, аж ахуйн нэгжийн хэмжил хэрэгсэлд шалгалт баталгаажуулалтыг хийдэг. Айл өрх, албан байгууллагад ашиглагдаж буй усны тоолуур, нефтийн бүтээгдэхүүн болон шингэрүүлсэн шатдаг хий түгээх станцуудын түгээгүүрийн хошуу, түлш зөөвөрлөдөг машины торх, архи спиртийн тоолуур, шингэний тоолуур, хэмжээст сав, цахилгааны тоолуур, худалдааны жингүүд үнэн зөв зааж байгааг шалгаж баталгаажуулан, улсын шалгагч гэрчилгээ олгодог. Иргэд, аж ахуйн нэгжүүд өөрсдийн ашиглаж буй хэмжих хэрэгслийн үнэн зөв зааж байгааг өөрсдөө хянан шалгалт тавьж байх хэрэгтэй. Хэмжих хэрэгслийн дагалдаж буй баталгаажуулалтын гэрчилгээ гээгдсэн үрэгдсэн, лац тэмдэг хөндөгдөж эвдэрсэн бол баталгаагүйд тооцно. Иймээс хэмжих хэрэгсэлд хяналт тавьж гомдол санал, зөрчил дутагдал гарсан бол манай байгууллагад хандана. Энэхүү хүсэлтийн дагуу хэмжүүрийн хяналтын улсын байцаагч томилогдон магадлан шалгалтыг явуулж дахин баталгаажуулалтыг хийнэ.

ОДООГООР 60 ГАРУЙ ТӨРЛИЙН ХЭМЖИХ ХЭРЭГСЭЛ ЗААВАЛ БАТАЛГААЖУУЛАЛТАД ХАМРАГДАЖ БАЙНА.

► Ажилтнуудын мэргэшсэн байдал, хэрхэн ажилтнуудыг бэлтгэдэг вэ?

- Ажилд орох хүсэлтэй иргэн нь төрийн албаны шалгалтад тэнцсэн байх ёстой. Үүний дараа Стандарт, хэмжил зүйн газрын Хэмжил зүйн улсын шалгагчийг бэлтгэдэг 45 хоногийн хууль эрх зүй, хэмжлийн төрлөөр онолын болон дадлага мэдлэгийг олгох дотоод сургалтад хамруулан, шалгалтын комиссын шалгалтад тэнцсэнээр улсын шалгагчийн эрх олгоно. Мэргэшүүлэх талд гадаад болон дотоод хэмжил зүйн чиглэлийн сургалтад хамруулж байна. СХЗГ нь олон улсын хэмжил зүйн байгууллагатай гишүүн ба хамтран ажиллах гэрээний дагуу гадаадын хэмжил зүйн сургалтад манай байгууллагын ажилтнууд тогтмол хамрагдаг.

БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХУГАЦААНД ЛАЦ ТЭМДЭГ ХӨНДӨГДӨХ, ГЭРЧИЛГЭЭ ҮРЭГДҮҮЛЭХ, БУРУУ ЗААЛТТАЙ ГЭЖ ЭРГЭЛЭЭЖ БҮЙ ТОХИОЛДОЛД ХЭМЖИЛ ЗҮЙН БАЙЦААГЧИД ХАНДАН МАГАДЛАН ШАЛГАЛТ ХИЙЛГЭЖ ЗӨРЧЛИЙГ АРИЛГАНА

► Тоног төхөөрөмж материаллаг баазын талаар?

- СХЗГ-ын эталон тоног төхөөрөмжийн хувь төсөв санхүүтэй холбоотойгоор хангалтгүй түвшинд байна. Үүнийг сайжруулах талаар төсөл хөтөлбөр бичиж санал хүсэлтэй гадаадын байгууллага болон Сангийн яам, Шадар сайдын албанд хүргүүлж байна. Дэлхийн нийтэд хэмжил зүйн технологи хурдацтай хөгжиж шинэ технологи хэмжих хэрэгслийг шалган баталгаажуулах шаардлага бий болж байна. Үүнийг дагаад шинэ технологийн эталон тоног төхөөрөмж нэн шаардлагатай байна. Шаардлагатай эталон тоног төхөөрөмжийг улсын төсөвт тусгах, олон улсын байгууллагад төсөл хөтөлбөр бичих зэргээр шат дараатайгаар шийдвэрлэхээр ажиллаж байна.

► Одоогоор ямар ажил дээр төвлөрч ажиллаж байна вэ?

- СХЗГ нь улсын хэмжээнд 21 аймагт салбартай. Шатахуун болон шингэрүүлсэн шатдаг хий түгээх түгээгүүрийн хошууг хавар, намар 6 сарын хугацаатай ээлжит баталгаажуулалтад хамруулдаг ба одоогоор намрын ээлжит баталгаажуулалт хийгдэж дууссан. УБ хотод байршилтай 9 лабораторид усны тоолуурын баталгаажуулалт тогтмол хийж байна. Албан байгууллагын дуудлагаар бас тогтмол баталгаажуулалтыг хийж байна.

► Ярилсанд баярлалаа. Танд цаашдын ажилд нь амжилт хүсье.



Хяналт- шинжилгээ, үнэлгээгээр байгууллагын үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлнэ



► Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын үндсэн чиг үүрэг юу вэ?

- Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээр холбогдох талуудыг үнэн, бодит мэдээлээр хангах, нотолгоо бүхий зөвлөмж, саналыг дэвшүүлэх, өнгөрсөн хугацааны ололт амжилт, тулгарсан сорилтуудаас суралцахад туслах, өөрчлөлтийг хэрэгжүүлэх шийдвэр гаргах үндэслэл бий болгоход чиглэн ажиллах үүрэгтэй.

Энгийн үгээр илэрхийлбэл, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрыг байгууллагын эмч гэж ойлгож болно. Хаана ямар ажил, төлөвлөлт ямар нэгж, албан хаагчаас хамаарч хэрэгжилт гүйцэтгэл хангалтгүй байгааг оношилж, цаашид ямар арга хэмжээ авахыг тодорхойлж өгч эмчилдэг гэсэн үг.

Тодруулбал, Монгол Улсын Хөгжлийн бодлогын урт хугацааны Алсын хараа-2050 бодлогын баримт бичгээс эхлээд хууль тогтоомжид стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, Стандарт, хэмжил зүйн газрын болон аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

► Хяналт-шинжилгээ, үнэлгээний ялгааг тайлбарлана уу?

- Хяналт-шинжилгээ нь хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйл ажиллагаанд гарсан ахиц, өөрчлөлтийг нягтлах үйл явц гэж үздэг бөгөөд “Бид хүссэн арга хэмжээг авч чадаж байгаа эсэх” төдийгүй “Бидний хүссэн үр дүнд хүрэх ахиц, өөрчлөлт гаргаж байгаа эсэх” нь чухал юм. Харин үнэлгээ нь төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхэд дүн шинжилгээ хийж үнэлэлт өгөх үйл явц байдаг.

► Танай нэгж хяналт-шинжилгээ, үнэлгээг хэдий хугацаанд хийдэг вэ?

- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д нийцүүлэн Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны А/99 дүгээр тушаалаар Стандарт, хэмжил зүйн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмыг баталсан байдаг.

Энэ журмын дагуу хагас, бүтэн жилээр Стандарт, хэмжил зүйн газрын зохион байгуулалтын үндсэн нэгжүүд, аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээс гадна газар дээрх явцын хяналт-шинжилгээг зохион байгуулалтын үндсэн нэгжүүдэд жил бүр, аймаг дахь

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагаанд 2 жил тутам хийж дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлэн ажилладаг.

Мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буугдсантай холбогдуулан 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, Нийслэлийн лаборатори болон хэмжил зүйн хяналтын чиг үүргийг тус газарт шилжүүлэн ирүүлсэн бөгөөд газар дээрх явцын хяналт- шинжилгээг 7 аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс, зохион байгуулалтын үндсэн 12 нэгж, 1 дэргэдэх байгууллагад хийж, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр үүрэг, чиглэл өгөхийн зэрэгцээ албан хаагчдыг идэвхжүүлэн урамшуулах, бүтээлч санаачилгатай ажиллахад чиглүүлэх, зарим албан хаагчдад сахилга хариуцлага ногдуулах саналыг агентлагийн даргад уламжлан ажилласан.

► Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээс дурдана уу?

- Үр дүнтэй төлөвлөлтийг хийж чадахгүй бол хяналт-шинжилгээ, үнэлгээг сайн хийж чадахгүй учраас сүүлийн жилүүдэд салбарын хэмжээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэн зөв, бодитой, ахиц дэвшил гаргах чиглэлд анхаарал хандуулан ажиллаж байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийснээр хаана, ямар алдаа дутагдал гарсныг олж оношилдог учир үр дүнд тодорхой хугацааны дараа болон тэр даруйд нь засах арга хэмжээг тодорхой төлөвлөгөө гарган хэрэгжүүлж эхэлдэг онцлогтой. Үүнийгээ дагаад олон олон ажил, арга хэмжээнд үр дүн гарсан байдаг. Энэ 2023 оны хувьд дараах голлох бодлогын чиглэлээр үр дүн гарсан гэж үзэж байгаа, үүнээс дурдахад:

- Стандарт, хэмжил зүйн газрын болон аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2017-2022 оны үйл ажиллагааны статистик мэдээлэл;
- Стандарт, хэмжил зүйн хэлтэс, зохион байгуулалтын үндсэн нэгжүүдийн хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд мөрдөж баримт бичгийн (дотоодын) жагсаалт;
- Аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөлт, тайлагналт, хэрэгжилтэд тодорхой ахиц гарсан;
- Аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн Сорилтын лабораторид ашиглагдаж буй бүх баримт бичгүүдэд шүүлт хийж, Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага ISO/ IEC 17025 стандартын шаардлагад нийцүүлэн Үйл ажиллагааны жишиг баримт бичиг, Менежментийн тогтолцооны жишиг журмыг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ ХИЙСНЭЭР ХААНА, ЯМАР АЛДАА ДУТАГДАЛ ГАРСНЫГ ОЛЖ ОНОШИЛДОГ УЧИР ҮР ДҮНД ТОДОРХОЙ ХУГАЦААНЫ ДАРАА БОЛОН ТЭР ДАРУЙД НЬ ЗАСАХ АРГА ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАН ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЭЛДЭГ ОНЦЛОГТОЙ.

А/210 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

► Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Шадар сайдаас Стандарт хэмжил зүйн салбарын үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулан ажиллаж байгаа. Ямар үр дүнд хүрч байгаа вэ?

- Монгол Улсын Шадар сайд манай салбарын үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулан ажиллаж байгаад салбарын нийт албан хаагчид маш талархалтай байгааг энд дурдах нь зүйтэй. Яагаад энэ салбарыг Засгийн газрын зүгээс онцгой анхаарах ёстой гэдгийг хэлбэ.

Монгол хүний амьдралын чанар, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, улс орны нийгэм, эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, олон улсын зах зээлд бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээ арилжих, дэлхийн худалдааны техникийн саад тотгорыг арилгахад нөлөөлөх гол хүчин зүйлс болох чанар дэд бүтэц буюу стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээний бодлогын асуудал байдаг.

Хийж бүтээж, хөгжиж байгаа юм шиг боловч дотоод агуулга мөн чанар нь стандартын шаардлагыг хангахгүй байвал ямар их хохирол учирч болдгийг 2023 оны Турк Улсад болсон газар хөдлөлтийн жишээ харуулж байна. Газар хөдлөлтийн төв бүсээс ойрхон байдаг нэг хот л хохирол амсаагүй. Энэ нь тухайн хотын дарга, эрх бүхий албан тушаалтан нь л барилгын стандарт, норм дүрмийг баримтлан ажилласан байна. Үүнээс үзэхэд стандарт, норм дүрмийг баримталж ажиллавал ямар ихийг хэмнэж болох тухай том ойлголт гарч байна.

Стандартын механизм эхнээсээ зөв бодитой ажиллаж л байвал тэр улс зөв хөгжиж байгаагийн илэрхийлэл болдог. Тийм ч учраас цаашид Стандарт, хэмжил зүйн салбарт бодлогын болон бусад чиглэлээр өөрчлөлт, шинэчлэл хийх зайлшгүй шаардлага тулгараад байгаа.

Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 48 дугаар хуралдаан, Монгол Улсын Шадар сайдаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд “Стандартчилал, хэмжилзүйн салбарын бодлогын урт хугацааны бичиг баримт”, “Стандарт ба хөгжил” үндэсний зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулан батлуулахаар холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Эдгээр баримт бичгийг Монгол Улсын хууль тогтоомж, бусад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд, хөрш орнууд болон зарим хөгжиж буй орнуудын стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээний байгууллагын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсруулсан. Тухайлбал, Олон Улсын Стандартчиллын байгууллага (ISO), Олон Улсын Шахилгаан техникийн хороо (IEC), Олон Улсын жин хэмжүүрийн товчоо (BIPM), Ази номхон далайн стандартчиллын байгууллага (PASC), Ази номхон далайн хэмжил зүйн хөтөлбөр (APMP), ХБНГУ-ын Физик, техникийн хүрээлэн (PTB) зэрэг манай байгууллагатай хамтын ажиллагаатай олон байгууллагыг дурдаж болно.

► Ярилцсанд баярлалаа. Танд цаашдын ажилд нь амжилт хүсье.

Аймаг дахь стандарт, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагааны статистик



21 аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсүүд нь доорх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалт;
- Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалт;
- Стандартын салбар сан, сургалтын үйлчилгээ;
- Хэмжил зүйн хяналт;
- Сорьцын хяналт;
- Үнэт металлын сорьц тогтоох үйл ажиллагаа;
- Сорилтын лаборатори.

№	Аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсүүд	Тохирлын баталгаажуулалтад хамрагдаж гэрчилгээжсэн дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний тоо						Тохирлын баталгаажуулалтад хамрагдаж гэрчилгээжсэн үйлчилгээний тоо						Шалгалт баталгаажуулалтад хамрагдсан хэмжих хэрэгслийн тоо						Стандартын үйлчилгээ		Сорьцын лаборатори Хайлсан алтны хэмжээ (кг)				Хэмжил зүйн төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулсан объектын тоо (2023)	Шинжилгээнд хамрагдсан бүтээгдэхүүн (2023)	
		2018	2019	2020	2021	2022	2023	2018	2019	2020	2021	2022	2023	2018	2019	2020	2021	2022	2023	2017-2022 дундаж	2023	2020	2021	2022	2023		Дээжийн тоо	Үзүүлэлтийн тоо
1	Архангай	6	4	6	9	30	26	274	164	232	178	212	197	2765	1283	3199	8413	3192	1194	65	127					24	1219	4428
2	Баян өлгий	8	8	9	63	24	34	103	85	67	147	94	83	2641	2669	2573	2130	3319	3085	48	115					22	1928	6599
3	Баянхонгор	5	3	8	7	7	11	199	209	235	201	230	224	4891	5062	2832	2300	3300	7743	180	66	1229	1267	1365	2027.7	0	1189	4317
4	Булган	6	8	6	24	34	35	227	146	187	110	199	169	2885	2888	2803	6245	3271	3921	215	75					10	1750	4838
5	Говь-Алтай	15	11	4	3	9	17	157	155	82	79	111	107	2687	2353	4186	3844	3502	3639	114	134					15	607	2463
6	Говьсүмбэр											9							115		26					0	347	1308
7	Дархан Уул	21	11	15	17	117	147	251	177	215	177	143	228	10502	6486	8252	6009	9164	12279	94	72	776.1	830.1	3328.4	1974.7	0	3523	8147
8	Дорноговь	19	25	30	35	29	18	239	268	210	220	244	190	5908	8297	6706	10920	3258	3036	150	180					24	2305	4778
9	Дорнод	5	18	10	9	46	43	154	234	160	131	194	173	3301	3645	4696	4561	4011	6520	210	155					0	2880	9057
10	Дундговь	6	3	7	5	51	60	120	144	88	159	110	148	2405	2489	1702	4931	2091	5895	130	62					0	1360	3685
11	Завхан	12	11	9	17	17	21	471	246	264	173	299	191	2193	1416	2048	2180	3838	3805	126	192					0	2193	6458
12	Орхон	20	13	38	14	51	53	51	70	72	122	195	211	9929	7948	7550	7587	26141	9300	285	330					0	3902	12808
13	Өвөрхангай	24	20	5	14	35	47	231	220	178	233	210	255	4939	4212	6121	14148	4088	3156	74	125					0	1701	3389
14	Өмнөговь	3	6	8	12	14	11	125	105	154	157	280	197	5817	2675	4048	4325	5332	3562	104	66					25	2187	8624
15	Сүхбаатар	4	2	3	2	1	48	170	176	143	72	112	64	3781	3213	4085	3097	3571	3526	119	274					0	654	1843
16	Сэлэнгэ	6	2	4	6	10	13	292	274	239	263	300	266	12241	4525	5021	2721	6928	3743	182	72					0	2678	8727
17	Төв	3	5	6	12	5	9	419	275	270	368	380	324	9359	5958	2792	6286	4579	3989	145	23					0	1163	3683
18	Увс	23	12	17	18	24	55	253	153	178	136	222	219	3994	4129	3056	1933	7981	6745	118	144					19	2696	5536
19	Ховд	11	9	23	7	19	45	273	140	235	172	226	212	3069	1876	3019	1844	2072	1768	85	78					20	1702	5631
20	Хөвсгөл	4	9	14	15	3	29	26	65	134	181	202	260	4040	3954	3374	3582	4322	4818	198	107					25	1806	6609
21	Хэнтий	1	1	2	1	7	18	150	149	156	168	188	224	3813	6116	4872	12074	3709	2468	95	82					19	813	2773
	Нийт	202	181	224	290	533	740	4185	3455	3499	3447	4151	3951	101160	81194	82935	109130	107669	94307	2737	2485	1005.1	2197.1	4723.4	4002.4	247	38603	115701

Монгол Улс жилдээ 200-250 стандарт баталдаг

► Ярилцлагын эхэнд яагаад бидэнд стандарт хэрэгтэй вэ? гэдэг асуултад та хариулж өгөхгүй юу? Энэ асуулт хамгийн чухал нь байх гэж бодож байна.

- Монголчууд бид баялаг түүхтэй ард түмэн. Монгол хэлэнд маш олон тооны хэлц үг хэрэглэдэг бөгөөд үүний нэг тод жишээ бол “Долоо хэмжиж нэг огтол” гэсэн үг байдаг. Энэхүү хэлц үг нь юуг илэрхийлж байна вэ? гэвэл бид төрхөөсөө эхлээд жинлүүлдэг. Жишээ нь Т.Нашагдорж гэдэг хүн 53 см өндөр, 3,300 грамм жинтэй байгаа нь төрөхдөө өөрийн биеийг хэмжүүлж, хэмжлийн нэг эд эс болоод эхэллээ гэж ойлгож болно. Харин стандартын хувьд жишээ авахад хэрэглэгч дэлгүүрт орж аливаа бүтээгдэхүүн худалдан авахдаа сав, баглаа боодол дээрх хаяг, шошготой танилцаж, хаана үйлдвэрлэсэн, он сар, өдөр, хадгалгаа хугацаа, нөхцөл, ямар орц найрлагатай байна зэрэг мэдээлэлтэй танилцах нь эрүүл, аюулгүй хүнсээр хангагдах хамгийн энгийн шаардлага юм. Үүнийг бүтээгдэхүүнд тавьж буй стандарт гэж ойлгож болно.

► Иргэдэд ээлтэй стандарт өдөрлөгийг өмнө нь зохион байгуулж байсан уу? Хэрэв зохион байгуулж байсан бол өмнөх туршлагаас иргэд юуг илүү сонирхож байсан бэ? Танай байгууллагын хувьд ямар боломж байгааг судалсан уу?

- Бид нээлттэй хаалганы өдөрлөгийг “Тогтвортой хөгжлийн 17 зорилт”-ын хүрээнд зохион байгуулж байсан. Мөн жил бүрийн 4 дүгээр сард үнэт металлын үзэсгэлэн худалдааг зохион байгуулдаг. Үүнд өөрсдийн үйл ажиллагааг чиглэл тус бүрээр сурталчилдаг.

Иргэд стандартыг хэрхэн баталдаг талаарх ойлголт бага байдаг. Жишээ нь стандартыг Стандарт, хэмжил зүйн газар өөрсдөө боловсруулж баталдаг. Бид тэрхүү бэлэн боловсруулж баталсан стандартыг шууд авч хэрэглэнэ гэсэн ойлголттой байдаг. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль



стандартыг иргэн, аж ахуйн нэгж байгууллага хэн ч санаачлан боловсруулж болно гэсэн заалтыг олон нийтэд ойлгуулах нь чухал юм байна гэж харсан.

Хөөрөг, гаанс, бөгж, сүүжин ээмэг, мөнгөн аяга зэрэг үнэт эдлэл сорьштой байдгийг таниулах, тус бүр стандарттай байдаг шүү гэдгийг ойлгуулах зорилготой.

► Тохирлын гэрчилгээ, Чанараар тэргүүлэгч гэж тодотгоод байгаагийн учрыг тайлбарлаад өгөхгүй юу? Тохирлын гэрчилгээг үйлдвэрлэгч хаана хандаж, яаж авах вэ? Өөрсдийн санаачилгаар авдаг уу?

- Стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн гэдгийг хөндлөнгийн гуравдагч этгээд буюу баталгаажуулалтын байгууллага нотолж байгааг гэрчилсэн баримт бичгийг тохирлын гэрчилгээ гэдэг. Таны худалдан авсан бүтээгдэхүүн чанартай гэдгийг нотолж тохирлын гэрчилгээ авдаг. Энэ гэрчилгээтэй бараа, бүтээгдэхүүнийг хэрэглэгч шууд худалдан авалт хийх боломжтой гэсэн үг юм. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ямар бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ авах хүсэлтээ СХЗГ болон

тохирлын үнэлгээний байгууллагад өгөх нь нээлттэй.

► Тохирлын гэрчилгээг үйлдвэрлэгчид өгдөг юм уу? Бүтээгдэхүүнд нь өгдөг үү? Манай улсад хэдэн тохирлын гэрчилгээтэй бүтээгдэхүүн байдаг вэ?

- Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ аль алинд нь тохирлын гэрчилгээг олгодог. Засгийн газрын 291 дүгээр тогтоолоор заавал тохирлын баталгаанд хамрагдах бараа, үйлчилгээг жагсаалтаар баталсан байдаг.

► Стандарт хэрхэн баталдаг процесс их сонин санагдаж байна. Олон улс, Европын холбоо, Монгол улсын стандартуудын тэмдэглэгээ, тоо нь юуг илэрхийлсэн байдаг вэ? Аж ахуйн нэгж байгууллага өөрсдийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг сурталчлахдаа тийм тийм стандартын шаардлага хангасан гээд аягүй их олон тоо л яриад байдаг тэ? Монгол улсын MNS гэдэг байх гэж бодож байна, олон улс, европын холбооны гээд явах байх ер нь бусад улсын стандартууд ямар байдаг юм бэ?

- Түүхээс нь эхлээд ярья. 1929 онд Ардын засгийн газар гэж байсан. Тухайн Ардын засаг тарваганы тос, ноос ноолуурыг экспортлох талаар хэлэлцэж байгаад 1930 онд тухайн үеийн худалдаа үйлчилгээний байгууллагад даалгасан байдаг. Эдгээр бүтээгдэхүүнд чанарыг тогтоосон журам гаргах талаар үүрэг даалгавар өгсөн байдаг. Энэ үүргийн дагуу 1931 онд анхны тарваганы арьсны стандартыг боловсруулж байсан түүхтэй. Тус стандартад хэмжээ болон сортоор нь 4 ангилж байсан түүхтэй. Тэгэхээр стандарт баталдаг байгууллага маань 1953 оны 4 дүгээр сарын 14-нд Сайд нарын зөвлөлийн 121 дүгээр тогтоолоор Улсын төлөвлөгөөний комиссийн дэргэд 9 хүний бүрэлдэхүүнтэй Цэвээн даргатай хэлтэс байгуулж байсан. Он цагийн дарааллаар 1979 онд Олон улсын стандартын байгууллага буюу ISO-д 86 дахь гишүүнээр элсэн орсон байдаг. Одоогийн байдлаар 167 орон гишүүнчлэлтэй байна. Манай улсын хувьд Олон улсын стандартчиллын байгууллагын 35 Техникийн хороонд “жинхэнэ гишүүн” 58 Техникийн хороонд “ажиглагч гишүүн”-ий статустайгаар оролцож байна. Олон улсын байгууллага бол 700-аад Техникийн хороодтой. Стандарт баталдаг хүмүүсийг “техникийн хороо” гэж нэрлэдэг. Стандартыг хэрхэн батлах вэ? гэвэл иргэн, аж ахуйн нэгж байгууллага хэн ч санаачилж болно. Гэхдээ стандартыг баталдаг стандарт буюу MNS 1-1, MNS 1-2 стандартын дагуу боловсруулж, баталдаг. Монгол улсад нийт 64 стандартчиллын Техникийн хороо байдаг бөгөөд тус хороонд 835 гишүүнтэй, төрийн болон төрийн бус байгууллага, иргэн аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний байгууллагын тэгш оролцоог хангаж ажилладаг. Эдгээр 64 техникийн хороо жилдээ 200-250 стандартыг баталдаг. Эдгээр стандартыг батлах процесс нь 6 үе шаттай бөгөөд үе шат бүр нь үйл явцын дэс дараалалтай байдаг. Санал дэвшүүлэх, бэлтгэх үе, санал авах, хорооны, батлах, мэдээлэх үе шатын дагуу стандартыг баталдаг гэж ойлгож болно.

Монгол улсын стандартыг англиар MNS буюу Монгол улсын үндэсний стандарт гэсэн үгний товчлол, ISO буюу Олон улсын стандарт гэсэн үгийн товчлолоор Олон

МОНГОЛ УЛСАД НИЙТ 64 СТАНДАРТЧИЛЛЫН ТЕХНИКИЙН ХОРОО БАЙДАГ БӨГӨӨД ТУС ХОРООНД 835 ГИШҮҮНТЭЙ БӨГӨӨД ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ИРГЭН АЖ АХУЙН НЭГЖ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТЭГШ ОРОЛЦООГ ХАНГАЖ АЖИЛЛАДАГ. ЭДГЭЭР 64 ТЕХНИКИЙН ХОРОО ЖИЛДЭЭ 200-250 СТАНДАРТЫГ БАТАЛДАГ.

улсын стандартыг тэмдэглэх жишээтэй. Мөн MNS ISO гэсэн тэмдэглэгээтэй стандарт байдаг энэ нь Олон улсын стандартыг орчуулаад Монгол стандарт болгон баталсан гэж ойлгож болно.

► Стандартыг заавал мөрдөх гэсэн зүйл заалт байдаг уу? Иргэн, аж ахуйн нэгж стандарт боловсруулах талаар саналаа гаргадаг гэж байна. Тэгвэл энэ процесс урвуу байх боломжтой юу? Жишээ нь танай байгууллага стандарт боловсруулаад батлах тохиолдол бий юу?

- Манай хуулийн 8 дугаар зүйл дээр Олон улсын стандарт, үндэсний стандарт, байгууллагын стандарт, хотын стандарт гэсэн 4 төрөл байдаг. Мөн Олон улс, бүс нутаг, гадаад орны стандартыг 18 сарын хугацаатай бүртгүүлэн хэрэглэж болно. Энэ хугацаанд хэрэглэж буй гадаад стандартаа тухайн аж ахуйн нэгж нь үндэсний стандартаар батлуулах үүргийг хүлээдэг. Ингэж хэрэглэснээр маш их хөрөнгө, мөнгө, цаг хугацааг хэмнэж байгаа бөгөөд бидний зүгээс аж, ахуйн нэгж байгууллага дэмжиж ажиллаж байна. Таны асуултад хариулахад стандартыг заавал мөрдөх ёстой. Хуульд бол сонгож хэрэглэнэ гэж заасан байдаг. Сонгож хэрэглэнэ гэдэг бол хэрэглэхгүй гэсэн үг биш танд ашигтай таны үйлдвэрлэл үйлчилгээнд хэрэгцээтэй шаардлагыг хангасныг сонгоно гэсэн үг болохоос биш энэ хэрэггүй гэсэн үг биш.

► Таны ярианаас сонсохоор бид 100 орчим жилийн өмнөөс стандартыг анх баталж, хэрэглэж стандарттай танилцсан байна. Харьцангуй эрт стандарт тогтоож ирсэн байна. Бидний яриад байгаа стандартын хөгжил бусад орныг бодвол Азийн улсдаа, бүс нутагтаа хэр түвшинд явж байгаа вэ?

- Манай улс Олон улсын стандартын ангиллаар хөгжингүй орны ангилалд хамаардаг бөгөөд Зүүн Азийн бүс нутагтаа стандартчиллын чиглэлээр хөгжингүй орондоо хамаардаг. Манай улс 6608 стандарттай. Австрали улс 6000 гаруй стандарттай. Дэлхийн тэргүүлэх Хятад, АНУ, ОХУ маш олон стандарттай. Гэхдээ тоо бол чухал биш хэрхэн ашиглаж байна, мөрдөж байна гэдэг л чухал ач холбогдолтой.

► Ярилцсанд баярлалаа. Танд цаашдын ажилд нь амжилт хүсье.

2024 онд виртуал хичээл бэлтгэхээр төлөвлөгөөнд тусгаад ажиллаж байна

► Мэдээллийн технологи, стандартын лавлагаа, сургалтын төвийн үйл ажиллагааны чиглэлийн тухай мэдээлэл өгөөч?

- Стандарт хэмжил зүйн газрын мэдээлэл, технологи стандартын лавлагаа сургалтын төвийн нэг чиг үүрэг нь Манай улсад мөрдөгдөж байгаа стандартчилал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, хэмжил зүйн тухай хууль дүрэм журмын хүрээнд энэ салбарт зохион байгуулагдах сургалтуудыг зохион байгуулах юм. Сургалтын хүрээнд хэмжилзүйн улсын шалгагч, шалгалт тохируулгын ажилтан, баталгаажуулалтын шинжээч, давтан сургалт зэрэг Стандарт хэмжил зүйн албан хаагчдыг сургаж дадлагуулах ажлыг зохион байгуулдаг. Мөн менежментийн тогтолцоо, стандарт хэмжил зүйн суурь ойлголтуудыг өгдөг сургалтын нэгж юм. Монгол улсад одоогоор бүх шатны боловсролын салбарт энэ төрлийн сургалт зохион байгуулагдаагүй тул хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэдэг.

Олон улсын стандартын Дэлхийн худалдааны байгууллагын Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргийн нэг хэсэг. Бид олон улстай худалдаа хийхэд нэн тэргүүнд стандартыг шаарддаг. Тэгвэл Монгол улсад мөрдөгдөж байгаа бүх стандарт нь улсын мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдэж нийтэд мэдээлэгддэг.

СХЗГ-Н ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОХ СТАНДАРТ БАТЛАХ, СТАНДАРТЫГ ОЛОН НИЙТЭД ТАНИУЛАХ, БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ БАТАЛГААЖУУЛАХ, ХЭМЖИЛ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, СОРЬЦ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ ЗЭРГИЙГ ЦАХИМЖУУЛСНААР ТӨРИЙН БҮТЭЭМЖ НЭМЭГДЭЖ, ИРГЭДЭД ОЙЛГОМЖГҮЙ ХҮНД ТӨВӨГТЭЙ АЖЛЫГ ОНОВЧТОЙ ХЯЛБАР БОЛОХ ЮМ.



► СХЗГ-ын сургалтаар 2023 онд шинэ, шинэчилсэн сургалт явагдсан уу?

- Манай сургалтын нэгж жилд ойролцоогоор 66 орчим төлөвлөгөөт болон захиалгат сургалт зохион байгуулдаг. Эдгээр сургалт бүгд л өөр өөрийн онцлогтой. 2023 онд СХЗГ-н хувьд онцлох жил байсан бөгөөд стандартыг бүх шатанд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан. Энэ хүрээнд оны хамгийн онцлог сургалт болох “Стандартын суурь асуудал” сургалтад давхардсан тоогоор 6000 гаруй хүн хамрагдлаа. Мөн гүний гаалийн, УБТЗ ХНН зэрэг төрийн томоохон байгууллага стандартын учир холбогдлыг сайтар ойлгож сургалт авсаар байна.

► Аж ахуйн нэгж байгууллагуудад зайлшгүй хамрагдах шаардлагатай гэвэл ямар сургалтыг нэрлэх вэ?

- Монгол төрийн үзэж байгаагаар бид хөгжлийн асуудлыг ярихаас илүүтэйгээр стандартыг бүх шатанд мөрдөж байж сая хөгжлийн замд орсон байна гэж ярьж хэлж болно. Ийм ч учраас эхлээд стандарт гэж юу вэ? гэдэг сургалтыг бүх шатандаа ойлгох хэрэгтэй. Энэ ч утгаараа бид 2024 онд виртуал хичээл бэлтгэхээр төлөвлөгөөнд тусгаж байна. Байгууллагад хамрагдах ёстой сургалт бол MNS ISO 9001:2016 сургалт буюу чанарын менежментийн тогтолцоо. Байгууллага бүр чанартай ажлыг хийж гүйцэтгэхээр зорилго болгодог. Тэгвэл энэ стандарт нь хэрхэн чанартай менежменттэй ажиллах зарчим гэж ойлгож болно.

► Ярилцсанд баярлалаа. Танд цаашдын ажилд нь амжилт хүсье.

2024 оны сургалтын календарчилсан төлөвлөгөө

Өдөр	I сар	II сар	III сар	IV сар	V сар	VI сар	VII сар	VIII сар	IX сар	X сар	XI сар	XII сар	Өдөр
1					Хэмжил зүйн суурь асуудлууд	Эх үрсийн баяр			Ням	Хэмжил зүйн суурь асуудлууд		Ням	1
2			Бямба	Хэмжил зүйн суурь асуудлууд		Ням					Монгол бахархал		2
3		Бямба	Ням					Бямба	MNS ISO 9001:2016		Ням		3
4		Ням			Бямба	Стандартчиллын суурь асуудлууд - M1		Ням					4
5			MNS ISO 19011:2020		Ням					Бямба	Стандартчиллын суурь асуудлууд - M1		5
6	Бямба	Лабораторийн шинжилгээний суурь асуудлууд онол, дадлага		Бямба				Бямба		Ням			6
7	Ням			Ням	Хэмжил зүйн мэргэшүүлэх сургалт ЦАХИЛГААН			Ням	Бямба			Бямба	7
8			Мартын 8			Бямба			Ням	Хэмжил зүйн мэргэшүүлэх сургалт		Ням	8
9			Бямба	Хэмжил зүйн мэргэшүүлэх сургалт МАСС							Бямба		9
10		Цагаан сар	Ням						MNS ISO 19011:2020		Ням		10
11		Цагаан сар			Бямба	Баталгаажуулалтын шинжээчийн эрх олгох сургалт M2, M3, M4	Наадам	Бямба					11
12		Цагаан сар	Хэмжил зүйн суурь асуудлууд		Ням		Наадам			Бямба			12
13	Бямба			Бямба			Наадам			Ням	Баталгаажуулалтын шинжээчийн эрх олгох сургалт M2, M3, M4		13
14	Ням	Стандартчиллын суурь асуудлууд - M1		Ням	Хэмжил зүйн мэргэшүүлэх сургалт Эзэлхүүн зарцуулалт ШТС		Наадам		Бямба	ДЭЛХИЙН СТАНДАРТЫН ӨДӨР		Бямба	14
15						Бямба	Наадам		Ням	Хүнсний үйлдвэрлэлийн зохистой асуудлууд		Ням	15
16			Бямба	Стандартчиллын суурь асуудлууд - M1						MNS ISO 22000:2018 НАССР	Бямба		16
17		Бямба	Ням					Бямба	Стандартчиллын суурь асуудлууд - M1		Ням		17
18		Ням			Бямба	MNS ISO 9001:2016		Ням					18
19			Хэмжил зүйн мэргэшүүлэх сургалт Эзэлхүүн зарцуулалт УСНЫ ТООЛУУР		Ням					Бямба	Лабораторийн шинжилгээний суурь асуудлууд онол, дадлага		19
20	Бямба	Баталгаажуулалтын шинжээчийн эрх олгох сургалт M2, M3, M4		Бямба		ДЭЛХИЙН ХЭМЖИЛ ЗҮЙН ӨДӨР	Бямба			Ням		Бямба	20
21	Ням			Ням	MNS ISO 17025:2018		Ням		Бямба			Ням	21
22										MNS ISO 9001:2016			22
23			Бямба	Баталгаажуулалтын шинжээчийн эрх олгох сургалт M2, M3, M4		Их дүчин өдөр					Бямба		23
24		Бямба	Ням					Бямба	Баталгаажуулалтын шинжээчийн эрх олгох сургалт M2, M3, M4		Ням		24
25		Ням			Бямба			Ням					25
26					Ням	MNS ISO 19011:2020				Бямба	Улс тунхагласан		26
27	Бямба		Хэмжил зүйн мэргэшүүлэх сургалт ДУЛААН ДАРАЛТ	Бямба				Бямба		Ням			27
28	Ням	MNS ISO 9001:2016		Ням	Хүнсний үйлдвэрлэлийн зохистой асуудлууд			Ням		Бямба		Бямба	28
29					MNS ISO 22000:2018 НАССР	Бямба			Ням	MNS ISO 19011:2020		Тусгаар тогтнол	29
30			Бямба			Ням					Бямба		30
31			Ням					Бямба					31



“Стандарт, хэмжил зүйн газрын 2024 оны сургалтын календарчилсан төлөвлөгөөнд тусгасан менежментийн тогтолцооны стандартын болон бусад тогтолцооны стандартын (MNS ISO 45001:2018, MNS ISO 14001:2016, MNS ISO 50001:2019) зэрэг сургалтыг ААНБ-ын албан хүсэлтээр захиалгаар зохион байгуулах боломжтой.

estandard.gov.mn

